

МОНГОЛ-ГЕРМАНЫ ХУДАЛДАА, ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦААНЫ ТҮҮХИЙН ЗАРИМ АСУУДЛУУД (1921-1938)

Сүлдэт Р.Төрдалай
(МУИС. Монгол Судлалын Төв)

1921 оны Үндэсний Ардчилсан хувьсгалаас өмнөх Монгол-Германы худалдааны харилцааны түүхэн тойм

“Тэнгэрийн” ба “Тэнгисийн” эзэнт гүрнүүдийн хоорондох түүхнээ “Хар тамхины” хэмээх тодотголтой үлдсэн 1839-1842 оны дайнд Манж Чин Улс ялагдал хүлээж улмаар Бээжин Британтанчуудын тулгасан тэгш бус гэрээг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй байдалтай тулгарснаар өмнөд мужийн далайд гарц бүхий Шанхай, Кантон зэрэг таван боомт хотыг Англи Улстай нээлттэй худалдаалах төвүүд болгон зарлаж, мөн Хонконгийг алдав. Энэхүү түүхэн үйл явдал нь олон зуун жилээр түжигдмэл, бие даасан шинжээ хадгалж байсан Манж Чин Улсын харъяан дахь Хятад, Монгол орнуудыг түүхэн хөдөлгөөнд оруулж чадсанаар үл барам нэн ялангуяа өрнөдийн хөгжингүй улс гүрнүүдийн зүгээс тус бүс нутаг руу хандах бодит сонирхлыг бий болгожээ. Дурдан буй үеэс эхлэн Герман Улс энэ бүс нутагт өөрийн нөлөөний хүрээг бий болгохыг эрмэлзэх болсон төдийгүй түүхий эд худалдан авч, оронд нь өөрийн бараа, бүтээгдэхүүнээ экспортлон гаргахыг чармайх болжээ.

Германы Эзэнт Улсын Засгийн газар 1861 оны IX сарын 2-ны өдөр Манж Чин Улстай байгуулсан гэрээгээр Монголд өөрийн худалдааны эрх ашгийг нэн тааламжтай нөхцлөөр тогтоож чадсан байна. Ийнхүү Германы худалдааны нөлөө Монгол оронд Манж Чин Улс өрнөдийн улсуудтай нээлттэй худалдаа хийх болсноос даруй 30 гаруй жилийн дараа 1870-иад оны дунд үеэс бодитойгоор бий болж эхлэв. Эхний үед Германы худалдаачид Их Хүрээнд өөрийн салбарыг хараахан нээгээгүй байсан учраас хятад худалдаачдаар дамжуулан Монголд бараа, бүтээгдэхүүнээ оруулж байв. Барууны худалдааны нөлөө Монголд бий болсноор монгол иргэд зөвхөн орос, хятадын барааг бус англи, герман, америкийн бараа бүтээгдэхүүнүүдээс сонголт хийх өргөн боломжтой болсноор энэ нь орос, хятадын худалдаа эрхлэгчидэд “нэгийг бодогдуулах” болжээ.

Энэ үеэс Монголчуудад Баруун Европын бараа таваар нэгэнт танил болж, цаашид Монголд байр суурь нь улам бэхжих үндэс суурь бүрэлдэж байв. Харин 1890-иэд он гэхэд герман худалдаачид Монголд нэгэнт бэхжиж чадсан нь Хаант Оросын улс төрийн зүтгэлтэн Петр Бадмаевын¹ бичсэн илтгэлээс тодорхой харагддаг. Тэрээр өгүүлэхдээ “...Их хүрээнд Азийн хувцас өмссөн англи, герман, франц, швед хүмүүс байна...”² гээд Хаант Засгийг Монголд идэвхтэй бодлого явуулах ёстойг тэмдэглэжээ.

Ийнхүү Монгол орон руу нэвтрэх гадаадын худалдааны урсгал тасралтгүй нэмэгдсээр ХХ зуун гарахад Монголд Европын хөгжингүй орнуудын томоохон хөрөнгө оруулалтаар байгуулагдсан пүүс, компаниуд нэгэнт бүрэлдэн бий болсон байлаа. Үүнд Түшээт хан ба Сэцэн хан аймгийн нутагт байгуулагдсан хувь нийлүүлсэн “Монголор” алтны компаниг нэрлэж болох юм. “Монголор” нь 1900 онд байгуулагдан Ерөөгийн алтны уурхайг малтан ашиглаж байжээ.

“Монголор”-т хувь нийлүүлж байсан олон улсын байгууллагууд дотор Герман Улсын Мендельсон & Ко (*Mendelson & Co.*) хэмээх пүүс байжээ. Энэ пүүсийн төв нь Берлин хотод байжээ. 1912 онд “Монголор”-оос олборлосон 1 354 222 рублийн үнэ бүхий алтыг Хаант Оросоор дамжуулан Берлин, Амстердамд гаргаж худалдаж байсан мэдээ байна. Түүнчлэн 1904 оноос Стукен (*Stuken*) 1909 оноос Бидерман (*Biedermann*), Якоб Зергаген (*Jakob Zerhagen*)-ны зэрэг пүүсүүд Монголд үйл ажиллагаа явуулах болжээ. Ялангуяа Стукен (*Stuken*), Якоб Зергаген (*Jakob Zerhagen*)-ны пүүсүүд жил бүр тус тус 100 мянган пүү³ ноос худалдан авч Герман, Англи, АНУ-д тээвэрлэн гаргаж байв.²

Дээрхи баримтуудаас үзвэл дурьдан буй үед орос худалдаачид Монголд Германы зарим пүүсүүдийн эрх ашгийг төлөөлөн худалдаа

¹ Петр Бадмаев – Хаант оросын улс төрийн зүтгэлтэн, дорно дахин судлаач. Хаант Орос Улсын Гадаад Явдлын яамны Азийн хэлтсийн түшмэл, Петербургийн Их Сургуулийн багш, III Александр хааны шадар зөвлөгч зэрэг алба хашиж явжээ. Тэрээр Хятад, Монгол, Төвдийг Хаант Орос Улсын хил хязгаарт багтаан нэгтгэх төлөвлөгөөг боловсруулж 1893 онд III Александр хаанд айлтгаж байжээ.

¹ Ш.Сандаг, Монголын улс төрийн гадаад харилцаа (1850-1919), vol. II, Улаанбаатар, 1971, 135-р тал.

² Пүү - 16, 3 киллограммтай тэнцэх хэмжээ.

² Ш.Сандаг, Монголын улс төрийн гадаад харилцаа (1850-1919), vol. II, Улаанбаатар, 1971, 160-р тал.

эрхэлж байсан нь элбэг тхоиолдол байжээ. Жишээ нь Ховд хотноо Германы Гутбецаль (*Gutbezahler*), Бидерман (*Biedermann*)-ы пүүсүүдийн төлөөлөгчөөр Хаант Оросын харъяат Степанов, Калмынин нар ажиллаж төрөл бүрийн ангийн үс (*марвага, үнэг, чоно, хэрэм, шилүүс гэх мэт*) худалдан авч Лейпцигийн зах зээл рүү гаргаж байлаа.³ Ерөнхийдөө Монгол дахь Германы пүүсүүдийн голлон эрхэлдэг худалдаа нь ангийн үс, ноосны арилжаа байсан ба ноос, ангийн үсийг Хаалган, Тэньжин руу машинаар тээвэрлэн аваачиж, улмаар цааш Лайпциг, Гамбург хотууд руу далайгаар тээвэрлэн их хэмжээгээр гаргадаг байжээ.⁴ Лайпциг, Берлин хот дахь Монголоос түүхий эд гатаж авдаг гол түнш газрууд нь Ф. Меркер & Н. Герценштейн (*F. Merker & N. Herzenstein*), Дармштадтын Зиммермахер & Виганд (*Simmermacher & Wiegand*), Берлины Август Блюменталь & Август (*August Blumenthal & August*), Геннеберок (*Hennebrock*), Вальтер & Ко (*Walther & Co*) зэрэг пүүсүүд болно. Иймээс Монголд түүхий эдийн ханш ямар байх нь Лондон, Лайпцигт мөнгөний ханш буурах, өсөхөд зохих хэмжээгээр нөлөөлөх хандлага байсан байна.⁵

Монгол оронд Европын орнуудын худалдаа хурдацтайгаар өсөн нэмэгдэж байсны гол шалтгаан нь бараа бүтээгдэхүүний нь чанар, эдэлгээ сайн, хийц хэлбэр гоёмсог, дөт усан замаар их хэмжээгээр тээвэрлэх боломжтой учир үнэ харьцангуй хямд, түүнээс гадна тухайн үед Орос, Хятадын худалдаачидад итгэх итгэл Монголчуудын дунд суларч эхлэсэн зэрэгтэй холбоотой байсан бололтой.

Иймээс энэхүү түүхэн нөхцлийг ашиглаж герман худалдаачид өөрийн орны өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг (цаг, ётон, гоёл чимэглэлийн зүйлс гэх мэт) Монголын зах зээлд нэгэнт танил болгож амжсан байна.

Тухайн үед, ер хожим ч XX зууны Монгол Улс дахь нийгмийн аливаа үйл явцыг Берлины зүгээс Орос, Хятадаас салгаж авч үзэж байсангүй ба энэ нь ч зайлшгүй зүйл байсан болов уу? Германы “*Франкфуртер Цайтунг*” (*Frankfurter Zeitung*), “*Дэр Остасиатише Ллойд*” (*Der Ostasiatische Lloyd*) зэрэг сонинуудад тухайн үеийн Монгол орны улс төрийн байдал ба үүнд Орос, Хятадын оролцоо хэрхэн явагдаж байгаа зэрэг асуудалд байнга анхаарлаа хандуулж байжээ.

³ Мөн тэнд, 163-р тал.

⁴ БНМАУ-ын түүх (1604-1917), 2-р боть, Улаанбаатар, 266-р тал.

⁵ Мөн тэнд, 179-р тал.

Гэвч энэ үеийн Монгол-Германы худалдааны харилцаа нь тун явцуу шинжтэй байсан бөгөөд Германы бизнесменүүд Монгол орноос хямд үнээр түүхий эд гаргах зорилгоор зөвхөн нэг талаас хандсан сонирхлын үүднээс харилцаа тогтоож байжээ. Харин Монголчууд тухайн үед идэвхгүй хэрэглэгчийн байдалтай байсан нь Манж Чин Улсын харъяанд хоёрдагч талтай бие даан худалдааны ямар нэгэн харилцаа тогтоох бололцоо байгаагүйтэй холбоотой хэрэг.

Энд нэг зүйлийг нэмж хэлэхэд манай өнгөрсөн түүх бичлэгт тун түгээмэл ажиглагддаг нэг зүйл бол тухайн үед Европын орнуудын (*жишээ нь Герман Улс*) зүгээс Монгол орны байгалын баялагыг талан эзэмшиж, өөрийн бараа таваар борлуулах уужим зах зээл болгон ашиглах, улс төрийн зорилгоор стратегийн түшиц газар болгох зорилго бүхий бодлого баримталж байсан мэтээр бичсэн, дүгнэсэн зүйл багагүй байх ба миний бодоход юутай ч Герман Улсын зүгээс Монголд хандах хандлага тийм хэмжээнд хүрч байсангүй бөгөөд 1) Тухайн үед Монгол оронд томоохон хөрөнгө оруулалт хийх эдийн засгийн бодит нөхцөл бүрэлдэн бий болоогүй байсан. 2) Монгол орон бараа бүтээгдэхүүн борлуулах зах зээлийн хувьд туйлын хумигдмал байсан. 3) Манж Чин Улс ба бас Монголын байдал олон талаараа ихээхэн тогтворгүй байсан тул томоохон хэмжээнд худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоох нь эрсдэлтэй байсан, мөн хариуцлага тооцох механизм ч тун хангалтгүй байсан ажээ. Иймээс энэ талаар бидэнд эргэн харах зүйл багагүй байна.

XIX зууны сүүлч XX зууны эхэн үе болж ирэхэд Манж Чин Улсад нийгмийн байдал ихээхэн тогтворгүй болж ард түмний амьдралын доройтол газар авч бослого хөдөлгөөн тасралтгүй үргэлжлэх болжээ. Энэ байдал Монгол оронд ч гүнзгий тусч улс орныхоо төрийн тусгаар тогтнолыг сэргээн мандуулах үзэл санаа үндэсний хэмжээний асуудал болон босож иржээ. Манжийн төр улс орноо бүрэн хэмжээгээр хянаж чадахаа больж ард түмнээ зэвсгийн хүчээр тогтоон барих замд шилжив. Ард түмний дургүйцэл хүчтэй газар авсан энэ үед Манж Чин Улс “Шинэ засгийн бодлого”-ыг явуулж эхэлсэн бөгөөд энэ нь 1911 онд Монголчуудыг үндсээ чөлөөлөх тэмцэлд босгосноор Монголчууд 220 орчим жилийн дараа улс орныхоо тусгаар тогтнолыг сэргээн тунхаглаж чаджээ.

Шинэ тулгар Богд хаант Монгол Улсын гадаад бодлогыг тэргүүн зорилт нь Ар, Өвөр Монголыг нэгтгэх, хоёр хөрш улсаар хүлээн

зөвшөөрүүлэх, мөн өрнөдийн хөгжингүй орнуудтай харилцаа холбоог тогтоож, тусгаар тогтнолоо олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрүүлэх бодлого байв. Энэ үүднээс 1912 онд Хаант Улсын Засгийн газраас өөрийн улсын тусгаар тогтнолыг зарлан тунхагласнаа мэдэгдэж дэлхийн олон улсад гэрээ байгуулан худалдааны харилцаа тогтоох, найрамдлыг зузаатгах зорилгоор нот бичиг явуулсан⁶ ба энд Дэ (Энэ нь герман гэсэн хятад ханзны дуудлага юм) улс чухал байр суурийг эзэлж байсан нь эргэлзээгүй билээ. Мөн Ерөнхий сайд Намнансүрэн 1913-1914 онд Хаант Оросод очих үедээ тус улс дахь Герман Улсын элчин сайдад дээрхи асуудлаар дахин нот бичиг явуулсан боловч бодитой ямар ч хариу авч чадаагүй байна.⁷ Герман Улс нь бусад улсын адил дээрхи нот бичигт хариу ирүүлээгүй бөгөөд Намнансүрэн сайдын дээрхи дипломат алхам түүний бодсончлон амжилт олсонгүй.

1913 онд Хаант Орос-Хятадын хооронд Монголын асуудлаар гаргасан тунхаг бичиг нь Германы худалдаа аж үйлдвэрийн бүлгийнхний төдийгүй Европын бусад улсуудын анхаарлыг зүй ёсоор энэ зүгт хандуулахад хүргэв. Энэ асуудлаар Германы Үндэсний либерал намын удирдагч фон Бассерман (*von Wassermann*) Рейхстагт хандсан бөгөөд тэрээр 1861 онд Манж Чин улстай байгуулсан гэрээнд заасанчлан Германы Эзэнт Улсын Монгол дахь худалдааны эрх ашигт энэхүү тунхаг нөлөөлж байгаа эсэхийг лавласан байна. Фон Бассерман (*von Wassermann*)-ы дэвшүүлсэн асуудлын хариуд Гадаад Хэргийн төрийн нарийн бичгийн дарга фон Ягов (*von Jagow*) -оос "...Гадаад Монгол дахь Хятадын сюзеренитет эрхийг Орос, Хятадын сүүлчийн хэлэлцээрт заасан шиг тодорхой зөвшөөрөн хүлээгээгүй байгаа ч 1861 оны IX сарын 2-ны өдөр Германтай байгуулсан худалдааны гэрээ ба түүний дотор тогтоосон нэн тааламжтай нөхцлийн эрх нь хүчин төгөлдөр хэвээр байна"⁸ гэсэн хариуг өгсөн байна.

Энэ үед Герман Улсаас Монгол дахь Хаант Орос Улсын худалдааны нөлөөг сулруулахын тулд Хятадын худалдааг дэлгэрүүлэхэд дэмжлэг

⁶ Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл. Баримт бичгийн эмхэтгэл (1900-1914), Улаанбаатар, 1982, 61-р тал.

⁷ В.Котвичийн хувийн архиваас олдсон Монголын түүхэнд холбогдох зарим бичиг, Улаанбаатар, 1972, 282-р тал.

⁸ Д. Уламбаяр, *Монгол-Германы түрүү үеийн харилцаа, Олон улс судлал* сэтгүүл, Улаанбаатар, 1 (2001), 79-р тал.

үзүүлэх явдлыг чухалчилж байсан ба Хятадын нэрээр өөрийн банкыг Хүрээнд нээх тухай асуудал ч яригдаж байгааг 1914 оны IV сард Хаант Орос Улсын Сайд нарын танхимийн дарга Горемыкинээс Гадаад Хэргийн яамны сайд С. Д. Сазановт илгээсэн захидалдаа дурьджээ.⁹

Эндээс харахад Германы худалдааны нөлөө XX зууны эхэн үед Монголд идэвхжиж байсныг тодорхой мэдэж болох бөгөөд Орос болон Европын бусад улсуудтай амжилттай өрсөлдөж байжээ. Гэвч энэ үеийн Монгол-Германы хоорондох худалдааны түүхэн тоймыг нэхэн харвал 1) Герман Улс манай орноос түүхий эд гадаадад гаргахад голлон анхаарлаа хандуулж байсан, 2) Монгол иргэд Германы худалдааны пүүсүүдэд түүхий эдээ өгч оронд нь өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн худалдан авч байснаас үзвэл энэхүү харилцаанд худалдааны шинж давамгайлж байсныг илтгэнэ.

Гэвч энэхүү худалдааны харилцаа нь хоёр орны иргэдийн дунд бие биеэндээ итгэлцэл, ойлголцлыг бий болгож ойртон харилцах, хожмын илүү өндөр түвшний найрсаг харилцаа бүрэлдэн буй болох бодитой хөрс суурь болж өгчээ.

Монгол - Германы худалдаа, эдийн засгийн харилцаа тогтох улс төр, эдийн засгийн түүхэн нөхцөл бүрэлдсэн нь

Дэлхийн I дайн дуусаж Версалын эрин үе эхлэснээр дэлхийн газрын зурагт ихээхэн өөрчлөлт гарав. Олон улсын харилцаанд зонхилох үүрэг гүйцэтгэж байсан Герман, Австри-Унгар, Оттоман Турк, Хаант Орос зэрэг хүчирхэг дөрвөн гүрэн газрын зургаас арчигджээ. Эдгээр эзэнт улсуудын суурин дээр олон жижиг үндэсний төрт улсууд үүсэн байгуулагдаж Версалын энх тайвны гэрээгээр (1919) дайнд ялагдсан улсуудын эзэмшил газар нутаг, колоньг дахин шинээр хувиарлах, таслан салгах, хэсэглэн хуваахын төлөөх тэмцэл Европын Англи, Франц зэрэг гүрнүүдийн идэвхтэй оролцоотойгоор явагдав.

Дайнд ялсан Англи, ялангуяа Франц Улс Герман Улсыг улс төр, эдийн засгийн хүнд шахалтанд байлгах бодлого барьж байсан бол Европт большевизмын нөлөөг дэлгэрэхээс болгоомжлох үүднээс Зөвлөлт Орос Улсыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж байлаа. Иймээс Герман ба Зөвлөлт Орос улсууд энэ үед олон улсын тавцанд эзлэх хүчтэй байр суурь, нөлөөтэй байж чадсангүй. Иймээс дурьдан буй үеийн Зөвлөлт Орос ба Германы гадаад бодлогод адил төсөөтэй

⁹ Мөн тэнд, 80-р тал.

түүхэн нөхцөл байсан юм. 1919-1923 он хүртэл Зөвлөлт Орос Улс Германд хувьсгал хийх боломжийг судалж Антантаас тулгасан дайны өрийг төлөхгүй байхыг Германчуудаас уриалах зэргээр суртал ухуулгын шинжтэй гадаад бодлого явуулж байлаа. Зөвлөлт Засгийн газар Герман Улсыг Европ дахь өөрийн далд холбоотон болгох зорилго агуулж байсан ба Германд ч Зөвлөлт засгийг талархагчид цөөнгүй байжээ. Учир нь тухайн үед Герман Улсад Төв, Ардчилсан намуудаас илүү Социал-Демократ нам улс төрийн хамгийн нөлөөтэй хүчин байсан тул зүүний бодлого баримталдаг улс төрчид засгийн эрхэнд цөөнгүй байжээ.¹⁰

Энэ нь ЗХУ Герман Улстай харилцахад дөхөмтэй байсан бололтой. Гэвч Германд большевикуудын төлөвлөж байсан шиг ямар ч хувьсгал гарсангүйгээр барахгүй Герман Улс харин ч улам бүр бие даасан шинжтэй гадаад бодлого явуулж амжилт олж эхлэв. 1924 оны XII сард тус улсад явагдсан сонгуулийн үр дүнд 1925 оны I сарын 15-нд Лютерийн Засгийн газар байгуулагдсан байна.¹¹ Лютерийн Засгийн газар нь улсын дотоод дахь өөрийн байр суурийг бататгахад чиглэгдсэн үйл ажиллагааг явуулсанахаа дараа гадаад бодлогоо сэргээн идэвхжүүлэх чиг шугамыг баримтлах болжээ.

Дэлхийн I дайны дараахи үеэс эрс суларсан Герман Улсын гадаад бодлого идэвхжсэнээр Алс Дорнод дахь өөрийн алдсан байр суурийг эргэн сэргээхийг чухалчлах болсон байна. Оросын 1917 оны хувьсгалын нөлөөгөөр Азийн олон улсууд үндэсний тусгаар тогтнолоо сэргээн тогтоож чадсан юм. Алс Дорно зүгт өөрийн нөлөөний хүрээг сэргээн тогтооход чиглэгдсэн Германы улс төрчдийн сонирхол нь тэдгээр орнуудтай улс төр, худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоох явдалд үндэслэх болжээ. 1923 оноос Зөвлөлт Орос Улс Ази, Европ дахь шинээр тусгаар тогтносон хувьсгалт улсуудад хандсан бодлогоо мөн идэвхжүүлэх болсноор Герман Улсын Азид чиглэсэн оролцоонд Зөвлөлт Орос Улс ихээхэн нөлөөтэй болохыг анхаарах болов. Энэ үүднээс Москва дахь Герман Улсын элчин сайд фон Брокдорф-Ранцау, Барон Мальцман зэрэг Герман Улсын улс төрчид өөрийн

¹⁰ ХХ зууны Дэлхийн түүх, Улаанбаатар, 2001, 140-р тал.

¹¹ Лосол, 1924-1939 оны Герман Улс, Улаанбаатар, 1948, 11-р тал.

Энэ үед Герман Улс нь Зөвлөлтийн нутгаар дамжин нэвтэрч, Азийн улсуудтай харилцаагаа шинээр болон сэргээн тогтоох асуудлаар байнгын эрх олж авах бодлого баримталж гэрээ, хэлэлцээр байгуулж байжээ. Уг бодлогын хүрээнд Монгол Улсыг багтаах чиглэлтэй байсан болов уу?

улсын улс төрийн байр суурийг Антантын эвслээс илүү бататгахын тулд ЗХУ-тай найрамдалт харилцааг хөгжүүлэх чиглэлийг тууштай баримтлахыг оролдож байжээ.

Герман Улс гадаад бодлогодоо идэвхжүүлж эхэлсэн тэр үед Монгол оронд 1921 оны Үндэсний Ардчилсан хувьсгал ялж, шинэ тулгар Монгол Улс тусгаар тогтнолоо зарлан тунхагласан явдал нь манай орны нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын хүрээнд гүнзгий өөрчлөлт, шинэчлэлт гарах түүхэн үндэс суурийг бүрдүүлэв. Энэхүү нөхцөл байдал нь тухай үеийн нам, төрийн удирдлагад улс орныхоо үндэсний эрх, ашгийг дээдэлсэн, хэтийн зорилготой, олон түшигт гадаад бодлого шуулах түүхэн боломж олгосон юм.

Иймээс, тухайн үед Монгол Улсын Ардын Засгийн газрын гадаад бодлогын эн тэргүүний зорилт нь төрийн тусгаар тогтнолоо Зөвлөлийн Засагт Орос Улсаас гадна өрнө дахины улс гүрнүүдээр хүлээн зөвшөөрүүлж, баталгаажуулах явдал байв. 1921 оны IX сарын 14-ний өдөр Ардын Засгийн газраас *“Монгол Улсыг тусгаар тогтносон тухай гадаад олон улсуудад тунхагласан бичиг”*-ийг дэлхийн олон улс, гүрэнд зарлан илгээсэн байна.¹²

Энэхүү тунхаг бичгийг зарлан илгээсэн явдал нь Монгол Улсын нам, төрөөс баримталж байсан гадаад бодлогын үндсэн чиглэл нь ЗОУ-наас гадна нийгмийн байгуулал, үзэл суртлын ялгаварлалыг үл харгалзан Герман, Франц зэрэг орнуудтай худалдаа, эдийн засаг, соёлын харилцааг тогтоон хөгжүүлэх, цаашилбал Монгол Улсын тусгаар тогтнолыг албан ёсоор хүлээн зөвшөөрүүлж, төрийн гадаад харилцаа тогтоохыг зорьж байсантай холбоотой юм. 1921 оны Үндэсний Ардчилсан хувьсгалын дараагаар Монгол Улсад бий болсон энэ нөхцөл байдал нь өрнө дахины орнууд, ялангуяа Герман Улсын худалдаа, эдийн засгийн ашиг сонирхол Монгол Улсад хүчтэй болоход нөлөөлсөн байна.

Дурдан буй үеийн нам, төрийн удирдагчид гадаад худалдаа, эдийн засгийн бодлогын үзэл баримтлалын хувьд олон түшигт байдалд үндэслэсэн, аль нэг их гүрний нөлөөнд хүчтэй орохоос зайлсхийж, гадаад түншлэлийн хоёрдагч талыг хайж байсан төдийгүй ЗХУ, Хятадын Монгол Улс дахь нөлөөг Герман зэрэг өрнө дахины хөгжингүй

¹² Монгол Ардын Бүгд Найрамдах Засаг тогтоон явуулсан нь, Улаанбаатар 1971, 8-р тал.

орнуудтай олон түшигт худалдаа, эдийн засгийн харилцааг хөгжүүлэх замаар тэнцвэржүүлэхэд чиглэгдсэн бодлого баримталж байсан юм. Иймээс энэ үеэс Герман Улстай худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоох асуудал манай улсын гадаад бодлогын үндсэн чиглэл болжээ. Улмаар 1921 оноос эхлэн Монгол Улс барууны орнуудын эрх зүйн тогтолцоог баримжаалах бодлого явуулж эхлэв.

Ардын Засгийн газраас 1922 оны V сарын 12-ны өдөр *“Хууль цаазыг зохиох тухай”* 21-р тогтоолыг гаргаж *“... Манай улс ардын эрхэт хэмжээт цаазат засгийг явуулж бүхий боловч үндсэн хууль зүйлийг тогтоон гүйцэтгээгүй нь аливаа хэргийг шийтгэж явуулахад их л дутагдалтай газар буй болой”*¹³ гэж зааснаар Европын улсуудын үндсэн хуулиудыг харгалзах шийдвэр гаргасан байна.

Дээрхи шийдвэрт үндэслэн 1922 оноос эхлэн Монгол Улсын тухайн үеийн эрдэмтэд, улс төрчид хамтран Австри, Герман зэрэг барууны орнуудын эрх зүйн тогтолцоог баримжаалан Үндсэн хуулиудыг нь орчуулан судалж байв.¹⁴

Ялангуяа Германы Ваймарын Бүгд Найрамдах Улсын Үндсэн хуулийг монгол хэлнээ орчуулж судлан шинжилсэн явдал нь Монгол Улс Ром-Германы эрх зүйн тогтолцоог баримжаалахыг эрмэлзэж байсны түүхэн нотлогоо болно.

1924 оны XI сарын 26-нд Монгол Улсыг тунхаглаж, Анхдугаар Үндсэн хуулиа баталсан түүхт явдал нь Монгол Улсын нийгмийн бүхий л хүрээнд цаашилбал худалдаа, эдийн засгийн салбарт дэвшилтэт үйл явц болсон юм. Анхдугаар Үндсэн хуулийн 14-р зүйлийн хавсралтад *“Мөн цагийн байдлыг хянаж ямар ч гадаад улстай харилцан найрамдах болох”*¹⁵ гэж заасан нь худалдаа, эдийн засгийн чиглэлд гадаадын улс орнуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг өрнүүлэн

¹³ БНМАУ-ын Үндсэн хууль, түүнд холбогдох зарим актын эмхтгэл (1921-1940), I боть, Улаанбаатар, 1972, 54-р тал.

¹⁴ Б. Чимэд, Зохистой тогтолцоог баримжаалах нь эрх зүйн шинэтгэлийг үр нөлөөтэй хийх үндэс болох нь, “Эрх зүйн шинэтгэл ба үндэсний эрх зүйн тогтолцоо” сэдэвт Олон Улсын симпозиумын баримт материал, Улаанбаатар, 2000, 23-р тал.

¹⁵ Монгол Ардын Бүгд Найрамдах Засаг тогтоон явуулсан нь, Улаанбаатар, 1971, 166-р тал.

хөгжүүлэхэд чиглэгдсэн зорилтуудыг хууль, эрх зүйн талаар баталгаажуулсан хэрэг байв.

Улмаар 1926-1929 онуудад энэ хүрээнд иргэний хууль, эрүүгийн хууль, аливаа хэргийг байцаан шийтгэх хууль зэрэг төрөлжсөн бусад хуулиудыг ч батлан гаргаж мөрдөж байжээ.¹⁶

Гэвч хожим 1932 онд хуралдсан МАХН-ын ТХХБТК-ын хавсарсан онц III бүгд хурал, Улсын XVII бага хурлаас *"1930-иад он хүртэлх Монгол Улсын хууль дүрэм нь хөрөнгөлөг ёсыг баримтласны тул нийгэм журмын ёсонд нийцүүлэн өөрчлөх тухай"* шийдвэр гаргах хүртэл дээрхи хуулиудыг даган мөрдсөөр байжээ.¹⁷

Европын орнуудтай гадаад харилцаа тогтоох талаар хүчин чармайлт гаргаж тэдгээр орнуудын Үндсэн хууль, бусад холбогдох хууль тогтоомжийг нарийвчлан судалж байсан явдал нь Монгол-Герман хооронд худалдаа, эдийн засгийн өргөн харилцаа тогтох хууль, эрх зүйн таатай орчин нөхцлийг бий болгосон байна.

1923 оны VII сарын 24-нд тусгай комиссын боловсруулан нийтэлсэн *"Эдийн засгийн үндсэн бодлого"* хэмээх бодлогын шинж чанартай бичиг нь дээрх үзэл баримтлалыг баталж байна. Тэрхүү баримт бичгийн 17-р зүйлд *"...Орос, хятад, рибин (Япон улс), америк, англи, герман зэргийн олон их, бага улс дотроос зарим нь эзэрхэг, шунахай бөгөөд бага буурайг дарламтгай ба залгимтгай, зарим нь хурц эрдэмтэй, бүдүүлэг байх мэт чанар дүрс адилгүй учраас зүй нь харилцан худалдаа, ашиг, эрдэм соёлын тухай гэрээ болзоо тогтоон нэвтрэлцэхэд хүрвэл эрх биш хэдэн давхар эргэцүүлэн хянаж тогтоовол зохино. Герман, Англи, Орос, Америк, Хятад, Рибин хэмээн шилж сонгоход хүрвэл аль ч талаар Герман, Орос, Америк хэмээх мэтээр дэс дарааллан орно заа."*¹⁸ гэж заасан юм.

Өнгөрсөн түүхийг нэхэн ажваас 81 жилийн тэртээ мөрдөж байсан *"Эдийн засгийн үндсэн бодлого"*-д зааснаас үзвэл тухайн үед манай улс худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоож болох хамгийн

¹⁶ Мөн тэнд, дурдсан талд

¹⁷ БНМАУ-ын түүх (Нэн шинэ үе), vol. III, Б, Улаанбаатар, 1969, 312-р тал.

¹⁸ Монгол Ардын намын хоёрдугаар их хурал (Баримт бичгүүд), Улаанбаатар, 1974, 139-140-р тал.

итгэмжтэй орнуудын тоонд Зөвлөлт Орос, АНУ-аас илүүтэйгээр Герман Улсыг чухалчлан үзэх хандлага бүрэлдэж байжээ гэсэн сэтгэгдэл төрж байна.

Энэ баримт бичгийг 1923 оны VIII сард хуралдсан МАН-ын II Их хурлаас намын программд нэмэн өргөтгөж баталсан 9-р зүйлтэй адил сацуугаар улс төрийн ба намын хэрэгт удирдлага болговол зохино гэж зааснаар дээрх асуудал төрийн бодлогын хэмжээнд тавигдах болжээ.¹⁹ Дээрх бодлогын шинж чанартай баримт бичиг /1923/ цаасан дээр тунхаглал болж үлдсэнгүй бөгөөд дурьдан буй үеэс амьдралд бодитой хэрэгжиж эхэлсэн юм.

1924 оны VIII сарын 5-нд хуралдсан МАН-ын III их хурлын 2-р хуралдаан дээр Намын Төв хорооны гишүүн Элбэгдорж Ринчино Герман Улстай худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоох асуудлын тухай хөндсөн байдаг.

Тэрбээр хэлэхдээ: *“Улс төрийн бодлогод холбогдолгүй худалдаа, эдийн засгийн их олон асуудал байна. Хэрэв манай эрх ашигтай нийлэмжтэй бол бид энэ талаар аль ч улстай харилцаа тогтооход бэлхэн байна. ... Бас Герман Улс худалдааныхаа төлөөлөгчдийг манайд ирүүлж, манайхыг төлөөлөгчдөө ирүүлнэ үү гэж урьсан зүйл буй тул Германтай албан ёсны харилцах нь тун их ашигтай бөгөөд тэднээс нарийн оньсон хүрдний зэрэг зүйлийг авч болно. Манайд дадлага бүхий боловсон хүн дутагдаж байгаа учраас Германд төлөөлөгчид явуулах, ер нь дурьдсан улсуудтай харилцаа тогтоох явдал саатаж байна. Манай дотоод байдал сайжрахын хамт бид гадаад харилцааны ажил хийх болно”²⁰* гэжээ.

Энд тэмдэглэхэд Монгол Улсаас дурьдан буй үед баримталж байсан гадаад бодлогын (худалдаа, эдийн засаг, соёл боловсрол гэх мэт нийгмийн бүх салбар дахь) үндсэн үзэл баримтлал нь ашигтай бол нийгмийн байгуулал үзэл суртлын ялгааг үл харгалзан ямар ч улстай харилцаа тогтоохыг дэмжиж байсан явдал юм. Өөрөөр хэлбэл энэ нь дээр Элбэгдорж Ринчиногийн *“улс төрийн бодлогод холбогдолгүй*

¹⁹ Б.Лхамсүрэн, Из истории внешних сношений Монгольской Народной Республики (1921-1945), Современная Монголия, 1957, № 5-6, с. 24.

²⁰ Монгол Ардын намын гуравдугаар их хурал (Дэлгэрэнгүй тэмдэглэл), Улаанбаатар, 1966, 31-р тал.

худалдаа, эдийн засгийн их олон асуудлууд байна” хэмээн өгүүлсэнчлэн албан ёсны харилцаанаас гадуур яригдаж байсан дан ганц худалдаа, эдийн засгийн асуудлууд байжээ. Иймээс албан ёсны харилцаагүй байсан улсуудтай ч худалдаа, эдийн засгийн харилцаа холбоо тогтоох сонирхол байжээ. Харин Герман Улстай албан ёсны түвшинд харьцангуй өргөн харилцаа тогтоохыг ихэд чухалчилж байсан ба хоёр улсын худалдааны төлөөлөгчдийг Берлин-Нийслэл Хүрээнд харилцан суулгах тухай асуудал хоёр талын харилцан санаачлагаар тавигдах болжээ.

Энэ үед МАН-ын III их хурлаас Гадаад яамны илтгэлийг сонсоод гаргасан тогтоолын 1-р зүйлд дурьдахдаа *“Гадаадын олон улсын дотроос харилцан найрамдаж, нэвтрэлцвэл зохих улсууд лугаа бидний Монгол Улс харилцан найрамдаж, улс төр ба ард түмний тус бүхий хэргийг нэвтрэлцвэл зохино”*²¹ гэж заасан нь гадаад бодлогын дээрхи үндсэн үзэл баримтлалыг батлагаажуулсан хэрэг болов. МАН-ын III их хурлын дээрх шийдвэр нь манай улсаас гадаад улсуудтай худалдаа, эдийн засаг, соёл, боловсролын харилцаа тогтоохыг гол болгож байсныг тодорхой харуулж байгаа төдийгүй Герман Улстай худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоох чиглэлд ч дээрх шийдвэр нь цаг үеэ олсон чухал ач холбогдолтой байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Гэвч дурьдан буй үед манай улсын гадаад, дотоод байдал нэн тогтворгүй байснаар үл барам МАХН-ын III их хурал хуралдаж байх үед буюу 1924 оны VIII сарын 11-нд КИГХ-ны тэргүүлэгчдээс *Монголын асуудлаар гаргасан тогтоол*-д МАН-ын дотор *“Барууны урсгал, баруун жигүүр”* байгаа тухай анх удаа дурьдсан байна.²²

Дээрх тогтоолд МАН-ын өмнө тулгамдаад байгаа зорилтуудыг тодорхойлж *“...Тус нам баруун жигүүрийнхний хувьсгалын эсрэг, намын эсрэг үүргийг намын олон түмний өмнө илчилж, намын удирдах байгууллагыг барууны нөлөөнөөс сэргийлэн, тэдгээр байгууллагыг төрийн байгууллагыг удирдах жинхэнэ хувьсгалт төв болгон хувиргах хэрэгтэй”*²³ гэж заасан байна.

²¹ Мөн тэнд, 222-р тал.

²² Коминтерн ба Монгол (Баримтын эмхтгэл), Улаанбаатар, 1996, 65-р тал.

²³ Мөн тэнд, 75-р тал.

Ийнхүү үндэсний эрх ашгаа дээдэлсэн манай тэргүүний удирдагч, сэхээтнүүдийг баруунтан хэмээн буруутгах болж, КИГХ-ноос хувьсгалт үзэл санаагаар төлөвшиж хүмүүжсэн залуусыг дэмжих замаар МАН-ыг төрийн удирдлагын удирдах жинхэнэ төв болгон хувиргаж, барууны хэлбэрлийг даруй арилгаж, нам дотор цэвэрлэгээ явуулах асуудлыг удаа дараа хөндөн тавих болжээ. Коминтернээс тухайн үед Монголын талаар баримталж байсан бодлогыг харуулсан нэгэн сонирхолтой жишээ бол *"МАН, Засгийн газар Залуучуудын эвлэлийн байдал ба КИГХ-ны төлөөлөгчийн баримтлах бодлогын тухай"* Р.Т.Рыскуловаас Мануильский, Войтинский нарт 1924 оны XI сарын 2-нд Нийслэл Хүрээнээс явуулсан илтгэлийн *"Цэрэндоржийн бүлгийн тухай"* гэсэн хэсэг юм.

Энд дурдахдаа *"Цэрэндоржийн бүлгийг халхавч болгон засгийн эрхэнд байлгаж байх ёстой бөгөөд тэгэхдээ ард түмний дотор байгаа тэр бүлгийн доод бааз суурийг нь аажмаар салган авч залуучуудаар бэхжүүлвэл зохино ... Хэрэв үүнтэй нэгэн зэрэг МАН-ын залуу жигүүр бэхжих юм бол энэ бүлэг бидний гарт орох болно"*²⁴ гэжээ.

Ийнхүү МАН-ын III их хурлын үеэр Бүх цэргийн жанжин С. Данзан, Засгийн газрын нарийн бичгийн дарга Баваасан нарыг намын чиг шугамыг эсэргүүцсэн гэх нэрийдлээр ял тулган шийтгэсэн явдал нь Монгол Улсын дотоод байдал тогтворгүйтэж, удирдлагуудын хүрээнд гүнзгий ан цав нэгэнт бий болсныг илтгэнэ. Гадаад бодлогын хувьд дээрхи тогтсон үзэл баримтлал байсан боловч намын доторхи үзэл баримтлалын зөрчилдөөнт байдал нь Герман зэрэг гадаад улсуудтай харилцахад гол бэрхшээлийг учруулж байжээ. Учир нь манай талаас уг асуудлаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж чадахгүй байсаар байжээ.

Түүнчлэн 1924 оноос Зөвлөлт Орос улс, Коминтерний зүгээс манай улсын дотоод хэрэгт хутгалдан оролцох явдал хүчтэй болж ирсэн юм. Ялангуяа МАХН-ын Намын Төв Хороо, Ардын Засгийн газраас Герман, Франц улстай холбоо тогтоох чиглэлийг баримтлах болсон нь ЗХУ, Коминтерний бодлого, үйл ажиллагаатай илэрхий зөрчилдөх болсон байна.

²⁴ Мөн тэнд, 83-р тал.

^{*} Намын чиг шугамыг эсэргүүцсэн гэхээс илүү Монгол Улсыг цаашид хэрхэн, ямар замаар хөгжүүлэх тухай үзэл баримтлалын эрс тэс байр сууринаас уг асуудал шийдэгдсэн гэж үзэх үндэстэй.

МАН-ын III Их хурал эхлэхээс хоёр сар гаруйхны өмнө буюу 1924 оны V сарын 31-нд ЗХУ-Хятадын хоорондын асуудлыг шийдвэрлэх өрөнхий зарчмын тухай хэлэлцээрийн 5-р зүйлд *"Гадаад Монгол БНХУ-ын салшгүй бүрэлдэхүүн хэсэг гэдгийг ЗСБНХУ-ын Засгийн газар хүлээн зөвшөөрч, Хятадын бүрэн эрхэт байдлыг хүндэтгэж байна"*²⁵ гэж заасан байна.

Гэвч ЗХУ-ын ГЯЯ-ны Ардын комиссар Чичерин 1924 оны эцсээр Төвийн Гүйцэтгэх хорооны Тблисси хотод болсон XXXII чуулган дээр дээрхи хэлэлцээрийн заалтыг нилээд өөрчилсөн тогтоол уншсан байна. Уг тогтоолд *"... Бид БНМАУ-ыг БНХУ-ын бүрэлдэхүүн хэсэг" гэж хүлээн зөвшөөрч байгаа боловч тус улсын автономит эрхийг өргөн утгаар хүлээн зөвшөөрч байна. Дотоод хэрэгтээ Хятадын хараат бус төдийгүй гадаад бодлогоо өөрөө бие дааж явуулах чадвартайг хүлээн зөвшөөрч байна"*²⁶ гэж дурьджээ.

Гэвч өдгөө тухайн үеийн Москвагийн улс төрийн байр суурийг тодорхойлж ОХУ-ын түүхч Е. Белов, С. Г. Лузянин нар бичихдээ *"... Зөвлөлт Орос болон Коминтерны үзэл суртлын хатуу нөлөөнд Монгол орныг улс төрийн хувьсгалын аятайхан талбар болгох, улмаар Монголоор дамжуулж Алс Дорнодыг бүхэлд нь хувьсгалжуулах бодлого явуулсан юм"*²⁷ гэжээ.

Эндээс үзэхэд БНМАУ-ын талаар Москвагийн баримталж байсан дипломат бодлого нь зөвхөн Хятадын хувьсгалд туслах стратегийн гол бодлогын хүрээнд явж ирсэн гэж үзэж болох бөгөөд үүний учир Москва Хятад дахь хувьсгалжих хөдөлгөөнийг түргэтгэх, анхнаасаа Монгол Улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхгүй байсан Хятадын хувьсгалчдыг өөрөөсөө хөндийрүүлэхгүй байхад чиглэгдэж байсан бололтой. Иймээс ЗХУ-ын дээрхи улс төрийн байр сууриас харахад тухайн үед Монгол-Германы харилцаанд анхнаасаа Зөвлөлт Орос Улсын улс төрийн нөлөө үлэмж их байсан нь ойлгомжтой бөгөөд Герман Улсын зүгээс ч БНМАУ-тай харилцах асуудалд ЗХУ, Хятадын байр суурийг (*ямар нэг хэмжээгээр*) албан ёсоор харгалзан үзэж байжээ.

²⁵ Р.А.Рупен, ХХ зууны Монголчууд, Улаанбаатар, 2000, 212-р тал.

²⁶ Мөн тэнд, дурдсан талд.

²⁷ Е.А.Белов, С.Г.Лузянин, О концепции Монгольского вопроса в истории Монгольской Народной Республики, Москва, Восток 1(2000), 44-45-р тал.

Учир нь Герман Улс нь БНМАУ-ын тусгаар тогтнолыг албан ёсоор хүлээн зөвшөөрөөгүй байсан юм.

Худалдаа, эдийн засгийн салбар дахь Монгол-Германы анхны уулзалт, хэлэлцээнүүдийн тухайд

Монгол-Герман Улсын хооронд худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоон хөгжүүлэх сонирхол нь хоёр талын харилцан ашиг сонирхлоос үүдэлтэй юм. Анх 1922 онд Москва дахь Германы Элчин сайдын яамны зөвлөх, Бээжин дэх Германы Элчин сайдын яамны худалдааны атташе, Дорнод Европыг судлах Германы нийгэмлэгийн нарийн бичгийн дарга нарын бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид Нийслэл Хүрээнд хүрэлцэн ирсэн бөгөөд уг үйл явдлын тухай тухайн үед *“Власть труда”* сонины 1922 оны VIII сарын 19-ний дугаарт нийтэлж байжээ²⁸. Академич Ж. Болдбаатар ХБНГУ-ын БундесАрхивт буй эх сурвалжид үндэслэн тэдгээр төлөөлөгчдийг Германы дипломатч Херманн Гипперих, доктор Армис нар болохыг тогтоосон билээ.²⁹

Тэдгээр төлөөлөгчид Монголд хүрэлцэн ирээд худалдаа, эдийн засгийн зарим хэлэлцээ хийсэн бөгөөд Монголд төмрийн завод байгуулах боломжийн талаар манай Засгийн газарт санал тавьж байжээ. Гэвч эдгээр төлөөлөгчид нь Монгол Улсад болж байсан үйл явцыг тандан судлах, Монголын талаар дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулах зорилготой байсан бололтой. Энэ тухай ноён Гипперих 1922 оны VII сарын 25-нд Бээжин дэхь Элчин сайддаа бичихдээ *“... Монголын албан газрууд Германд ихээхэн найрсаг хандаж байх шиг байна. Ерөнхий сайд надаас ямар зорилго, төлөвлөгөөтэй ирснийг асуугаад, бүх талын дэмжлэг үзүүлэхэд бэлэн байна гэв. Герман хүний*

²⁸ Үндэсний Төв Архив, Фонд 382. данс. 3. хадгаламжийн нэгж - 51.

²⁹ Монгол Улс, ХБНГУ-ын хооронд дипломат харилцаа тогтсоны 30 жилийн ойд зориулан Монгол Улсын Гадаад Хэргийн Яам, Монгол Улсад суугаа ХБНГУ-ын Элчин Сайдын Яамны ивээл дор зохион байгуулсан “Монгол-Германы харилцааны түүх, өнөөгийн байдал, хэтийн төлөв” эрдэм шинжилгээний бага хуралд Академич Ж. Болдбаатарын тавьсан “БНМАУ-ын эдийн засгийн тусгаар тогтнол ба Герман Улс /1921-1930” сэдэвт илтгэл, Улаанбаатар, 2004. I. 27.

нь хувьд намайг Монголын эгэл жирийн хүмүүс ч маш элэгсэг дотно хүлээн авч байна”³⁰ гэж тэмдэглэжээ.

1922 оны VIII сарын 5-ны өдөр доктор Армис Ерөнхий сайд болон Гадаад Явдлын, Цэргийн яамны сайдуудад бараалхсан ба түүний бичсэнээр уулзалт хэлэлцээр гурван цаг гаруй үргэлжилж, манай талаас Герман Улсын тусламжтайгаар аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх, Германы пүүсүүдийн тоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг доктор Армисаас дахин дахин хүсч байжээ.³¹

Уг айлчлалын үр дүнд худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоох талаар ийнхүү зарим нэг тодорхой тохиролцоонд хүрсэн чухал уулзалтууд Монгол-Германы албаны хүмүүсийн хооронд болж өнгөрсөн бололтой. Манай Улсын удирдах албаныхан техник, технологи өндөр хөгжсөн Герман Улстай худалдаа, эдийн засгийн өргөн дэлгэр харилцаа тогтоох асуудлыг ихээхэн сонирхож байсан нь эргэлзээгүй юм. Германы дипломатч Херманн Гипперих, доктор Армис нарын хагас албан ёсны шинжтэй энэ айлчлалын үеэр манай тал Герман Улстай худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоох, нөхцөл байдлыг судлах зорилгоор худалдааны төлөөлөгчдөө илгээхээр шийдсэнээ албан ёсоор мэдэгдсэн байна. Энэ тухай доктор Армис бичихдээ “... Урьдах өдөр бас цэргийн яамны сайд энэ тухай надад ярьж байсан. Энэ асуудлыг зарчмын хувьд аль хэдийн шийдвэрлэсэн боловч төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд хэн хэнийг оруулах, хэдийд явуулах талаар одоо болтол тодруулан өгсөн зүйл хараахан үгүй байна... Хожим би өөр нэг сурвалжаас Ерөнхий сайд, буриад Ринчино нарыг явуулахаар тогтсон гэж сонсов”³² гэсэн байдаг.

Мөн зарим түүхэн баримтаас үзвэл Хаалган хот дахь АНУ-ын Консулын газар, Оросын Чита хот дахь Германы Консулын газрууд Монгол Улстай албан бус харилцаатай байсан баримт мэдээ байна. Энэ тухайд холбогдох нэгэн сонирхолтой баримт нь Хаалганд сууж байсан АНУ-ын консул Самуэл Сокобин 1922 оны VIII сарын 16-нд Төрийн нарийн бичгийн даргадаа бичсэн тайлан юм. Самуэл Сокобин бичсэнээр “... Читад суугаа Германы консулын газрынхан Хүрээнд

³⁰ Ж. Болдбаатар, Түүх зулсан он жилүүдийн ойллого, боть I, Улаанбаатар, 2003, ХБНГУ-ын Бундес архивт буй Монголын тухай баримт сэлт (1921-1930), 290-р тал.

³¹ Мөн тэнд

³² Мөн тэнд

үргэлж ирж очиж, тэд Монголчуудтай хэл амаа ололцон ойртож байна. Энэ нь Германчууд Монголыг Хятадад хамаагүй тусгаар тогтносон улс хэмээн үздэгтэй холбоотой хэрэг байх”³³ гэж дүгнэсэн байдаг.

Мөн 1923 оны III сарын 21-нд Монгол Улсын элчин сайд Жадамбаа Москвад суугаа Герман Улсын Элчин сайдын яамны зөвлөх доктор Армисийг хүлээн авч уулзах үеэрээ хэлэхдээ “... Монгол орныг Англи, Франц, Герман сонирхож байна. Монголын Засгийн газар Германы пүүсүүдийг илүү хүчтэй дэмжих болно. Учир нь Герман Улс Монгол орноос хол, тиймээс ямар ч аюул учруулах боломжгүй, нөгөө талаар Германы бараа болон хийж буй ажил нь чанартай, Германчууд манайд ажиллахаар очвол манайхыг Хятадын муж мэтээр үзэж болохгүй, бие даасан улсын ёсоор хандах ёстой”³⁴ гэж мэдэгдэж байжээ.

Түүнчлэн 1923 оны IX сард Дундад Улсад суугаа Герман Улсын элчин сайдын зөвлөх Кибор Нийслэл Хүрээнд албаны хэргээр хүрэлцэн ирсэн тухай баримт байна. Тэрээр хоёр улсын хооронд албаны ямар нэгэн гэрээ, хэлэлцээр хийсэн тухайд маш бүрхэг байгаа ч манай талаас түүний зорьж ирсэн үйл хэрэгт зохих дэмжлэгийг үзүүлсэн байна. Энэ тухай Монгол Улсын Гадаад Явдлын яамны 1923 оны IX сарын 20-ны өдрийн № 852 тоот албан бичигт дурьдсан байна. Доор сийрүүлбээс:

“...Монгол Улсын Ардын Засгийн газрын Гадаад Явдлын яамнаас, үнэмлэх, тамга дарсан бичиг шийтгэн олгосны учир, Эдүгээ Герман Улсаас Дундад улс дор суугаа элчин сайдын зөвлөх түшмэл, Кибороос, миний бие мөнөөхөн албан хэргийн учир Нийслэл Хүрээнд хүрч ирсэн, одоо хойш буцах тул авч яваа эл зүйлсийг Монгол хязгаарын дотор тохиолдох олон гаалийн хорооны газраа задлан үзүүлэхгүй өнгөрүүлэх үнэмлэх бичиг олгомуу хэмээснийг манай яамнаас ёсоор болгосны тулд, аливаа зам тохиолдох тус улсын гаалийн хорооны зэрэг газрын түшмэл, цэрэг албаны хүмүүс саатуулан боогдуулах үгүй найртай сайны ёсоор хамгаалан өнгөрүүлэх хэмээн үүний тул, үнэмлэх тэмдэг дарсан бичиг шийтгэн олгов.”³⁵ гэжээ.

³³ БНМАУ-ын Гадаад харилцааны түүхчилсэн товч лавлах, Улаанбаатар, ГЯЯ, ШУА, ГЯЯ-ны Архив, 1987, 162-р тал.

³⁴ Ж.Болдбаатар, Түүх зулсан он жилүүдийн ойллого, боть I, Улаанбаатар, 2003, ХБНГУ-ын Бундес архивт буй Монголын тухай баримт сэлт (1921-1930), 290-р тал.

³⁵ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6. Монгол-Германы харилцааны данс – 1, нугалбар № 1.

Дээрээс харахад 1925 он хүртэлх хугацаанд Монгол-Герман улсууд худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоох боломжийн талаар харилцан судалж зохих албаны хүмүүсийг томилон явуулж байжээ. Дурьдан буй үед Монгол Улс дахь гадаадын эдийн засаг, худалдааны ашиг сонирхлыг дэмжих таатай орчинг бүрдүүлэхэд ихэд анхаарч байсны үр дүнд 1923 оны байдлаар Монгол Улс дахь Англи, Америк, Германы пүүс 26 байсан бол 1924 онд 62 болж өссөн байна.³⁶

Хэдийгээр энэ үеэс ЗХУ, Коминтерны улс төрийн оролцоо дотоод, гадаад бодлогод шийдвэрлэх нөлөөтэй болсоор байсан ч МАХН-ын Төв хороо, Ардын Засгийн газраас Герман Улстай харилцах асуудлыг чухалчлан үзэх болж 1924 оны XI сарын 3-ны өдөр Монгол Улсаас ЗХУ-д суух бүрэн эрхэт элчин сайдаар томилогдсон А. (Япон)Данзанд Монгол Улсын Ерөнхий сайд Б. Цэрэндорж Москвад суугаа гадаад орнуудын элчин сайдууд тэр дундаа тусгайлан Германы элчин сайдтай биечлэн уулзаж, Герман Улсын улс төрийн байдал, Монгол Улсын талаар баримталж байгаа бодлого, чиглэлийн нь тухай мэдээлэл авах, Германы монгол судлаач эрдэмтэдтэй холбоо тогтоох, зохиол бүтээлүүдээс нь ирүүлэх зэрэг ажлын удирдамж чиглэл өгч байсан нь өдгөө ихээхэн анхаарал татаж байна.³⁷

Элчин сайд А. (Япон) Данзан Засгийн газраас өгсөн дээрхи чиглэлийн дагуу Москва хот дахь Герман, Франц, Япон, Хятад зэрэг гадаад улсуудын элчин сайд, дипломат төлөөлөгчидтэй биеэр очиж уулзан эдгээр улсуудтай найрсаг харилцаа тогтоож, Монгол Улсын тусгаар тогтнолыг албан ёсоор хүлээн зөвшөөрүүлэх асуудлуудыг хөндөн ярилцаж байсны зэрэгцээ Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу гухайн улсуудын улс төрийн байдал, худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоох боломж, Монголыг хэрхэн үзэж байгаа зэргийг судлаж, монголч эрдэмтэдтэй уулзаж ном, зохиолоос нь олж ирүүлэх боломжийг эрэлхийлж ажилласан байна.³⁸

Элчин сайд А. (Япон) Данзан-ы Герман Улстай харилцаа тогтоох идэвхтэй оролдлого амжилт олж 1925 оноос манай хоёр улсын

³⁶ С.Идшинноров, Хот суурины хувийн хэвшлийн хөгжил, хувьслын асуудалд /1921-1960, Түүхийн ШУ-ны дэд доктор /Ph.D/-ын зэрэг горилсон бүтээл, Улаанбаатар, 1993, 17-р тал.

³⁷ Монгол Улсын Гадаад Хэргийн яамны Төв Архив. Фонд 01ш. хадгаламжийн нэгж-1173

³⁸ Мөн тэнд.

харилцан хүчин чармайлтын үр дүнд худалдаа, эдийн засаг, соёл боловсролын салбар дахь харилцаа холбоо эрс идэвжсэн билээ.

Мөн энд зайлшгүй тэмдэглэх ёстой нэг асуудал бол Монгол-Герман хооронд худалдаа, эдийн засгийн харилцаа тогтооход чиглэгдсэн анхны үйл ажиллагаа зохих амжилт олоход Москва дахь Германы элчин сайд фон Брокдорф-Ранцау (*von Brockdorff-Rantzau*) гүнгийн санаачилга, оролцоо зохих нөлөө үзүүлснийг дурьдах хэрэгтэй болов уу?

Москва дахь Герман Улсын элчин сайдаар сууж байсан фон Брокдорф-Ранцау (*von Brockdorff-Rantzau*) бол Герман Улсын улс төрийн байр суурийг ЗХУ-тай харилцан найрамдалт харилцааг хөгжүүлэх чиглэлд хандуулж байсан улс төрчдийн нэг байв. Иймээс Монгол-Германы харилцаа өргөжихөд ЗХУ-ын талаар аядуу байр суурийг баримталж байсан Герман Улсын зарим улс төрчдийн байр суурь чухал үүрэг гүйцэтгэж байсныг үгүйсгэх аргагүй юм.

1925 он гармагц Герман Улсад худалдааны төлөөлөгч нарын бүрэлдэхүүнийг илгээх тухай асуудал үндсэндээ шийдэгдсэн байна.

1925 оны IV сард БНМАУ-ын Засгийн газрын ажилтан Даш Сампилон, инженер Хурлат нарыг худалдааны төлөөлөгчдөөр сонгон Герман Улсад явуулсан байна. Герман Улсад худалдааны төлөөлөгчөөр сонгогдсон инженер Хурлатын тухай материал архивт хадгалагдан үлдсэн байна.

БНМАУ-ын Гадаад Явдлын яамны 1925 оны IV сарын 7-ны өдрийн № 360 тоот албан бичигт Герман Улсад үйлдвэрийн багаж хэрэгсэл худалдан авах, судлах ажлаар томилогдсон Аж ахуйн яамны инженер Хурлатыг хилээр саатуулахгүй нэвтрүүлэхийг ЗХУ, Германы гаалийн албаны удирдлага, ажилтнуудаас албан ёсоор хүссэн байна.³⁹

Герман Улсад явах худалдааны төлөөлөгч Даш Сампилон, Хурлат нарт Засгийн газраас ажлын доорхи чиглэлүүдийг өгсөн ба тэдгээр нь:

- *Берлин хотод Монголын худалдаа, соёлын төлөөлөгчийн газрыг нээх*

³⁹ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6. Монгол-Германы харилцааны данс – 3-1, нугалбар № 2.

- БНМАУ-д ажиллах төрөл бүрийн салбарын мэргэжилтэн, сургагч нарыг олж ирүүлэх
 - Зарим үйлдвэрийн газруудыг шинээр барьж байгуулах, төхөөрөмжлөх талаар Герман Улсын холбогдох газруудтай холбоо тогтоож, дэмжлэг авч болох эсэх талаар судлах
 - Монгол орны ашигт малтмал, тэдгээрийн орд газрыг нээн илрүүлэх, зураглал зохиох, лабораторын шинжилгээ хийх асуудлаар дэмжлэг авах
 - БНМАУ-д нэн шаардлагатай байгаа техник, тоног төхөөрөмж, бараа таваарыг байнга нийлүүлэх томоохон пүүс, фермүүдтэй холбоо тогтоох
 - БНМАУ-аас Герман Улсад түүхий эд экспортлох тухай асуудлаар албан ёсны гэрээ, хэлэлцээр хийх
 - Герман, Францад оюутан суралцуулах асуудлыг судлах⁴⁰
- зэрэг асуудлууд байсан юм.

Энэ айлчлалын үр дүнд Монгол-Герман хоёр улсын хооронд худалдаа, эдийн засаг болон соёл боловсролын харилцаа тогтоох талаар үндсэн тохиролцоонд хүрч чадсан байна. БНМАУ-ын худалдааны төлөөлөгчид Герман Улсад очсон тухай он цагийн нарийн мэдээ баримт тун бүрхэг байгаа боловч архивийн баримт мэдээ бусад холбогдох эх сурвалжуудаас авч үзвэл 1925 оны V сарын эхээр хүрэлцэн очсон болов уу? гэх үндэслэл байна.

Энэ тухай Герман, Франц Улс дахь Монгол сурагчдын захиргааны дарга Б. Ишдоржийн зөвлөхөөр ажиллаж байсан С. М. Вольф хожим 1964 оны хавар Лондон хотноо Хааны Төв Азийн сэтгүүлд бичсэн *"Баруун Европ дахь Монголын боловсролын зоримог үйл хэрэг"* хэмээх дурсамж өгүүлэлдээ 1925 оны V сарын эхээр Берлинд байгуулагдсан Монголын Худалдааны төлөөлөгчийн газрын удирдлагуудтай уулзсан тухайгаа тодорхой бичсэн байдаг.⁴¹

⁴⁰ Монгол Улс, ХБНГУ-ын хооронд дипломат харилцаа тогтсоны 30 жилийн ойд зориулан Монгол Улсын Гадаад Хэргийн Яам, Монгол Улсад суугаа ХБНГУ-ын Элчин Сайдын Яамны ивээл дор зохион байгуулсан "Монгол-Германы харилцааны түүх, өнөөгийн байдал, хэтийн төлөв" эрдэм шинжилгээний бага хуралд Сүлдэт Р.Тердалайн тавьсан "Герман Улс дахь Монголын худалдааны төлөөлөгчид /1925-1926/" сэдэвт илтгэл, Улаанбаатар, 2004. I. 27.

⁴¹ S.M.Wolff, Mongolian Educational Venture in Western Europe /1926-1929/, Zentralasiatische Studien 5 (1971), 268-р тал.

Тэрбээр мөн БНМАУ-ын худалдааны төлөөлөгчдийн тухайд "...Эхлээд хоёр хүний бүрэлдэхүүнтэй худалдааны төлөөлөгчдийг Герман улсад илгээсэн бөгөөд тэд нилээд хугацаанд тэнд байхдаа Монгол Улсад нэн шаардлагатай байсан машин, тоног төхөөрөмж мөн олон төрлийн бараа таваарыг өргөнөөр худалдан авах тухай худалдааны харилцаа холбоог тогтоохыг зорьж байсан юм."⁴² (Төв Азийн сэтгүүлийн 1945/46-г үз.) гэж бичсэн байдаг.

Мөн манай ГХЯ-ны Төв Архивт хадгалагдаж байгаа Монгол-Германы харилцааны холбогдолтой баримтуудад Сампилон, Хурлат нар Герман Улсаас худалдан авсан машин, техник, бараа таварын зүйлсээ Орос-Германы хамтарсан тээврийн пүүсээр дамжуулан Монгол Улс руу явуулсны хөлс (Тэд дойч марк, америк доллар, английн фунт зэрэг валютаар тооцоо хийсэн ажээ. Р.Т) зэргийг нэхэмжилсэн хуудас Аж Ахуйн яаманд ирсэн байна.⁴³

Худалдааны төлөөлөгчид дээрээс өгсөн чиглэл, даалгаварыг өндөр түвшинд гүйцэтгэж байжээ. Сампилон, Хурлат нар Герман Улсын Берлин, Гамбург, Дрезден зэрэг хотуудаар явж БНМАУ-д гэрээгээр ажиллах мэргэжилтнүүдээр нилээд олон хүнийг элсүүлэн авч чадсан байна.⁴⁴ Гэрээ ёсоор БНМАУ-д урилгаар очиж ажиллах мэргэжилтэнүүдтэй гэрээ байгуулж хоёр талын хүлээх үүргийг тодорхой заасан байна.

БНМАУ-ын Засгийн газрын хүлээх үүрэг нь:

- Сар бүр 225-250 мексик долларын цалин олгох
- Орон сууцаар үнэгүй хангах
- Ирэх, буцах замын зардлыг төлж байх
- Эмнэлэгийн үйлчилгээгээр сайн хангах
- Өмч хөрөнгийг нь хамгаалах

Герман мэргэжилтнүүдийн хүлээх үүрэг нь:

- БНМАУ-д ажиллах хугацаандаа өөрийн хариуцсан ажиллах өмч хөрөнгө, материалд ариг гамтай хандаж, бүрэн бүтэн байдал, ажиллагааг хангах

⁴² Мөн тэнд, 247-р тал.

⁴³ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6. Монгол-Германы харилцааны данс -1-1д, нугалбар № 39.

⁴⁴ С. Идшинноров, Хот суурины хувийн хэвшлийн хөгжил, хувьслын асуудалд /1921-1960/, Түүхийн ШУ-ны дэд доктор /Ph.D/-ын зэрэг горилсон бүтээл, Улаанбаатар 1993, 44-р тал.

- Аж ахуйн яамнаас өгсөн үүрэг, даалгаврыг нягт нямбай гүйцэтгэх
 - Туршлага мэдлэгээ бүрэн дайчилан ажиллах
 - БНМАУ-ын холбогдох хуулийг чанад мөрдөн сахих
 - Улс төрийн аливаа ажиллагаа хийхгүй байх
 - Гадаадын аль нэг фирм, үйлдвэр байгууллагыг төлөөлөхгүй байх
- эрэг ерөнхий үүргүүдийг харилцан хүлээсэн байна.⁴⁵

1925 оны 7 сард Даш Сампилон, Хурлат нар Герман Улсын ГЯЯ-ны холбогдох албан тушаалтнуудтай уулзаж ярилцан Берлин хотод *"Монголын худалдаа, соёлын төлөөлөгчийн газар"* нээх тухай ирилцжээ. Түүнчлэн Сампилон энэ үеэр *"Deutsche Allgemeine Zeitung"* сонины эрхлэгч Т.Стревед Монголын тухай сонирхолтой ярилцлага өгч байжээ.⁴⁶

Герман Улсын Засгийн газрын холбогдох албан тушаалтнууд ч БНМАУ-тай худалдаа, эдийн засаг, соёл боловсролын харилцаа тогтоох асуудлыг анхааран үзэж бүх талаар дэмжихээ илэрхийлж байжээ. Тодруулбал энэ үед Германы удирдах албаны хүмүүсийн дунд Герман-Монголын хооронд худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоож их хэмжээний экспорт, импортын бараа, бүтээгдэхүүн, түүхий эдийг харилцан нийлүүлэх, Герман Улсын Худалдаа дэмжих фондоос хэдэн сая маркийн хөрөнгө гаргах асуудлаар идэвхтэй яриа хэлэлцээ болж байсан тухай сонирхол татам баримт байна.⁴⁷

1925 оны VII сарын 19-нд Даш Сампилоноос Москва хот дахь элчин сайдын яамаар дамжуулан Аж Ахуйн яамнаа илгээсэн албан захидалдаа энэ тухай тодорхой дурьджээ. Даш Сампилон бичихдээ *"...Бид нар Герман Улсын Гадаад яамны түшмэд нар лугаа учирч манай Монголын дотоод гадаадын байдал төлөвийг илтгэн тодорхойлсон дор тэд нарын хэлсэн нь Герман Улс болбоос дипломатын ба улс төрийн политикин ёсоор Монгол Улсыг сонирхон үзэх ба түүний тухай хэлэлцээ хэлэлцүү үл чадах боловч эрдэм соёлын ёсоор Монгол ард түмний байдлыг мэдэн авч, аливаа*

⁴⁵ С. Идшинноров, Хот суурины хувийн хэвшлийн хөгжил, хувьслын асуудалд (1921-1960), Түүхийн ШУ-ны дэд доктор /Ph.D/-ын зэрэг горилсон бүтээл, Улаанбаатар, 1993, 45-р тал.

⁴⁶ S.M.Wolff, Mongolian Educational Venture in Western Europe /1926-1929/, Zentralasiatische Studien 5(1971), 280-р тал.

⁴⁷ Т.Намжим, Монголын аж ахуй, эдийн засаг (Түүхэн гурван үед), 2-р боть, Улаанбаатар, 2000, 517-р тал.

боловсронгуй эрдмийн тусламж хүргэхийг хүсэж баймой хэмээснээс гадна август сарын гучидаар Засгийн газраас нэгэн эрдэмт түшмэлийг томилон Монгол дор явуулахаар завдан буй хэмээсэн..."⁴⁸ тухай өгүүлсэн байна.

Энэхүү түүхэн баримт нь Герман Улсын зүгээс БНМАУ-ыг хэрхэн үзэж байсныг илтгэх тодорхой эх сурвалж болж байна.

Герман Улсаас ийнхүү Засгийн газрын түвшинд албан ёсны төлөөлөгчөө ирүүлж Монголын байдлыг судлуулахаар шийдвэрлэсэн нь тэмдэглүүштэй хэрэг байлаа. Уг төлөөлөгч нь Берлины Их сургуулийн багш профессор Кюзенсис гэдэг хүн байсан ба түүнийг дагалдаж өмнө нь Монгол Улсад нэг бус удаа ирж байсан (*Сампилоны бичснээс үзвэл*) Монголын байдлыг сайн мэдэх туршлагатай Баурик гэдэг хүнийг томилохоор болсон байна.⁴⁹ Профессор Кюзенсис нь 1923 оноос Бүгд Найрамдах Киргиз улсад ажиллаж ард, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар чамгүй зүйл хийсэн төдийгүй тэр тухайгаа Германдаа очсоны дараа тусгай ном хэвлүүлж байжээ. Тэрбээр Монгол Улсад томилогдон ажиллах хугацаандаа Нийслэл Хүрээ, Улиастай, Ховд зэрэг газраар явж монгол иргэдийн эрүүл мэндийг шинжилэн судалж дараа нь өөрийн Засгийн газартаа ямар чиглэлээр тусламж үзүүлбээс зохихыг мэдээлэх, улмаар Монгол-Германы Засгийн газруудын хамтын хөрөнгөөр эмийн үйлдвэр ба оношлогооны лаборатор байгуулах зорилготой байжээ.

Профессор Кюзенсис нь урьд нь Туркестан болон Тблисси хотод лаборатор байгуулан ажиллаж байсан ихээхэн туршлагатай эмч гэдгийг ч Сампилон захидалдаа дурьдсан байна.⁵⁰ Сампилоноос эдгээр хүмүүст хил саадгүй нэвтрүүлэх виз гарган өгөхийг Алтанбулагын сайдаас хүсэхийн зэрэгцээ орос хэлний орчуулагч, автомашинаар үйлчилж, ихэд хүндэтгэл үзүүлэн яамандаа урин дайлж, сайтар танилцахыг харъяат яамны сайд нарт зөвлөн мэдэгдсэн байна.

Энд бас нэгэн сонирхолтой баримт байгаа нь 1925 онд Герман Улсын өдөр тутмын хэвлэлд БНМАУ-ын талаар гарсан өгүүлэл бөгөөд уг өгүүлэлийн монгол орчуулга ГХЯ-ны Төв Архивт *"Германы сонинд*

⁴⁸ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6. Монгол-Германы харилцааны данс – 1-1д, нугалбар №40.

⁴⁹ Мөн тэнд

⁵⁰ Мөн тэнд

нийтлэгдсэн өгүүлэлийн орчуулга, танилцуулах мэдээ” гэсэн гэрчигтайгаар хадгалагдаж буй хуудасны дугаар тавигдаагүй задгай материал юм. Германы сонинд хэвлэгдсэн энэхүү баримт бол тухайн үеийн Монгол Улсын талаар өөрийн Засгийн газрынхаа албан ёсны байр суурийг тодотгосон, Монгол Улс дахь Оросын нөлөө, оролцооны тухай бодитой өгүүлсэн түүхэн баримт болно. Энэхүү баримтыг ямар нэг тайлбаргүйгээр дор сийрүүлъя.

Герман Улсын сонинд нийтлэгдсэн нь.

**“Монгол Улс болбоос Оросын шинэ ёсны байдлыг таниж
Бородины замд орсон”**

Ковну хотоос ирсэн цахилгаан мэдээ

“Москвагаас ирсэн мэдээгээр үзвээс, Монгол ба Орос улсууд хоёр хоорондын гэрээ байгуулах явдлыг хэлэлцэж, Монгол Улсын Засгийн Газар нь Оросын мэдүүлсэн ба дурьдсан зүйлүүдийг цөм зөвшөөрөх нь гэрээ бичиг... батлахаар завдан буй үүний гол зорилт нь Монголын цэргүүдийг Бородин дор шууд захируулж Монголын бүх цэргийн зөвлөх түшмэлийн албан тохоож Монгол цэргийн удирдагч толгой болгохоор хэмээжээ. Байцааваас өнгөрсөн 1924 онд Монголчууд болбоос ардын эрхэт засгийг байгуулж, Монгол Ард Улс хэмээн нэрийдсэнээс дараа Монгол Улс нь СССР Улс лугаа харилцан ойр хэлхээ холбоотой болж Улаанбаатар хотноо сургагч хэмээх мэтийн нэр зүүж албан хааж буй орос нар байдаг хэмээхээс гадна энэхүү гэрээ бичиг байгуулж найрамдалтай болох хэмээсэн нь Монголыг эзэрхэн авахыг завдсан хэрэг мөн бөгөөд Бородин нь Монголын байдалд оролцохыг завдсан хэрэг бус харин зүүн ба өмнө Хятадын хэрэгт оролцох зорилго байгаа хэрэг. Бородин болбоос Монгол цэргийн зөвлөх түшмэл ... үүгээр Дорнод хязгаарын газар нуугдах төв газрыг байгуулжээ”.

1925 он.⁵¹

гэжээ.

Эндээс үзэхэд Герман Улс энэ үед БНМАУ-ын дотоод асуудалд ЗХУ-аас хутгалдан оролцох болсон зэрэгт шүүмжлэлтэй хандаж байв. Энэ үед Герман Улс Монголд өрнөж байсан асуудлуудыг анхааралтай ажиглаж байжээ. Мөн БНМАУ дахь Оросын нөлөөний хүрээг сулруулах бодлого баримтлахын тулд БНМАУ-ын удирдагчдын

⁵¹ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6. Монгол-Германы харилцааны данс – 3-1, хуудасны дугааргүй материал.

Герман Улсад хандсан үйл ажиллагааг аль болохуйц дэмжих бодлого баримталж байсан бололтой.

Гэтэл нөгөө талаар өдгөө нээлттэй болж буй хуучин ЗХУ-ын үеийн архивийн нууц баримтуудаас үзвэл 1920-иад оны дунд үед ЗХУ нь Германы капиталыг Монголд оруулахыг дэмжиж байсан баримт байна. 1925 оны VI сарын 11-ний ОК(б)Н-ын Төв Хорооны Улс төрийн товчооны 66 дугаар хуралдаанаас гаргасан тогтоолд *“ЗСБНХУ “Монголор” хэмээх үйлдвэр аж ахуйн ажилд оролцож чадахгүй нь харамсалтай байна гэж Монголын Засгийн газарт мэдэгдэх. Монголын Засгийн газарт Германы капиталыг татан оролцуулах санал тавьж, тийнхүү татан оролцуулахад бидний хүчин туслахад бэлэн байгааг мэдэгдэх.*

*Төв Хорооны нарийн бичгийн дарга И. Сталин*⁵² гэжээ.

Дээрхи баримтад түшиглэн үзвэл ЗХУ-Германы хооронд тухайн үед далдуур ойртол, нягтрал явагдаж байсан ба өдгөө энэ нь хэн бүхэнд нэгэнт ойлгомжтой болжээ. ЗХУ-Германы энэхүү далд хамтын ажиллагаа нь Монгол-Германы харилцаанд хэрхэн нөлөөлсөн эсэх нь өдгөө ч тодорхойгүй асуудал хэвээр байна. Цаашид нарийвчлан судалууштай асуудал энэ хүрээнд цөөнгүй бий.

Юутай ч дурьдан буй үед Герман Улсаас манай талтай хийх худалдааг Оросын Сибирийн төмөр замаар дамжуулан явуулах тухай идэвхтэй яриа хэлэлцээ ч явагдаж байжээ. БНМАУ-ын худалдааны төлөөлөгчдийн айлчлалтай давхцан бас нэгэн *“сонирхолтой аялал”* болсон нь 1926 оны XI сараас 1927 оны I сарын эцэс хүртэл хугацаанд МАХН-ын Намын Төв Хорооны дарга Ц. Дамбадорж, Намын Төв Хорооны орлогч дарга Н. Жадамбаа нар Москвад сууж байсан элчин сайд А. Данзан(*Япон*), БНМАУ дахь Герман Улсын “Востваг” пүүсийн удирдлагуудтай тохиролцож зөвшилдөн 3 сарын хугацаатайгаар Герман, Франц, Итали орнуудаар явжээ.⁵³

Тэдний томилолт нь Судар бичгийн хүрээлэнгийн өмнөөс Өрнөд Европ дахь монгол судлал хөгжиж байгаа улсуудын их сургууль, хүрээлэнтэй холбоо тогтоох гэсэн агуулагатай байсан төдийгүй уг

⁵² Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичигт (1921-1932), Баримтын эмхтгэл, боть I, Улаанбаатар, 2002, 191-р тал.

⁵³ S.M.Wolff, Mongol Delegation in Western Europe, /1925-1929/, Royal Central Asian Journal, London, 1944.

ийлчлалын тухай мэдээ баримт тун ховор байгаа нь ЗХУ-ын удирдлагуудаас нууж айлчлалтай холбоотой нь эргэлзээгүй. Томилолтын агуулагаар бол эрдэм шинжилгээ, соёлын асуудалд гол анхаарлаа хандуулах ёстой байсан ч тэдний томилолт илүү өргөн хүрээг хамарч улс төрийн агуулагатай болсон гэж үзэж болно.

Өөрөөр хэлбэл тэдний айлчлалыг тодорхойлбол нэг талаар албан ёсны мэт боловч зарим талаар албан бус байдалтай байсан юм. Ц.Дамбадорж томилолтынхоо явцад Берлинд Лейпцигийн Конрадын коллежийн Зүүн Азийн салбарын эрхлэгч, профессор Э. Хэниш (1880-1966), С. М. Вольф, Герман улсын ГЯЯ-ны Алс Дорнодын хэлтсийн ажилтнуудтай уулзаж Германаас монголч эрдэмтэн урин аваачих, монгол сурагчдыг илгээн суралцуулах зэрэг асуудлыг тавихын зэрэгцээ Герман Улстай худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоон мэргэжилтнүүдийг гэрээгээр ажиллуулах тухайд албан тохиролцоог хийсэн байна.⁵⁴ Гэвч Ма Хо-Тайн 1926 онд Ц.Дамбадоржтой уулзсан тухайгаа бичсэн дурсамжинд түүнийг Герман, Францаар явахдаа “мөнгөөр туйлж” 30.000 ам. доллар зарцуулсан тухай⁵⁵ бичсэн байдаг ба энэ тухай хожим намын хурал дээр ч шүүмжлэл явагдаж байсан юм. Юутай ч худалдааны төлөөлөгч Сампилон, Хурлат нарын айлчлалыг давтсан шинжтэй болсон Монголын албаны хүмүүсийн Герман дахь аялал, нөгөө талаар айлчлал нь зохих үр дүнд хүрсэн нь эргэлзээгүй бөгөөд Герман Улстай худалдаа, эдийн засгийн өргөн харилцаатай тогтоох боломж улам нээлттэй болсон юм.

Мөн энэ үед дээрхи үйл ажиллагааг батлагаажуулсан нэгэн шийдвэр гарсан нь Ардын Засгийн газрын даалгавраар ЗХУ-аас бусад гадаад орнуудтай найрсаг харилцаа тогтоож, хөгжүүлэх тухай заалт Москвад сууж байсан Монголын Бүрэн эрхэт төлөөлөгчийн газрын 1926 оны дүрэм болон Гадаад явдлын яамны 1927 оны дүрэмд орсон байна.⁵⁶ Монгол-Германы дээрхи уулзалт хэлэлцээрүүдийн үр дүнд Берлин хот дахь *“Монголын худалдааны төлөөлөгчийн газар”* нь хоёр улсыг холбосон худалдаа, эдийн засгийн өргөн харилцааны илэрхийлэл болж чадсан байна.

Эцэст нь онцлон тэмдэглэхэд ерөнхий сайд Б. Цэрэндорж, Гадаад Явдлын яамны сайд В. Дорлигжав, Аж ахуйн яамны сайд А. Амар, МАХН-ын Төв Хорооны дарга Ц. Дамбадорж зэрэг манай улсын

⁵⁴ өн тэнд.

⁵⁵ Р.А.Рупен, ХХ зууны Монголчууд, Улаанбаатар, 2000, 248-р тал.

⁵⁶ Монгол Улсын Гадаад Хэргийн яамны Төв Архив. Фонд 01. Хадгаламжийн нэгж – 274.

удирдах дээд албаныхан Герман зэрэг өрнөдийн улс гүрнүүдтэй харилцан тэгш эрх, дотоод хэрэгт үл оролцох зарчмын үүднээс худалдаа, эдийн засаг, соёл, боловсролын салбарт хамтран ажиллахыг чухалчлаж байв.

Өөрөөр хэлбэл улсын дайтай улс байх гэсэн Монголчуудын үндэсний эрх ашгаас улбаатай түүхэн эрмэлзлэл нь Өрнөдийн хөгжингүй улс, гүрнүүдээр шинэ тулгар БНМАУ-ын тусгаар тогтнолыг албан ёсоор хүлээн зөвшөөрүүлж, төрийн харилцаа тогтоосноор жинхэнэ утгаараа биелэгдэх боломжтой байсныг тэд сайн мэдэж байлаа.

Иймээс ЗХУ-аас гадна гадаад түншлэлийн хоёрдагч замыг сонгож, олон түшигт харилцааг төрийн бодлогынхоо үндсэн чиглэл болгож байжээ.

Монгол сурагчдыг Герман Улсад суралцуулж үндэсний мэргэжилтнүүдийг бэлтгэж эхлэсэн нь

Энд онцлон тэмдэглэхэд анхнаасаа монгол сурагчидыг Герман Улсын ерөнхий боловсрол, тусгай мэргэжлийн төрөл бүрийн сургуулиудад суралцуулж байсан үйл хэрэг нь тус улстай тогтоосон худалдаа, эдийн засгийн харилцаатай харилцан нарийн уялдаатай явагдаж байсан юм.

1923 оны VII сарын 24-нд тусгай комиссын боловсруулан нийтэлсэн *“Эдийн засгийн үндсэн бодлого”* хэмээх бичгийн 15-р зүйлд *“олон үйлдвэрийн дунд ба дээд эрдмийг гадагш явж сурахгүй болбаас болохгүй болов уу”*⁵⁷ гэж заасны дагуу 1925 оны XI сарын 27-ны өдөр хуралдсан Ардын Засгийн газрын 42-р хуралдаанаас гаргасан шийдвэр ёсоор Ардыг Гэгээрүүлэх яамнаас хичээл сурлагадаа шалгарсан биеийн эрүүл мэндийн хувьд тэнцэх дунд сургуулийн төгсөх ангийн 13-17 насны 35 сурагчийг сонгон авч Герман, Франц улсад явуулж дунд, лицей болон тусгай мэргэжлийн ажилтан бэлтгэх төрөл бүрийн сургуульд суралцуулах” шийдвэр гаргасан байна.⁵⁸

Монгол сурагчид 1926 оны IV сарын 27-ны орчим алс холын Баруун Европт сурч боловсрохоор Герман Улсын нийслэл Берлин хотыг зорин Улаанбаатар хотоос хөдөлсөн бололтой. Тэдгээр сурагчдыг Намын

⁵⁷ Монгол Ардын намын хоёрдугаар их хурал (Баримт бичгүүд), Улаанбаатар, 1974, 139-р тал.

⁵⁸ УТА, Фонд № 11, данс. 2, хадгаламжийн нэгж - 4 хуудасны дугаар - 126-127.

Төн Хорооны дарга Ц. Дамбадорж, Ерөнхий сайд Б.Цэрэндорж, сайд А. Лмар, Судар бичгийн хүрээлэнгийн дарга Ж. Цэвээн нар үдэж мордуулжээ. Энэ тухай 1926 оны V сарын 21-ний өдрийн Үнэн сонин № 28-д нийтлэгдсэн дугаарт дүгнэн бичихдээ "... Ардыг Гэгээрүүлэх Намнаас ийнхүү бага насны өчнөөн хүүхдийг Герман, Франц зэрэг орноос улсад сургуулиар томилон явуулсан нь тэд нар сургуулийн тусламцааг дуусгаж эргэж ирэх цагт улс төр, ард түмний үйл хэрэгт түүхний их тустай нөхөд магад гарч ирэх буй за хэмээн найдах бөгөөд үүнээс үргэлжлэн Монголын сэргэлэн хурц, бага насны хөвгүүд охицыг орноос улсад ийнхүү сургуульд явуулсаар байваас хураах тус гавъяа хувь илүүгээр нэмэгдэн өрнөх тул энэхүү явдлаа улам өрнүүлэн шулуулахыг итгэж хүснэ"⁵⁹ гэжээ.

Энэ нь Герман Улсад оюутан, сурагчидыг явуулж сургах асуудлыг БНМАУ-ын нам, төрөөс тууштай дэмжиж байсныг батлах түүхийн баримт болж байна.

Монгол сурагчид Герман Улсад хүрэлцэн очиж Фронау (*Frohnau*)-д хэлний бэлтгэл хийснийхээ дараа тус улсын ерөнхий боловсролын болон БНМАУ-ын Засгийн газартай худалдааны гэрээтэй байсан үйлдвэр, заводуудад мэргэжлийн дадлага, сургууль хийж суралцах болсон байна..

- Монгол сурагчдын сургуульд хуваарилагдсан байдлыг авч үзвэл:
- Герман Улсын нийслэл Берлин /Berlin/ хотын Лихтерфельде дүүрэгт орших Улсын Сургалтын байгууллага /Staatliche Lehranstalt in Lichterfelde/ -ын дунд сургуульд
 - Лайпциг /Leipzig/ хот дахь газарзүйн зургийн Wagner&Debes нүүс, мөн Arno Pries & I.B.Hirschfeld хэвлэлийн нүүст
 - Залфельд /Saalfeldt/ хотын Виккерсдорфын чөлөөт сургуульд
 - Айзнах /Eisenach/ хотын Dixi автомашины үйлдвэрт
 - Лецлинген /Letzlingen/ хотын гар үйлдвэрлэлийн хамтлагт
 - Ораниенбург /Oranienburg/ хотын Хөдөө Аж ахуйн сургалтын байгууллага /Landwirtschaftliche Lehranstalt in Oranienburg-Luisenhof/-д
 - Фрайберг /Freiberg/ хотын арьс шир боловсруулах үйлдвэрийн сургуульд
 - Штутгартын ойролцоо Мюлакерн /Muehlacker/-ын Messrs. Haendle & Sons-ын тоосгоны заводад

⁵⁹ УТА, Үнэн сонин, 1926 оны V сарын 21, № 28.

- *Котбус /Cottbus/ хотын нэхмэлийн сургуульд*
 - *Потсдам /Potsdam/*
- зэрэг хотуудад хуваарилагдан суралцжээ.⁶⁰

Ийнхүү дээрх нэр бүхий 35 монгол сурагч Герман Улсад суралцах болж Европын шинжлэх ухаан, техникийн ололт амжилтаас суралцан эх орондоо мэдлэг боловсролтой мэргэжлийн боловсон хүчин болж эргэн очих нэр хүндтэй хариуцлагатай даалгаврыг гүйцэтгэх болжээ. Монгол сурагчид дээрхи сургуулиудаа дүүргэсний дараа эх орондоо эргэн ирж Герман Улстай худалдаа, эдийн засгийн харилцаатай байх хугацаанд байгуулагдсан үйлдвэр, заводад болон бусад чухал шаардлагатай ажлуудыг хариуцан ажиллах боловсон хүчин болох төлөвлөгөөтэй байлаа. Энэ үүднээс МАХН-ын V их хурлаас гаргасан тогтоолд Герман, Франц Улсад суралцаж байсан нэг монгол сурагчийн жилийн зардлыг 2230, 21 төгрөг гэж заасан⁶⁰ нь тухайн үедээ нэн өндөр үзүүлэлт байжээ.

Энэ нь 1927 онд Улсын III их хуралд Ардыг Гэгээрүүлэх яамнаас тавьж хэлэлцүүлсэн *“Ардын гэгээрлийг 10 жилээр төлөвлөсөн тухай”* илтгэлд Герман болон бусад хөгжилтэй орнуудад сургах оюутан, сурагчдын тоог нэмэгдүүлэн дэмжих зорилгыг баталсан шийдвэртэй холбогдож байна⁶¹. Мөн Засгийн газраас *“Герман, Франц Улс дахь Монгол сурагчдын захиргаа” (Verwaltung der Studierenden Mongolen in Deutschland und Frankreich)* нэртэй албан ёсны байгууллагыг байгуулан сурагчидтай холбогдох бүх хэргийг хамааруулах болсон ба дээр дурьдсанчлан Герман Улсад суралцах сурагчдын тоо болон өртөг, зардлыг тасралтгүй нэмэгдүүлэхийг дэмжиж байсан нь энэ зүгт ихээхэн анхаарал хандуулж байсныг батлан харуулж байна. С. М. Вольф хожим энэ үйл явцыг дурсаж *“...Миний олж мэдсэнээр алс холын Азийн орны Засгийн газар Европт залуусаа илгээж, улмаар Берлин хотод “Герман, Франц улс дахь Монгол сурагчдын захиргаа” нэртэй байгууллагыг бий болгож санхүү болон засаг захиргааны бүхий л*

⁶⁰ Сүлдэт Р.Төрдалай, Монгол-Германы соёл, боловсролын харилцаа: Монгол оюутан, сурагчид Герман Улсад суралцсан нь (1925-1930), Герман: Судалгаа, мэдээлэл сэтгүүл, Улаанбаатар, 1(3)2004, 99-100-р тал.

⁶¹ МАХН-ын V Их хурал, V боть, Улаанбаатар, 1981 он, 244-р тал.

⁶² УТА, Фонд № 6, данс-1, хадгаламжийн нэгж -153, хуудасны дугаар 4.

лсуудлыг хариуцуулахаар төлөвлөсөн нь ховор тохиолдол байлаа"⁶³ хэмээн хожим дурсан өгүүлсэн байдаг.

XX зууны шинэ Монгол Улсын аж үйлдвэр, техник технологийн салбарын эх үүсвэрийг тавилцахад Герман Улсаас уригдан ирсэн мэргэжилтэн сургагч нарын гүйцэтгэсэн үүргийг энд тэмдэглэхгүй өнгөрч болохгүй бөгөөд тухайн үеийн манай улсын улирдагчдын зүгээс ч Герман Улстай худалдаа, эдийн засгийн найрсаг харилцааг тогтоохын зэрэгцээ ирээдүйд БНМАУ-ын уг салбарыг авч явах шинэ чадварлаг боловсон хүчнийг Герман Улсад бэлтгэх алсын хараатай бодлого баримталж байсан нь энэ ажээ. Герман Улсад суралцсан монгол сурагчид ч энэхүү түүхэн үүрэг хариуцлагыг гүнээ ухамсарлан сайтар суралцаж манай улсын шинэ үеийн сэхээтнүүдийг оройлогчид байж түүхнээ нэрээ мөнхөлж чадсан бөлгөө.

БНМАУ дахь Герман Улсын хөрөнгө оруулалттай байгуулагдсан байгууламж, үйлдвэрийн газрууд

1921 оноос гадаадын хөрөнгө оруулалтыг татах замаар улсаас гарах хөрөнгө, хүчийг хэмнэх бодлого баримталж Засгийн газраас нарийн тогтсон журмын дагуу Герман зэрэг улстай худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоож тус улсын эдийн засгийн сонирхлыг Монголд бодитойгоор бий болгохыг чармайн ажиллаж байв. Энэ бодлого чиглэлийн дагуу Монгол-Германы харилцан хүчин чармайлтын үр дүнд 1926 оноос худалдаа, эдийн засгийн салбар дахь харилцаа өргөжин тэлж Герман Улсын хөрөнгө оруулалттай үйлдвэр, завод, байгууламжууд ашиглалтанд орж үйл ажиллагаагаа явуулах болсон төдийгүй манай улсын худалдаа, аж үйлдвэрийн зарим салбарт Герман Улсаас уригдаж ирсэн мэргэжилтнүүд ажиллах болжээ. Дурьдан буй үед БНМАУ нь Герман Улсаас доорхи чиглэлүүдээр хөрөнгө оруулалт, мэргэжилтэн боловсон хүчний шууд дэмжлэг авч байжээ.

Үүнд:

- *Цахилгаан, эрчим хүчний*
- *Мод, төмөрлөг боловсруулах*
- *Барилгын материал боловсруулах*
- *Хэвлэлийн үйлдвэрлэлийн*
- *Уул уурхай, ашигт малтмалын*
- *Авто тээвэр, шатахууны*

⁶³ S.M.Wolff, Mongolian Educational Venture in Western Europe (1926-1929), Zentralasiatische Studien 5(1971), 248-р тал.

зэрэг салбаруудыг тус тус багтааж болохоор байна.

Герман Улсын Засгийн газраас эрхлэн гаргаж байдаг “Геополитик” сэтгүүлийн 1928 оны дугаарт манай улсад уригдан ажиллаж байсан уурхайн хэлтсийн ахлах мэргэжилтэн, инженер Ф. Вейске “*Die wirtschaftlichen Verhältnisse in der Äußeren Mongolei*” тайлан илтгэлээ хэвлүүлсэн байна.⁶⁴ Уг илтгэлд 1925 оны БНМАУ-ын гадаад худалдааны салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтын эзлэх статитик хэмжээг тодорхойлсон байдаг.

Гэвч Ф. Вейскегийн тайлан илтгэл дэхь мэдээг МАХН-ын V Их хуралд НТХ-ны дарга Ц. Дамбадоржийн тавьсан илтгэлд гарч байгаа баримтуудтай харьцуулахад Германы пүүсүүдийн хөрөнгө оруулалтын хэмжээ болон бусад үзүүлэлтээр ихээхэн зөрөөтэй байгаа юм.⁶⁵

Мөн МАХН-ын V их хурлын эмхэтгэлд гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээг төгрөг(₮)-өөр тооцсон байгаа бол Ф. Вейске тайландаа мексик. доллар (\$) -аар тооцсон байна. Тухайн үед герман инженерүүдийн цалинг мексикийн доллараар бодож олгож байсан зэргээс үзвэл мексикийн доллараар тооцох явдал түгээмэл байсан байж болох талтай. Гэвч Ц. Дамбадорж мексик долларыг төгрөг гэж дурьдсан байж болох эсэхийг судалж тогтоох шаардлагатай байна. Үүний үндсэн дээр Монгол-Герман хоёр улсын хооронд худалдаа, эдийн засгийн харилцаа тогтохоос өмнөх зурвас үеийн манай улсын эдийн засаг дахь Германы капиталын оролцоо, эзлэх хувийн жинг бодитой тодорхойлон судлах ач холбогдолтой юм.

Юутай ч Баруун Европ руу худалдаа, эдийн засаг, соёл, боловсролын харилцаа тогтоохоор хандахаас өмнөх 1925 оны манай улсын гадаад, дотоод худалдааны нийт эргэлт 21 452 500 төгрөг байсны 60% гаруй буюу 12 921 000 төгрөгийг ЗХУ-аас гадна гуравдагч орнууд эзлэж байсан нь нэн өндөр үзүүлэлт юм.⁶⁶ Эндээс харахад ЗХУ дурьдан буй үед манай улсын эдийн засагт хүчтэй нөлөөтэй байж чадсангүй.

Үүнийг батлах нэгэн түүхэн баримт бол 1926 оны V сарын 15 нд хуралдсан БХК(б)Н-ын Төв Хорооны Улс төрийн товчооны Монголын комиссын 2-р хуралдааны маш нууц тогтоолд заахдаа “... ЗСБНХУ

⁶⁴ Fritz Weiske, Die wirtschaftlichen Verhältnisse in der Äußeren Mongolei. Geopolitik /Wiesbaden/ 1928, 162-р тал.

⁶⁵ МАХН-ын V Их хурал, V боть, Улаанбаатар, 1981 он, 44-р тал.

⁶⁶ Мөн тэнд.

Монголд эдийн засгийн талаар нэвтэрсэн нь бага, Монголын барааны эргэлтэд Зөвлөлт Улсын оролцох явдал өсөж нэмэгдэх нь удаашралтай байгаа явдал Монголд гадаадын капитал эдийн засгийн талаар нэвтрэх бүх бололцоог нээж, энэ нь Монголд манай улс төрийн ололтыг сулруулахад дэм өгч болзошгүйг харгалзан Бүгд Найрамдах Монгол Улстай манай эдийн засгийн хэлхээ холбоог зохицуулан бэхжүүлэх..." хэмээн үйл ажиллагааныхаа гол зорилтоо болгон дэвшүүлж байснаас тодорхой харагдаж байна.

Дурьдан буй үеэс ЗСБНХУ манай улсын эдийн засгийн дахь хоёрдагч орнуудын оролцоог шахан гаргах замаар өөрийн байр сууриа бэхжүүлэх асуудалд анхаарал хандуулах болжээ.

Инженер Ф.Вейскегийн тайлан илтгэл дэхь статистик тоог дор хүснэгтээр үзүүлвэл:

Хүснэгт № 1

(Гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ 1925 оны байдлаар)

1. Цахилгаан, эрчим хүчний салбар

№	Хөрөнгө оруулагчид	Хөрөнгө оруулалтын хэмжээ (мексикийн доллараар)	Эдийн засагт эзлэх хувийн жин
1.	Оросын Засгийн газрын хөрөнгө оруулалт	1 267 000	
2.	Оросын хувийн пүүсүүдийн хөрөнгө оруулалт	704 500	
3.	ЗХУ-ын нийт хөрөнгө оруулалт – 1 971 500		10, 4%
4.	Хятадын 283 пүүс	7 248 000	
5.	Германы 3 пүүс	173 000*	
6.	Америкийн 5 пүүс(?)	560 000	
7.	Английн 10 пүүс	4 500 000	

8.	Оросоос бусад орнуудын хөрөнгө оруулалт- 12 481 000	65, 9 %
9.	Монголын Төв хоршоо	3 000 000
10.	Монгол банк	1 500 000**
11.	Монголын хөрөнгө оруулалт – 4 500 000***	23, 7 %

Нийслэл Хүрээнд цахилгаан эрчим хүч түгэн дэлгэрсэн тухай түүхийг сөхөн үзвээс 1917 онд анхны жижиг цахилгаан станцыг Герман Улсын Кода фирмээс Шанхай, Манжуураар дамжуулан худалдан авч байсан тухай Сангийн яамнаас Дотоод яамнаа албан хуудсаар мэдэгдэж байсан баримт байна.⁶⁷ Уг станцын хэрэгцээт тоног төхөөрөмжийг Оросоос худалдан авч хүчин чадлыг нь нэмэгдүүлэн иргэдэд цахилгаан түгээж байсан түүхэн баримт байна.

Энэ станцад ажиллаж байсан Унгарын харъяат Иосиф Глета нь 1925 оны V сарын 30-ны өдөр дугаар № 728 тоот албан бичгээр Харилцан Туслалцах Хоршооны Ерөнхий Хороонд өргөсөн бичигтээ Тяньжин хот дахь Герман Улсын “Кода” фирмээс станцад шаардлагатай мегометр (газар хэмжигч), цахилгаан самбар, кабель утас, лонх, төмөр дэгээ, хөндийрүүлэгч материал (изоляция), таслуур, гал хамгаалагч зэрэг багаж хэрэгслийг станцын дарга Жанцансамбуугийн хамт явж худалдан авч ирсэн тухайгаа дурьдаад тэдгээрийн төлбөр 3500 янчааныг төлөхийг хүссэн байна.⁶⁸ Тухайн үед Ардын Засгийн газрын өмнө тулгамдаж байсан шийдвэрлэвэл зохих чухал асуудлын нэг нь байгууллага, иргэдийг цахилгаан, эрчим хүчээр хангах явдал байсан бөгөөд 1925 оны XI сарын 23-ны өдрийн Засгийн газрын 142-р хурлын шийдвэрээр Цахилгаан Гэрлийн Хороог шинэчлэн байгуулах асуудлыг яаравчлахыг Аж Ахуйн яамнаа даалгасан байна.⁶⁹

Ийнхүү 1926 оны эхээр Нийслэл Хүрээнээ бүрэн ашиглалтанд орсон энэхүү хоёр дахь цахилгаан станц нь локомотивиор ажиллах, 30 квт чадалтай генератор нэг, 90 квт чадалтай генератор нэг, нийтдээ 120 квт-ын хүчин чадалтай байжээ. Улмаар 1928 оноос Засгийн газраас

⁶⁷ Я.Намсрай, Монголын цахилгаан эрчим хүчний салбарын түүхэнд холбогдох зарим материалууд, Улаанбаатар, 1997, 72-р тал.

⁶⁸ Мөн тэнд, 25-р тал.

⁶⁹ Мөн тэнд, 74-р тал.

цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийг ергөжүүлэн хөгжүүлэхэд илүү ихээр анхаарах болж Ерөнхий сайд Б. Цэрэндоржийн дэмжлэгтэйгээр 1928 оны V сарын 25-ны өдөр Герман Улсын Берлин хот дахь А.Е.Г фирмтэй гэрээ байгуулан 500 киловатт чадалтай дулааны цахилгаан станц, түүний сэлбэг хэрэгслийг захиалан авчруулахаар хэлэлцэн тохиролцож Улаанбаатар хотноо хоёр тал гарын үсэг зурж батлагаажуулсан байна.⁷⁰

Уг хэлэлцээрийг байгуулахад манай талаас Аж Ахуйн яамны Цахилгаан Гэрлийн Ерөнхий хорооны дарга Пүрэвжав, Германы талаас станцын барилгын ерөнхий инженер Камерер нар оролцжээ. Энэ гэрээнд тусгагдсан нөхцлүүдийг дор авч үзвэл А.Е.Г фирмийн зүгээс Германаас тээвэрлэн авчирах, байрлуулах, угсрах, ашиглалтанд өгөх, 6 сарын хугацаатай мэргэжилтэн урьж ажиллуулах зэрэг бүх баталгааг зааж өгсөн бол манай Засгийн газраас станцын үнэ болох 75. 000 ам. долларыг гэрээнд заасан ёсоор гурав хувааж хугацаандаа төлөх үүрэг хүлээсэн байна.⁷¹ Мөн гэрээнд тусгагдснаар цахилгаан станцыг 1929-1931 онд барьж дуусгахаар заасан байна. Энэхүү станц нь хүчин чадлын хувьд тэр үедээ хамгийн өндөрт тооцогдож байв. Мөн энэ станцтай цуг 6 төрлийн машин, аппаратыг тус фирмээс 1928 оны VI сарын 15-ны дотор ирүүлэхээр тохиролцсоны тул хил, гаалийг саадгүй нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг ГЯЯ-ны эрхэлсэн түшмэл Чогдонжамбаа ЗХУ-д суугаа элчин сайдад мэдэгдэж байв.⁷² Энэ үед Цахилгаан Гэрлийн Ерөнхий хороонд урилгаар ажиллаж байсан Герман Улсын харъяат инженер Хамир Эрист бүрмөсөн нутагтаа буцах болсон ба түүнийг хил гаалиар саатуулахгүй өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг Цахилгаан Гэрлийн Ерөнхий хорооноос ГЯЯ-нд 1928 оны V сарын 28-ны өдөр № 71 албан тоотоор мэдэгдэж хүсчээ.⁷³

Засгийн газар болон А.Е.Г фирмүүдийн хооронд байгуулсан гэрээ ёсоор дээрхи станцыг ажиллуулах хугацааг түргэвчилэх зорилгоор Аж Ахуйн яам, ГЯЯ-аас ЗХУ дахь элчин сайдын яаманд хилээр саатуулахгүй нэвтрүүлж ирүүлэх асуудлаар удаа дараа албан тоот

⁷⁰ С.Идшинноров, Хот суурины хувийн хэвшлийн хөгжил, хувьслын асуудалд /1921-1960, Түүхийн ШУ-ны дэд доктор /Ph.D/-ын зэрэг горилсон бүтээл, Улаанбаатар, 1993, 48-р тал.

⁷¹ УТА. Фонд № 359, данс- 1, хадгаламжийн нэгж 32.

⁷² МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6. Монгол-Германы харилцааны данс-3 II, хуудасны дугаар 4.

⁷³ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6. Монгол-Германы харилцааны данс-4, нугалбар № 2.

явуулж харилцаж байсан баримт байх юм. Учир нь цахилгаан станц, түүний холбогдох тоног төхөөрөмжийг Герман Улсаас ЗХУ-ын нутгаар дамжуулан тээвэрлэж авчирахаас өөр аргагүй байсан ба ЗХУ-ын холбогдох албан газраас зайлгүй зөвшөөрөл авах шаардлагатай байжээ. Иймээс ГЯЯ-аас 1928 оны XI сарын 11-ний өдөр ЗХУ дахь БНМАУ-ын элчин сайдад, мөн БНМАУ дахь ЗХУ-ын элчин сайд нарт дугаар № 1162 албан бичгээр тус тус мэдэгджээ. Энэ нь уг асуудалд улсаас өндөр ач холбогдол өгч байсныг бэлхнээ харуулж байгаа юм. Эцэст нь ЗХУ дахь БНМАУ-ын элчин сайдаас уг асуудлаар холбогдох газруудад хандсаны дагуу зохих зөвшөөрлийг авч чадсан учир Герман Улс дахь БНМАУ-ын Худалдааны төлөөлөгчийн газарт мэдэгдсэн тухайгаа ГЯЯ-ны орлогч сайд Буянчуулганд № 262 цахилгаан мэдээ илгээн дурьдсан байна. Сайд Буянчуулган уг шийдвэрийг 1928 оны XII сарын 15-нд № 1534 тоотой Аж Ахуйн яамнаа албан ёсоор мэдэгджээ.⁷⁴

Гэсэн хэдий ч уг станцыг Монгол руу явуулах үйл ажиллагаа удааширч байсан тул Гадаад Явдлын яамнаас сайд Гүрсэд 1929 оны IV сарын 9-ны өдөр № 356 тоотой ЗХУ дахь элчин сайдын яаманд дахин мэдэгдсэн байна.⁷⁵

ГЯЯ-аас 1929 оны 4 сарын 9-нд № 258 тоотой Аж Ахуйн яаманд явуулсан албан бичигт дурьдснаас үзвэл станцыг Монголд тээвэрлэн авчирах үйл ажиллагаанд элдэв хүндрэл учирсаар байжээ. Ийнхүү олон дахин албан бичиг явуулж хөөцөлдсөний эцэст дээрхи станцыг 1930-иад оны эхээр холбогдох хэрэгслийн хамтаар Москва, Улан-Үд хотуудаар дамжуулан хүлээн авсан байна.

Одоо энэ салбарт Германаас уригдан ирж ажиллаж байсан мэргэжилтнүүдийн талаар авч үзье. Цахилгаан Гэрлийн Ерөнхий хороонд урилгаар ажиллаж байсан инженер Хамир Эрист нутаг буцсан тул⁷⁶ цахилгаан, эрчим хүчний үйл ажиллагааны жигд байдлыг хангахад мэргэжилтэн, боловсон хүчний дутагдалтай болсон нөхцөл байдлыг харгалзан үзэж Герман Улсын Берлин хот дахь *“Цахилгааны кампани”*-тай 1928 онд гэрээ байгуулан монтёр Антон Вехерийг Аж

⁷⁴ Мөн тэнд, 7-р тал.

⁷⁵ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6, хадгаламжийн нэгж 6, хуудасны дугаар - 2.

⁷⁶ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6. Монгол-Германы харилцааны данс- 4, нугалбар № 2.

Ахуйн яамны албан ёсны урилгаар Цахилгаан Гэрлийн Ерөнхий Хороонд ажиллуулахаар тохиролцжээ. Монтёр Антон Вехер 1930 оны V сарын дундуур Монголд хүрэлцэн ирэх төлөвлөгөөтэй байсан тул түүнд дэмжлэг үзүүлж хил нэвтрэх виз олгохыг Аж Ахуйн яамны сайд Г. Содномоос ГЯЯ-аар дамжуулан Москва дахь БНМАУ-ын элчин сайдад уламжилжээ. Берлин хот дахь “Цахилгааны кампани”-д Москва дахь элчин сайдаас 1930 оны IV сарын 10 нд монтёр Антон Вехерийг БНМАУ руу урилгаар ирүүлэх асуудлаар цахилгаан мэдээгээр харилцсан ба үүний хариуд тус кампаниас 1930 оны V сарын 2-ны өдөр № 165 тоот цахилгаан мэдээ илгээн дурьдахдаа:

“Телеграмма из Берлина от Всеобщей Ко Электричества/ Берлин хот дахь “Цахилгааны Компани” хэмээх хоршооны энэ оны таван сарын хоёрны өдрийн арван таван тоот цахилгаан мэдээ

Таны IV сарын 10-ны өдрийн цахилгаан мэдээг авав. Монтёр Антон Вехер болбоос Герман улсын харъяат хүн бөгөөд Монгол газар одоохуйд Оросын элчин сайдаас зөвшөөрөл авч гүйцэтгэвээс зохих хэмээх тул эл зөвшөөрлийг хүсмүй.

Электрон”⁷⁷

гэсэн байна. Мөн ДЯЯ-ны сайд Х. Чойбалсангаас 1930 оны V сарын 19-нд № 261 тоотор ЗХУ дахь Элчин сайдын яамнаа дахин албан бичиг явуулсан ба энэ бичигт “... Машинд чухал хэрэглэгдэх албан хаах Герман улсын харъяат Антон Вехерийн биеийг нэвтрүүлэн ирүүлэхийг зохих газар лугаа харилцаж гүйцэтгүүлмүй хэмээх учрыг дурьдсан үүний улмаар эрхэм элчин сайдын яамнаа явуулаад гуйх нь, мөнхүү Антон Вехерийн биеийг нэвтрүүлэн ирүүлж уул хөдөлгүүлэн явуулах ажилд гүн тусламжийг үзүүлэхийг итгэмжлэн бүрэн хүндэтгэснийг хүлээн авахыг хүсмой.

Сайд Чойбалсан”⁷⁸

гэжээ.

Антон Вехер нь хоёр талын тохиролцооны дагуу Цахилгаан Гэрлийн Ерөнхий хорооны станцыг суурилуулан тавьж ажиллуулах үүргийг хүлээж байжээ.

Тухайн үед Засгийн газраас баримтгijж байсан бодлогын дагуу дулааны станцыг Аж үйлдвэрийн комбинатын зарим үйлдвэрүүдийн

⁷⁷ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6, хадгаламжийн нэгж 6, хуудасны дугаар - 18.

⁷⁸ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6, хадгаламжийн нэгж - 6.

хамтаар 1931 оны VIII сард тохируулга, туршилтыг хийж дуусгаад ажиллуулж эхлэсэн байна.⁷⁹ Тоног төхөөрөмжийн хувьд Герман Улсын Тигел заводад 1928 онд үйлдвэрлэсэн ЗВГ хэв маягийн 22 атмосфер даралттай цагт 350-400°C халуун, 12 тонн уур боловсруулдаг 2 зуух, Англи улсад усан онгоцны зориулалтаар үйлдвэрлэсэн уурын машин, мөн 60 герц үелзэлтэй, тус бүр 250 квт чадалтай, гурван фазын, 525 вольтын хүчдэлтэй Германы Сименс-Шуккерт заводын 2 ширхэг цахилгаан гаргагч генератор, 1909 онд мөн улсад үйлдвэрлэсэн А.Е.Г хоршооны дулааны цахилгаан станцууд тус тус багтаж байлаа.

Энэ үеэс нийслэлчүүдийн дунд “Дунд голын чийдэн хороо” нэрээр танил болсон уг станц ажиллаж эхлэсэн байна. Станцын анхны дизельчинээр Германд суралцагчдын нэг Самбуугийн Лувсанцэнд ажиллаж байв. С. Лувсанцэнд нь мөн 1934 онд хожмын Хонхорын радио станцын эх үндэс болох 255 квт хүчин чадалтай Уушин дэнгийн радио станцыг⁸⁰ ажиллуулан Нийслэлийн Консулын дэнж, Улаанхуаран, Американ хашаа зэрэг газрыг хэрэглэгчдийг гэрэл, цахилгаанаар хангах ажлыг гардан гүйцэтгэж байсан ажээ.

Ийнхүү Герман Улсын мэргэжилтэн, боловсон хүчин, техник, тоног төхөөрөмжийн шууд дэмжлэг туслалцаатайгаар Улаанбаатар хотын цахилгаан, шугам сүлжээний газрын тулгын чулууг тавьжээ.

2. Мод, төмөрлөг боловсруулах салбар

1926 оны VIII сарын 27-ны өдөр хуралдсан Засгийн газрын 34-р тогтоолын 3-р зүйлд “Төмөр, модны зэрэг үйлдвэрийн газар” нээн байгуулах учир энд хэрэглэгдэх машин хэрэгсэл ба боловсронгуй сургагч (мэргэжилтэн) хүмүүсийг урин ирүүлсэн хойно уул үйлдвэрийн

⁷⁹ Я. Намсрай, Улаанбаатар хотын цахилгаан станц, цахилгаан шугам сүлжээний товч түүх, гар бичмэл.

⁸⁰ Энэ дулааны цахилгаан станцыг 1931-1924 онд “Дунд голын чийдэн хороо”, 1934-1964 онд Төв Цахилгаан комбинат, 1964-1977 онд Төв Цахилгаан станц, 1977 оноос Нэгдүгээр Цахилгаан станц гэж тус тус нэрлэжээ.

⁸¹ Ахмад холбоочин С.Лувсанцэнд гуайн дуртгалаас үзвэл Уушин дэнгийн радио станц нь анх 1910-иад оны үед Дани улсын харъяат нар Монголын Хиагт-Чуулалт Хаалганы чиглэлээр төмөр утсан шугамыг тавьснаар байгуулагдсан ба эхний үед 10 квт-ын хүчин чадалтай жижиг станцаас радио, телефоны ажиллагааг явуулж ихэвчлэн оройн цагаар цөөн тооны газрыг цахилгаан гэрлээр хангаж байжээ. Гэвч Уушин дэнгийн радио станц нь 1960-иад онд Хонхорын радио станцыг байгуулах хүртэл үүргээ гүйцэтгэн ажилласаар байжээ.

цалин, зардал зэргийг төлөвлөн батлуулбаас болох эсэхийг зохих газар явуулсанд УБХ-д хэлэлцэж ёсоор болгон баталсан” тул Герман Улсын хөрөнгө оруулалтаар “Төмөр, модны үйлдвэрийн газар”-ыг байгуулахаар заасан байна. Төмөр, модны үйлдвэрийн газар нь (Төмрийн завод гэдэг нэрээр олонд илүү танил болжээ. Р.Т) 1927 оны VI сарын 28-нд албан ёсоор ашиглалтанд орж үйл ажиллагаагаа явуулж эхлэжээ. Төмрийн завод нь газар зүйн байрлалын хувьд хуучин Цогтбадамжавын хашаа, байшингаас баруун урагш 100-иад метрийн зайд өдгөө ч буй Ардын Засгийн газрын анхны ажлын байр байрлаж байсан байшингийн орчим буюу тодруулбал өнөөгийн Бөхийн Өргөө орчим байжээ.

Төмрийн завод нь 1930-иад оны дундуур Монгол тээхийн удирдах газартай нэгдэн өргөжиж герман маркийн хоёр дизель, токарь зэрэг багаж төхөөрөмжтэй, халуун төмөр, ширэм хайлах, мод урлал, банз хатаах, шалгах лаборатори зэрэг хэсэг, тасагтай болж үйл ажиллагаа нь өргөжив. Ийнхүү Төмрийн заводыг анх Герман Улсын техник, тоног төхөөрөмжөөр тоноглож зөвхөн ширэм хайлуулан цутгах бус автомашины мотор засах, хөдөө, аж ахуйн ба бусад өргөн хэрэглээний сэлбэг засварыг хийх, иргэдийн ахуйн хэрэглээний барааг үйлдвэрлэн гаргаж байв. Төмрийн заводод Герман Улсын харъяат зүтгүүрийн инженер Карл Шварце, мод боловсруулах машины мастер Альфенс Бейнлих нар урилгаар ажиллаж байлаа.⁸⁰ Төмрийн завод нь байгуулагдсан цагаасаа Герман Улсын харъяат Вилгельм Дорнтойд албан ёсны гэрээ хэлэлцээ байгуулан чухал шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг Хятадаас авчируулж байсан санхүүгийн баримт материал Үндэсний Түүхийн Архивт цөөнгүй байна. Мөн В. Дсрн ч энэ тухайгаа Засгийн газарт 1929 оны V сарын 21-нд бичсэн өргөдөлдөө тодорхой дурьдсан байдаг.⁸¹

Төмрийн заводад Герман Улсын мэргэжилтэн, боловсон хүчин ажиллахаас гадна Швед Улсын харъяат нар ч ажиллаж байсан мэдээ баримт байгаа бөгөөд Д. Нацагдорж Германаас ирснийхээ дараа 1929 оны хавраас 1930 оны хавар хүртэлх хугацаанд уг заводад хэлмэрч хийж байв.⁸² Төмрийн завод нь 1931 онд түймэрт өртөж нилээд их хэмжээний хохирол үзсэн ба машин, техник тоног төхөөрөмжүүдийн ихэнх нь бүрэн шатсан тул дахин сэргээхэд их хүндрэлтэй байжээ.

⁸⁰ УТА. Фонд № 359, данс -1, хадгаламжийн нэгж – 282.

⁸¹ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6, Монгол-Германы харилцааны данс- 2, хуудасны дугаар № 7.

⁸² С.Лочин, Дашдоржийн Нацагдорж: ХХ зууны монгол зохиолчид, vol. I, Улаанбаатар, 2000, 8-р тал.

Өдгөө ч Төмрийн заводад хэрэглэж байсан Герман Улсын техник, тоног төхөөрөмжүүдийн хэсгүүд үлдэж хоцорсон бөгөөд шинжин үзвэл Төмрийн заводод Германаас нилээд их хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэж байсныг мэдэж болох юм.

Гэвч миний бие энэхүү хөрөнгө оруулалтын тухайд холбогдох албан ёсны бичиг баримтыг өнөө хир олж чадаагүй байна.

3. Барилгын материал боловсруулах салбар

Герман Улстай хамтран ажиллаж байсан өөр нэгэн чухал салбар бол барилгын материалын үйлдвэрлэл байжээ. Анх 1925 онд Герман Улсад худалдааны төлөөлөгчдийг явуулахад Засгийн газраас барилгын материалын үйлдвэрлэлийн салбарт тус улсын пүүс, фирмүүдтэй холбоо харилцаа тогтоож мэргэжилтэн, боловсон хүчнийг урин ирүүлэх, Германд энэ чиглэлээр оюутан сургах асуудлыг судалж шийдвэрлэхийг Сампилон, Хурлат нарт албан ёсоор хариуцуулсан юм.

Энэ айлчлалын явцад барилгын инженер К. Геринг, Дебель нарыг урин ирүүлж ажлуулахаар тохиролцсон байна. Инженер К. Геринг нэгэн удаа бичихдээ “... *Би Швейцарын коммунист намын санал болгосны дагуу ирсэн*” гэсэн нь зарим мэргэжилтнүүдийг Монгол руу явж ажиллахад тухайн орны намын байгууллага зуучилан дэмжлэг үзүүлж байсан бололтой.⁸³ Барилгын материал үйлдвэрлэлийн боловсронгуй технологийг бий болгож, тухайн үед нэн дутагдалтай байсан барилгын хэрэгцээт материалыг үйлдвэрлэн гаргах үйлдвэр байгуулах зорилгоор 1926 оны II сарын 14, 17-нд тус тус тохиролцсоны дагуу Герман Улсын Вюртемберг дэхь “*Карл Хендлэ & Санс*” фирмээс тоосгон заводыг нээхэд шаардлагатай бүх техник, тоног төхөөрөмжийг худалдан авахаар тохиролцжээ.⁸⁴

Герман Улсын “*Карл Хендлэ & Санс*” фирмээс тоосгон заводод хэрэглэгдэх шороо татагч машин 1 ширхэг, хэмжигч машин 1 ширхэг,

⁸³ С.Идшинноров, Хот суурины хувийн хэвшлийн хөгжил, хувьслын асуудалд /1921-1960/, Түүхийн ШУ-ны дэд доктор /Ph.D/-ын зэрэг горилсон бүтээл, Улаанбаатар 1993, 44-р тал.

⁸⁴ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6, хадгаламжийн нэгж 6, хуудасны дугаар - 19.

шороо хутгагч машин 1 ширхэг, тоосго зүсэгч 350 миллиметрийн машин 1 ширхэг, хэвлэгч машин 25 ширхэг, байшингийн дээврийн тоосгоны машин 1 ширхэг, бешикер 1 ширхэг гэх мэт багаж хэрэгслийг тус фирмээс санал болгосны дагуу худалдан авсан ба тэдгээрийг суурилуулан ажлуулахаар мөнхүү гэрээт инженер К. Геринг хүрэлцэн ирсэн байна.

Инженер Геринг зохих тохируулга, засварыг хийсний дараа Худалдаа ба Аж ахуйг яаманд Тоосгон заводыг 1929 оны IX сард албан ёсоор хүлээлгэн өгчээ. Гэсэн хэдий ч анх хоёр талын тохиролцсоны дагуу Тоосгон завод нь бүрэн хүчин чадлаараа ажиллаж өдөр тутам 8 цагийн дотор 12000-15000 ширхэг тоосго үйлдвэрлэх хүчин чадалтай байхаар заасан ба инженер К. Геринг 1930 оны ажлын төлөвлөгөөгөө хийхдээ өдөр тутам 8 цагийн дотор 24000 ширхэг, хоёр ээлжээр ажилласан нөхцөлд 30000 ширхэг түүхий тоосго үйлдвэрлэн гаргахаар тогтсон ба жилд барагцаалбал 9 000 000 ширхэг түүхий тоосго үйлдвэрлэн гаргах тухай дурьдсан байна. Эндээс үзвэл тоосгон завод нь тухайн үедээ манай улсын барилгын материалыг бүрэн хангаж чадахуйц томоохон үйлдвэр байсан нь харагдаж байна.

Харин 1930 оны сүүлээр Худалдаа ба Аж ахуйн явдлын яамнаас хийсэн шалгалтаар Тоосгон заводын зарим техник, тоног төхөөрөмж эвдэрч муудсаны улмаас үйлдвэрлэл шаардлагатай хэмжээнд явагдаж чадахгүй хоёр талын хооронд байгуулсан гэрээ, хэлэлцээ зорчигдож байгааг дурьдсан байна. Энэ тухай ХААЯЯ-ны сайд Равдан, эрхэлсэн түшмэл Жанчив нараас ГЯЯ, ЗХУ дахь Худалдааны төлөөлөгчийн газраар дамжуулан Герман Улсын “Карл Хендлэ & Санс” гэрээт фирмийн удирдлагад албан мэдэгдэл явуулж байсан байна.

Уг албан мэдэгдэх хуудсанд бичихдээ “... Өдөр тутмын 8 цаг ажиллаж 12-15 мянган туйпуу гаргах буюу өдөр тутам хоёр ээлжээр ажиллах аваас 24 буюу 30 мянган туйпуу гаргаж болох атал бариулсан пийшин нь 24 цагийн дотор зөвхөн 9 мянган туйпуу гаргах нь завсар хүч үл хүрэлцэхийн улмаас мөн заводын дотор цаг зуурын пийшин 5-ыг үйлдэхэд хүрсэн энэ мэт пийшин хэрэглэх түлш үлэмж болохын дээр энэ явдлууд болбоос танай төлөөлөгч боловсролгүй болох ба ер инженер хэмээхэд нэн бэрхтэй болохоос гадна уул машин

* Энэ албан мэдэгдлийг монгол бичгийн машинаар бичиж бүрэн эхийг орос хэлнээ орчуулан ард нь хавсаргажээ.

багаж нь ийнхүү түргэнээр элэгдэж хуучирсныг үзвээс угаас чанараар сайнгүй байсныг илэрхий болгомог”⁸⁵ гэжээ.

Ийнхүү инженер К. Герингийн ажлын байдал болон Тоосгон заводын зарим багаж хэрэгслийн элэгдэл, хорогдлын улмаас манай тал Герман Улсын дээр дурьдсан пүүсэд гомдол гаргаж хариу шийдвэрлүүлэхийг оролдож байсан ч зохистой ямар хариу авсан нь тодорхойгүй байна. Манай талаас үйлдвэрлэлийг хэвийн ажиллуулах талаар өртөг, зарлага их гаргаж байсан учир ийнхүү гомдол мэдүүлсэн бололтой. Мөн үүнээс өмнө тоосгон заводын барилгын ажлыг хурдан дуусгах талаар Зөвлөлтийн инженер Ле-Дантю, Германы инженер К. Геринг нарын хооронд зөрчилдөөн гарч байсан ба Аж ахуйн яамны сайд, Намын Төв хорооны орлогч дарга Н. Жадамба, Д. Сампилон, М. И. Амагаев нар очиж зохицуулж байсан байна.⁸⁶

Мөн Засгийн газраас барилгын материал үйлдвэрлэх заводыг нээн ажлуулахын сацуу уг салбарт ажиллах үндэсний мэргэжилтэн, боловсон хүчнийг бэлтгэх шаардлагыг үүднээс дээрхи өргөн харилцаа бүхий Герман Улсын Штутгарт (*Stuttgart*) хотын ойролцоо Мюлакерт Хэндли & Санс фирмийн тоосгоны завадад хоёр оюутныг суралцуулж байжээ. Иймээс Мюлакерт Хэндли & Санс- фирм нь манай улсын Засгийн газартай худалдаа, эдийн засгийн төдийгүй боловсрол, сургалтын талаар ч өргөн харилцаатай байсан Герман Улсын томоохон түншлэгч байжээ.

С. М. Вольф хожим 1964 оны хавар Хааны Төв Азийн сэтгүүлд нийтлүүлсэн *“Баруун Европ дахь Монголын боловсролын зоримог үйл хэрэг”* хэмээх өгүүлэлдээ энэ тухай *“... Бас хоёр оюутан тоосго үйлдвэрлэх ажиллагаанд бэлтгэгдэж байв. Энэ бол Монгол Улсын Засгийн газрын онцгойлон анхааралдаа авч сонирхож байсан үйл ажиллагаа байсан төдийгүй Худалдааны Төлөөлөгчийн газраар дамжуулан тоосгоны үйлдвэр байгуулахаар төлөвлөсний дагуу тоног төхөөрөмжийг худалдан авч байлаа”⁸⁷* гэж дурсан тэмдэглэсэн байдаг.

Иймээс Герман Улстай энэ салбарт хамтран ажиллах нь манай Засгийн газрын урьдаас төлөвлөсөн, үндсэн зорилт байсан ажээ.

⁸⁵ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6, хадгаламжийн нэгж 6, хуудасны дугаар - 19.

⁸⁶ Коминтерн ба Монгол (Баримтын эмхтгэл), Улаанбаатар, 1996, 159-р тал.

⁸⁷ S.M.Wolff, *Mongolian Educational Venture in Western Europe 1926-1929*, *Zentralasiatische Studien* 5(1971), 270-р тал..

4. Хэвлэлийн үйлдвэрлэлийн салбар

1926 оноос хэвлэлийн үйлдвэрийн салбарыг шинэ техникээр тоноглох, мэдлэг чадвартай мэргэжилтнүүдийг ажиллуулан ажлын бүтээмжийг дээшлүүлэх, Монгол Хэвлэлийн хороог (*Монгол пресс*) байртай болох зэрэг ажил өрнөсөн байна. Засгийн газраас хэвлэлийн үйл ажиллагааг боловсронгуй, болгож өргөтгөхөд зориулж 300 000 төгрөгийн хөрөнгийг арван жилийн хугацаагаар зээлээр гарган өгсний дагуу Герман Улсын харъяат барилгын инженер Дебель, Зөвлөлтийн инженер Барановски нарын зураг төслөөр Хэвлэлийн хорооны байшинг өргөтгөн тоосгон байшин нэмэн бариулж 1929 онд ашиглалтанд оруулсан байна. Хэвлэлийн хороог ийнхүү нэмэн өргөтгөсний учир гэвэл 1926 онд Шанхай хот дахь Герман Улсын “*Siemens*” пүүсээс авахаар тохиролцож захиалсан машин техник, зургийн тор зэрэг хэрэгсэл 1927 онд Монголд үйл ажиллагаагаа явуулж байсан Германы “*Востваг*” нэгдлээр дамжин ирсэн тул хуучин байшинд байрлуулж багтахгүй болсонтой холбоотой ажээ.

Тухайн үеийн Монгол Хэвлэлийн хороо (*Монгол пресс*)-ны техник хэрэгсэл нь Германы хоёр эргэлтийн том хэмжээний “*Винклер*” машин 3 ширхэг, зогсдог цилиндртэй “*Штурмфоголь*” машин 2 ширхэг, “*Американк*” гэдэг жижиг тигель машин 2 ширхэг, бага офсет машин 1 ширхэг ажиллаж 30-иад нэр төрлийн номыг 3000-5000 хувиар хэвлэн гаргаж байлаа.⁸⁸ Монгол Хэвлэлийн хороо (*Монгол пресс*)-ны анхны мэргэжилтэн, сургагч нар Герман Улсын харъяат нар байсан бөгөөд анх Ардыг Гэгээрүүлэх яаманд номын санч хийж байсан байсан Зөвлөлтийн харъяат Курт Альферевич Кавельмахер нь 1927 оноос тус хороонд ажиллаж Монгол Улсад хэвлэлийн үйл ажиллагааг хөгжүүлэхэд их зүйл хийсэн тул тухайн үедээ нэр хүндтэй ажилтан байжээ. Манай улсын хэвлэлийн ахмад ажилчдын нэг соёлын гавъяат ажилтан Ч. Содов гуайн дурсан бичсэнээр “... Сургагч Курт Альферевич Кавельмахер нь “*Востваг*” пүүстэй үргэлжийн харилцаатай, албан бичгийн нэг ширээ ч тэднийд байдаг байсан.”⁸⁹ гэснээс үзвэл Курт Альферевич Кавельмахер нь ажлын хажуугаар Германы “*Востваг*” нэгдэлд орон тооны албан ажил хаших хэмжээнд ажиллаж байжээ.

⁸⁸ Номын ууган орд (Дуртгалын эмхтгэл), Улаанбаатар, 1972, 19-р тал.

⁸⁹ Номын ууган орд (Дуртгалын эмхтгэл), Улаанбаатар, 1972, 41-р тал.

1928 онд тус хороонд дутагдалтай байгаа мэргэжилтэн, боловсон хүчний байдлыг харгалзан үзэж Шанхайгаас Герман инженер Барторын тэргүүлсэн дөрвөн хятад ажилчинг урин ирүүлж ажиллуулж байв. Герман инженер Бартор нь өндөр хэвлэлийн машины мэргэжилтэн байсан ба дөрвөн хятад ажилчид нь чулуун барын ажилчид байжээ. Энэ тухай Я.Цэвэл гуай хожим дурсан бичихдээ "... Мэргэжилтэй ажилчны талаар шинэ ирсэн машин дээр ажиллуулахаар хэвлэлийн мэргэжилтэй хятад дөрвийг Шанхайгаас авч ажиллуулсан ба гадаадад хүн явуулж Германд Баатарсэнгэ, Лувсаннамжил нарыг сургуулилах, дотоодод сурах хүмүүсийн сонирхлыг дагуулан мэргэжилтэй ажилчдыг дагалдуулан сургаж байснаас гадна 1928 оны сүүлчээс эхлэн 20-50 сурагчидтай хэвлэлийн мэргэжлийн түр сургууль жил дараалан байгуулан бэлдэж байсан юмаа"⁹⁰ гэжээ.

Я. Цэвэл гуайн энэхүү дурсамжтай холбоотой архивийн нэгэн түүхэн баримт байгаа нь 1928 оны V сарын 24-нд БНМАУ-ын Дотоодыг Хамгаалах газраас ГЯЯ-нд явуулсан № 274 тоот албан бичигт дурьдсанаар Хэвлэлийн хороонд ажиллах зорилгоор ирэх Герман Улсын мэргэжилтэн Барторыг дөрвөн шанхай иргэдийн хамтаар хил гаалийг саадгүй нэвтрүүлэхийг хүссэн байна.⁹¹ Мөн Я. Цэвэл гуай дуртгалдаа "...шинжлэх ухаан сурах, суралцах бичигт хэрэглэгдэх байгал түмэн бодисын хэв барыг Германаас тусгай захиалгаар худалдан авч ирүүлэх зэргээр тухайн үеийн бололцоог харгалзан гүйцэтгэж байсан билээ"⁹² хэмээн өгүүлжээ.

Манай улсын Засгийн газраас авч хэрэгжүүлж байсан зохистой төлөвлөгөөний дагуу Герман Улсын Лайпциг хотын хэвлэл газарзүйн зургийн *Wagner & Debes* пүүст дадлагын ажил хийхээр Аюурзана, Лувсандамдин нарын хоёр сурагч, мөн тус хотын *Arno Pries & I. B. Hirschfeld* гэдэг хэвлэлийн пүүст Баатарсэнгэ, Лувсаннамжил нарын хоёр сурагчыг 1926 оноос суралцуулж байв. Энд нэгэн сонирхолтой баримт дэлгэхэд Аюурзана, Лувсандамдин нарын суралцаж байсан *Arno Pries & I. B. Hirschfeld* пүүсийн эзэн ноён Прэйс нь БНМАУ-тай худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоох явдлыг дэмжиж сонирхдог,

⁹⁰ Мөн тэнд, 49-р тал.

⁹¹ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6, Монгол-Германы харилцааны данс- 4, хуудасны дугаар -№ 3.

⁹² Номын ууган орд (Дуртгалын эмхтгэл), Улаанбаатар, 1972, 49-50-р тал.

үйлдвэртээ дадлага хийж байсан монгол сурагчидад байнга анхаарал халамж тавьдаг хүн байжээ.

С. М. Вольф ноён Прэйстэй уулзсан тухайгаа дурсан бичихдээ *"...Бид бусад хотуудаас Лайпциг руу илүү олон удаа явдаг байсан учир нь тэнд суралцаж байсан дөрвөн залуу газрын зураг хэвлэж эхлэсэн тул шалгах ажил байсан юм. Нэгэн удаа надад ноён Прэйстэй уулзаж сонирхолтой яриа өрнүүлэх завшаан олдсон билээ. Тэр бол дунд эргэм насны, нилээд хөрөнгө бэлтэй, худалдаа наймаанд дуртай, төрх байдлын хувьд төлөв, тогтуун сайхан хүн байлаа.*

Тэрээр, яагаад Монгол Улсын Засгийн Газар ямар нэг аргаар Герман Улсын Засгийн газрын албан ёсны хүлээн зөвшөөрлийг эрхэмлэн олж авахыг оролдохгүй байгааг ойлгож чадахгүй байгаагаа дурьдаад зарим тохиролцож чадсан зүйлүүдийн дагуу эрт орой хэзээ нэгэн цагт дипломат харилцаа тогтоно гэдэгт итгэдэг гэж ярьсан юм. Энэхүү ярианаас үзэхээр тэрээр Лейпцигт томилогдсон Монгол Улсын төлөөлөгчийг анхнаас л сонирхож байжээ. Түүнтэй уулзаж нилээд удаан ярилцсаныхаа дараа мөн түүний туслахтай уулзаж Монгол Улсын Засгийн газартай холбоотой сайтар бодож боловсруулсан ажлуудынх нь талаар асуусан юм. Энэхүү хэрэг явдал нь зөвхөн түүнтэй холбоотой хэрэггүй нотлогоонууд байгаагүй ба Герман бизнесмен хүний төлөвлөсөн хэт ирээдүйд хэрэгжих боломжтой ухаалаг тооцоо байлаа"⁹³ гэж дүгнэн бичсэн байдаг.

Мөн Берлин хотод байрлаж байсан *"Герман, Франц улс дахь Монгол сурагчидын захиргаа"*-ны дарга Б. Ишдорж дээрээс өгсөн зааврын дагуу Германы Вандерер (Wanderer) үйлдвэрт анхны монгол үсгийн машиныг захиалан хийлгэж Монгол руу 100 ширхэгийг илгээсэн ба өөрөө нэгийг авч үлдээд захиргаанаас оюутнуудтайгаа хамтран эрхэлж гарган байсан *"Сурагчдын монгол сэтгүүл"*-ийн эхийг гэртээ бичиж, хувилах ажлыг гүйцэтгэж байжээ.⁹⁴

Германд суралцаж ирсэн Ц. Баатарсэнгэ, Лувсаннамжил нар нь тухайн үеийн Монголын анхны хэвлэлийн үндэсний мэргэжилтэн болж патин ба монгол үсэг өрөгч нарыг курсээр сургаж 1930 оноос *"Үндэсний эрх"* сонинг латинаар өрөн хэвлэж байв. Мөн *"Герман, Франц улс дахь Монгол сурагчидын захиргаа"*-ны дарга байсан Б. Ишдорж багш 1930

⁹³ S.M.Wolff, Mongolian Educational Venture in Western Europe /1926-1929/, Zentralasiatische Studien 5(1971), 275-р тал.

⁹⁴ Мөн тэнд, 275-р тал.

онд Германаас буцаж ирснийхээ дараа Германд суралцаж байсан шавь С. Наваан-Юндэн, Б. Содном нарын хамт хэвлэлд бэлтгэх материалын хэл найруулагыг засах, монгол хэлнээ орчуулага хийх зэрэг ажлыг анхлан гүйцэтгэж энэ салбарт их зүйл хийжээ.

5. Уул уурхай, ашигт малтмалын салбар

1920-иад оны үеийн Монгол орон дахь уул уурхай, ашигт малтмалын үйл ажиллагаа хэдхэн тооны Орос, Хятадын пүүсүүдээс хэтрэхгүй байсан ба үндэсний хэмжээнд бодлого авч хэрэгжүүлээгүйн улмаас жилд их хэмжээний ашигт малтмалыг үнэгүй шахам алдаж байв. Түүнээс гадна энэ салбарыг хөгжүүлэх үүднээс хөгжингүй орнуудын техник, технологийг авч ашиглах, чадварлаг мэргэжилтэн, боловсон хүчний дэмжлэг авах явдал чухал байжээ. Худалдааны төлөөлөгч Сампилон, Хурлат нар 1925 онд Германд айлчлахдаа энэ тухай албан ёсоор гэрээ байгуулж уул уурхайн техник, тоног төхөөрөмж худалдан авах, Монгол орны ашигт малтмалыг хайн илрүүлэх, түүний зураглалыг зохиох, лабораторийн шинжилгээ хийх ажилд дэмжлэг авах зорилгоор энэ чиглэлд Германы пүүс, фирмүүдийн анхаарлыг хандуулахад анхаарсан байна.

Засгийн газрын 1928 оны VIII сарын 17-ны өдрийн Засгийн газрын хурлын тогтоолд Герман Улсаас урин ирүүлэх уурхайн ахлах мэргэжилтэн Ф. Вейскегийн Монголд хүрэлцэн ирэх тухай өгүүлсэн байдаг.⁹⁵ Вейске нь Монголд ажиллаж байхдаа уул уурхайн хэлтсийн ахлах мэргэжилтэн гэсэн албан тушаалыг эрхэлж байсан ба түүний удирдлаганд нилээд хэдэн герман инженерүүдээс бүрдсэн хайгуулын хэлтэс ажиллаж байсан бололтой. Германы экспедици Монгол оронд хайгуулын шинжилгээний ажил хийх болсноор тодорхой үр дүнд хүрч өнөөгийн Сэлэнгэ аймгийн Зүүн-Хараа орчим алтны уурхай нээн олзворлох ажиллагаа явуулж байсан баримт байдаг.

Гэвч энэ тухай дэлгэрэнгүй баримт ховор байна. Монголд ажиллаж байсан Германы инженер, мэргэжилтнүүд нь манай улсын тухай мэдээллийг Герман Улсад зохих хэмжээгээр хүргэж байсан ба 1928 онд Герман Улсаас БНМАУ-д урилгаар ирж ажилласан уурхайн хэлтсийн ахлах мэргэжилтэн, инженер Ф. Вейске *“Гадаад Монголын эдийн засгийн нөхцлийн тухай”* илтгэл бичиж хэвлүүлсэн нь Герман Улсын ГЯЯ-ны сонирхлыг ихэд татаж, өндөр үнэлэгдэж байсан баримт

⁹⁵ УТА. Фонд № 359, данс-1, хадгаламжийн нэгж-18.

байна⁹⁶. Мен Аж Ахуйн яамны сайд Н. Жадамба 1927 онд М. Амагаевтай ярилцахдаа герман инженер нар улс төрийн бодлогоор хөөцөлддөггүй гээд харин улс төрийн бодлого руу тэмүүлдэг хүн гэвэл ганц инженер Вейске гэж хэлсэн байдаг.⁹⁷

Эндээс үзэхэд инженер Ф. Вейске нь ямар нэг пүүс, фирмийн гэрээгээр биш Монголын талаархи Герман Улсын Засгийн газрын зохистой сонирхлын хүрээнд Монголд ирж ажиллаад, дараа нь энэ тухайгаа ГЯЯ-ндаа тайлан илтгэл бичсэн байж тун болзошгүй бөгөөд цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатай асуудал юм. Уул уурхай, ашигт малтмалын салбарт Герман Улстай албан ёсны гэрээтэй ажиллахаас гадна бас цөөн тооны герман иргэд хувиараа энэ салбарт аж ахуй эрхлэж байв. Аж Ахуйн яам 1927 оны VI сарын 1-нээс эхлэн Герман Улсын иргэн Р. Мюллертэй жил тутам 5000 пүнтээс доошгүй эрдэнийн чулуу олборлуулж, тэн хагасыг нь Р. Мюллерт олгож нөгөө хагасыг нь Аж ахуйн яамнаас татвар болгон хурааж энэхүү хураасан чулууны пүнт бүрийг 2 төгрөгөөр Р. Мюллерт худалдах, хэрэв илүү үнэ хүрвэл Аж Ахуйн яам өөр газар худалдах эрхтэйгээр хоёр жилийн хугацаатай гэрээ байгуулж байжээ.⁹⁸

6. Авто машин, техникийн чиглэлд

Юуны өмнө нэгэн сонирхолтой түүх өгүүлье. Манж Чин Улсын Бадаргуулалт төрийн 32-р он улаагчин хонин жил буюу Европын 1907 онд VIII Богд Жибзундамба Хутагт Герман Улсаас 1 цилиндртэй, дотоод шаталтын хөдөлгүүртэй “Деймлер” хэмээх автомашиныг худалдан авчруулсанаар Монгол дахь анхны автомашин эзэмшигч болсон байна.

Энэ нь Монгол оронд автомашиныг өргөнөөр хэрэглэсэн түүхийн эхлэл болов. БНМАУ-ын авто тээврийн салбар “Монгол тээх нэвтрүүлэх газар” 1925 онд байгуулагдсанаар гал голомтоо бадраасан түүхтэй. “Монгол тээх нэвтрүүлэх газар” анх байгуулагдахдаа Америк, Герман, Франц зэрэг орнуудад үйлдвэрлэсэн 1-1,5 тоннын бага даацын

⁹⁶ Б.Батбаяр, XX зууны Монгол: Нүүдэл суудал, гарз олз, Улаанбаатар, 1996, 356-р тал.

⁹⁷ Коминтерн ба Монгол (Баримтын эмхтгэл), Улаанбаатар, 1996, 159-р тал.

⁹⁸ С.Идшинноров, Хот суурины хувийн хэвшлийн хөгжил, хувьслын асуудалд /1921-1960/, Түүхийн ШУ-ны дэд доктор /Ph.D/-ын зэрэг горилсон бүтээл, Улаанбаатар, 1993, 34-р тал.

40 орчим марк, серийн 120 автомашинтай байв.⁹⁹ “Монгол тээх нэвтрүүлэх газар” байгуулагдсанаар Монгол орны өнцөг булан бүрт иргэдэд ахуйн хэрэгцээтэй бараа, тавар, бусад шаарлагатай үйлчилгээ хурдан шуурхай хүрэлцэн очих болжээ.

“Монгол тээх нэвтрүүлэх газар” байгуулагдахаас өмнө Герман Улсын “Востваг” кампани 1923 оноос Хаалган - Нийслэл Хүрээ хооронд 100 гаруй автомашинаар байнгын ачаа, тээврийн үйл ажиллагаа явуулж чухал үүрэг гүйцэтгэн ажиллаж байжээ.¹⁰⁰ Эндээс үзэхэд “Монгол тээх нэвтрүүлэх газар” байгуулагдан үйл ажиллагаагаа явуулахаас өмнө Герман зэрэг гадаадын пүүс, кампаниуд Монгол дахь авто тээврийг голлон эрхэлж байжээ. Авто тээврийн үндэсний салбар үүсэн хөгжсөн үеэс эхлэн бензин, шатахууны хангамжийн асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй болсон байна. Энэ үүднээс 1924-1926 онд шатахуун хадгалах зориулалттай 14-15 тоннын багтаамж бүхий 230 ширхэг савыг Герман Улсаас худалдан авчирч тавьсан баримт байна.¹⁰¹ Энэ үндсэн дээр Улаанбаатар хотод анхны шатахуун түгээгүүрийн станцыг барьжээ. Герман Улсын “Востваг” кампани нь манай улсын шатахууны тодорхой хувийг ханган нийлүүлэх үүрэг хүлээн ажиллаж байсан ба мөн автомашин, түүний сэлбэг хэрэгслийг ч импортлож байсан юм. Үүний зэрэгцээ Герман Улсын иргэн Вильгельм Дорн “Монгол тээх нэвтрүүлэх газар”-т автомашины сэлбэг хэрэгсэл гэрээгээр нийлүүлж байлаа. Энэ тухайд холбогдох албан бланк, хуудасууд Үндэсний Түүхийн Архивийн Фонд № 359-д нилээд хадгалагдаж байна.

⁹⁹ Т.Намжим, Монголын аж ахуй, эдийн засаг (Түүхэн гурван үед), 2-р боть, Улаанбаатар, 2000, 517-р тал.

¹⁰⁰ Д.Уламбаяр, Монгол-Германы түрүү үеийн харилцаа, Олон улс судлал сэтгүүл, Улаанбаатар, 1 (2001), 88-р тал.

¹⁰¹ Т.Намжим, Монголын аж ахуй, эдийн засаг (Түүхэн гурван үед), 2-р боть, Улаанбаатар, 2000.

* Вилгельм Дорн нь “Монгол тээх нэвтрүүлэх газар”-т автомашины сэлбэг хэрэгсэл гэрээгээр нийлүүлэхээс гадна Төмрийн завод, Улсын аптег, Мал эмнэлэгийн ерөнхий хороо зэрэг газруудад чухал шаардлагатай байсан тоног төхөөрөмж, материалыг Хятадаас авчиран нийлүүлдэг байжээ. Улаанбаатар хотын 3-р хорооны 462-р хашаанд амьдарч байв. 1929 оны V сарын дундуур В.Дорныг эрхлэн буй ажлаа 14 хоногын дотор хаахыг Засгийн газраас шаардсан байна. Энэ шийдвэр нь В.Дорнд их алдагдал хохирол учруулах байсан тул тэрээр Засгийн газарт энэ асуудлаар V сарын 21, VI сарын 6 нд гэх мэтээр удаа дараа гомдол гарган өргөдөл бичиж байжээ. В.Дорн найрамдалт харилцаатай хоёр улсын (Монгол-Герман) холбоог бэхжүүлэх үүднээс Засгийн газрыг шийдвэрээ цуцлаж өгөхийг хүссэн утгатай өргөдөл бичиж байв. Гэвч ямар үндэслэлээр В.Дорны эрхлэж байсан бизнесийг зогсоосон нь тодорхойгүй ба асуудал хэрхэн шийдэгдсэн нь ч мэдэгдэхгүй байна. Бодвол зүүнтнүүдэн уршигт хийрхэлтэй холбоотой болов уу?

Пильгельм Дорн нэгэн өргөдөлдөө бичихдээ "... Өчүүхэн хүн миний бие БНМАУ-ын газар суухуй дор тус газар манай Герман Улсын пүүсийг байх үгүйг мэдэх ба бас Германаас урьд ирсэн боловсронгуй сурагч нар Монгол газар сууж албан хааж бүхүй ба мөн Монгол улсын олон харьяат нар манай Герман Улс дор одож эрдэм боловсрол дор суралцаж байсан зэрэг найрамдлын байдал төлөвийг тус тус баримтлан"¹⁰² гэх зэргээр өөрийн хүсэлтээ нааштайгаар шийдүүлэхийг хүсэж байжээ. Энэ асуудал яван явсаар хоёр улсын эрх бүхий хүмүүсийн сонорт хүрсэн ба Тяньжин хот дахь Герман Улсын бүрэн эрх барих элчин сайдаас В. Дорны асуудлаар албан бичиг хүртэл ирсэн байх юм.

1929 оны XI сард "Монгол тээх нэвтрүүлэх газар"-ыг "Монгол Транс" болгон өөрчлөн зохион байгуулсан байна. Ингээд "Монгол тээх нэвтрүүлэх газар"-т хуучин ашиглагдаж байсан автомашинуудаас 80 гаруйг нь ашиглалтаас хасаж актласны дараа тус байгууллагт Монгол орны цаг уур, замын нөхцөл, ачаа тээврийн онцлогт тохирсон автомашинаар парк шинэчлэл хийх шаардлага гарсан юм. 1930 онд Засгийн газрын тогтоолд "Монгол Улсын хязгаар дотор уурын тэргэд ба мотоциклуудыг оруулж ирэх явдлыг журамтай болгох тухай" дүрмийг баталж, "Монгол транс"-ын хяналтын дор албан газар, хувь хүмүүс, гадаад орнуудаас автомашин, мотоцикл хил нэвтрүүлэн оруулж байхаар нийтэд журамлан тогтоожээ.¹⁰³

Мөн гадаад орнуудаас Форд, Дож, Грахам, Мерседес-Бенз, Автокар, Бьюк, Шевроле маркын автомашиныг түлхүү оруулж ирэх тухай Засгийн газрын тогтоол ч гарч байжээ.¹⁰⁴ Эндээс үзэхэд Герман Улсад үйлдвэрлэсэн автомашинууд Засгийн газраас тогтоосон дээрхи шаардлагуудыг сайн хангаж байсан тул манай тал Германы автомашинуудаар авто тээврийн парк шинэчлэл хийх сонирхол их байсан нь харагддаг.

1930 оноос "Монгол Улсын Хувь Нийлүүлсэн Зам Тээврийн Ерөнхий Хороо Монгол транс"-аас Герман Улсын автомашин үйлдвэрлэлийн "Мерседес-Бенз"(Mercedes-Benz) компанитай хэлэлцэн тохиролцож,

¹⁰² МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6, Монгол-Германы харилцааны данс-2, хуудасны дугаар № 7.

¹⁰³ БНМАУ-ын тээвэр 1925-1975 онд (Статистикийн эмхэтгэл), Улаанбаатар, 1979, 7 83-р тал.

¹⁰⁴ Т.Намжим. БНМАУ-ын тээврийн системийн хөгжлийн асуудал, Улаанбаатар, ШУАХ, 1977, 234 хуудас.

тус үйлдвэрийн автомашин Монгол орны нөхцөлд нийцэх эсэхийг шалган үзэж судлах комисс байгуулан ажиллахаар тогтсон байна.

Энэ хүрээнд авто инженер Карл Швагерыг Монголд урин ирүүлж ажиллуулахаар тохиролцжээ. Дотоодыг Хамгаалах газраас 1930 оны Х сарын 20 ны өдөр № 511 тоотор “Монгол Улсын Хувь Нийлүүлсэн Зам Тээврийн Ерөнхий Хороо Монгол Транс”-ын удирдлагад “Магадыг хянаж түүгээр гүйцэтгүүлмүй” хэмээн илгээсэн албан бичигт “Эдүгээ хувь нийлүүлсэн Монгол-Трансын Ерөнхий Хорооноос тус улсад ирэх Мерседес-Бенз хэмээх машин тэргийг харъяат улсын орон нутгийн байдалд нийцэлдэх эсэхийг шинжлэн үзэх комисс байгуулахаар Алтанбулаг хотоор хязгаар нэвтрэн ирэх Герман Улсын Мерседес-Бенз хэмээх машин тэрэг үйлдэх пүүсийн төлөөлөгч, мөн улсын харъяат Карл Швагерийн биед түр хугацааны үнэмлэх бичиг олгом уу хэмээн 3648/3702 тоотуудаар удаа дараагаар шаардан ирүүлсэн үүнд байцааваас тэрхүү Карл Швагерийн биеийг тийнхүү дурьдсан ажлыг гүйцэтгэх түр хугацааны үнэмлэх олгож ирүүлэхэд манай яамнаас онц татгалзахгүй бөгөөд түүгээр магадыг хянаж гүйцэтгэх ажаамуй.

Үүнийг Монгол-Трансын Ерөнхий Хорооноо мэдэгдсүгэй.

Сайд Чойбалсан.^{105*}

гэсэн албан бичиг илгээн үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж байжээ.

“Монгол Улсын Хувь Нийлүүлсэн Зам Тээврийн Ерөнхий Хороо Монгол Транс”-ын дарга О. С. Абалов, бичиг хэргийн эрхлэгч С. А. Кузнецов нараас ГЯЯ-нд 1930 оны Х сарын 16-ны өдөр илгээсэн бичигт дурьдсанаар үзвэл инженер К. Швагер нь 1930 оны Х сарын 17-нд Монголд ирэх төлөвлөгөөтэй байсан ч виз олгохгүй удааширч байсны улмаас мөн сарын сүүлээр хүрэлцэн ирсэн бололтой.¹⁰⁶

Мөн К. Швагераас гадна Кречман, фон Дегион Монтеток зэрэг авто инженерүүд Монголд албан ёсоор уригдан ажиллаж байжээ.¹⁰⁷ Герман Улсын “Мерседес-Бенз”(Mercedes-Benz) компаниас гадна *Юнкерс & Моторенбау*(Junkers Motorenbau) пүүстэй энэ салбарт мөн өргөн харилцаатай байсан мэдээ баримт бий. Автомашин, механикийн

¹⁰⁵ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6, хадгаламжийн нэгж 6, хуудасны дугаар - 7.

¹⁰⁶ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6, хадгаламжийн нэгж 6, хуудасны дугаар - 13.

¹⁰⁷ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6, хадгаламжийн нэгж 6, хуудасны дугаар - 8.

чиглэлээр Герман Улсын Эйзнах /Eisenach/ хотын Dixi автомашины үйлдвэрт Базарням, Лувсан нарын хоёр сурагчийг бэлтгэн сургаж байв.

Юутай ч авто тээврийн салбарыг хөгжүүлэхэд Герман тэргүүтэй хөгжингүй орнуудын туслалцаа, дэмжлэгийг авсны үр дүнд 1931 он гэхэд “Монгол Улсын Хувь Нийлүүлсэн Зам Тээврийн Ерөнхий Хороо Монгол Транс” нь 12 маркийн 121 ачааны машинтай байсан бол 1936 оны эхээр яаз, бенз, амо зэрэг 3-4 маркийн 322 ачааны машин, 14 автобустай болж өргөжин хөгжсөн байна.¹⁰⁸

Эдгээрээс гадна 1926 оноос Герман Улстай Иргэний нисэхийн асуудлаар харилцаатай байв. Дурьдан буй үед Герман Улс нь Алс Дорнодод руу чиглэсэн дипломат бодлогоо дахин сэргээхийг оролдож байсан тул тус Улсын Нисэхийн Ерөнхий хорооноос янз бүрийн чиглэлээр туршилт хийсний нэг нь *Берлин-Москва-Улаанбаатар-Бээжин* хүртэлх иргэний нисэхийн агаарын зам байсан юм.

Улмаар Герман Улсын “Люфтанза” (Lufthansa) хэмээх нисэхийн хорооноос инженер нисгэгч Ервин Шульц, Габриел Надеждин нар ГИМАУ-д 1926 оны VII сарын эхээр хүрэлцэн ирсэн бололтой. ГЯЯ-ны 1926 оны VII сарын 1-ны албан бичигт “...Одоо нисгэгч, инженер Ервин Шульц, Габриел Надеждин нарын дурьдсан хэрэг нь энэ нэгэн үдэл ёсоор болж хоёр улсын найрамдал, холбоо байгуулах хэргийн үүсэл болохын зохих тул мөнхүү нисэх онгоцыг ирсэн тухай дор тусламж үзүүлэх, цахилгаан мэдээг шууд нэвтрүүлэх, сүйтгэлийг хөнгөтгөх зэргээр харъяат газруудад үүрэг болгож 2 сарын хугацаатай нэвтрэх бичиг олгох”¹⁰⁹ тухай зааж холбогдох газруудад

¹⁰⁸ Т.Намжим, Монголын аж ахуй, эдийн засаг (Түүхэн гурван үед), 2-р боть, Улаанбаатар, 2000, 518-р тал.

¹⁰⁹ Дэлхийн I дайны дараагаар Герман улсаас Антантын өмнө хүлээсэн нэг үүрэг бол цэргийн нисэх хүчин байгуулахгүй байх явдал байсан юм. Иймээс энэхүү агаарын зам шинжлэн судлах ажиллагаанд ямар нэгэн улс төрийн агуулагатай зүйл байгаагүй юм. Харин манай тал энэ асуудлаар хэт үзэл сурталжсанаар 1931 онд Германы хоёр нисэгчийг баривчлан хорьсон тал бий. Манай талаас уг асуудлыг улс төржүүлж байсан боловч үнэндээ 1935 оны III сарын 13 нд Рейхсканцлер А. Гитлерийн санаачлагаар Герман Улс өөрийн цэргийн нисэх хүчингүй байх үүрэгээсээ татгалзах хүртэлх агаарын зам шинжлэн судлах ажиллагаа нь иргэний нисэхийн шинж чанартай байсан болов уу?

¹¹⁰ Герман Улсын “Люфтанза” (Lufthansa) хэмээх нисэхийн хороо нь Хятадтай байгуулсан гэрээ ёсоор Манжуур-Шанхайгийн чиглэлээр нислэг үйлдэж байсан ажээ.

¹⁰⁹ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6, Монгол-Германы харилцааны данс-1, хуудасны дугаар 7.

энэ талаар үүрэг, чиглэл өгсөн байна. Манай улсын зүгээс Герман Улсын агаарын зам нээх ажилд зохих дэмжлэг үзүүлэхийг анхнаасаа хичээж байсан ба найрамдалт хоёр улсын ёсоор харилцахыг эрмэлзэж байв.

Энэхүү хоёр нисгэгчийн хамтаар нэгэн эрдэмтэн ирж Ардыг Гэгээрүүлэх яам, Судар Бичгийн хүрээлэнгийн удирдлагуудтай эрдэм, соёлын талаар яриа хэлэлцээ өрнүүлж байсан баримт байна.¹¹⁰ Иймээс 1926 онд Герман Улсаас агаарын зам шинжлэн үзэхээр ирсэн баг манай талын дэмжлэгтэйгээр үүргээ саадгүй биелүүлсэн байна. Мөн 1927 оны IX сарын 28-нд “Востваг”-ын тэргүүлэгч Иосиф Голденберг Монголд хүрэлцэн ирж БНМАУ-ын ДХГ-т бичиг илгээн эхнэрийн хамт, Шимон, жолооч нарын дөрвөн хүн Улаанбаатар хотын эргэн тойронд дойч хэмээх 929-858 дугаартай нисэх онгоцоор зугаалах зөвшөөрөл авч байсан сонирхолтой баримт байна.¹¹¹

Герман Улсын Нисэхийн Ерөнхий хорооноос олон чиглэлээр зам нээхийг оролдож байсан ба нэг хувилбар нь *Шанхай-Нанжин-Тэньжин-Бээжин-Күлүн-Сибирь* гэсэн маршрут байжээ. Энэ чиглэлээр нисэхэд БНМАУ-ын Буйр нуурын орчмоор дайран гарч байснаас 1931 оны VII сард зөвшөөрөлгүй туршин нисэлт хийж байсан Герман Улсын “*Европа Ази*” пүүсийн хоёр онгоцыг буудан унагаж нисгэгч Фридрих Кольбер, Иохан Ратье нарыг баривчлан хорьжээ. Германы хоёр нисгэгчийг 1931 оны VIII сарын 6-ны өдрийн Дээд шүүхийн таслах Цэргийн коллегийн тогтоолоор 5 жилийн хугацаагаар хорих ял шийтгэсэн байна.

Гэсэн хэдий ч Герман Улсын Засгийн газраас иргэдээ суллуулах талаар дипломатын шугамаар ЗХУ дахь БНМАУ-ын элчин сайдын яам ба БНМАУ дахь ЗХУ-ын элчин сайд А. Я. Охтинд удаа дараа бичиг илгээн хоёр нисгэгчийг суллаж онгоцны хамт буцаан эх оронд нь явуулахыг албан ёсоор хүсч байжээ.¹¹² Энэ бүх дипломат арга хэмжээний үр дүнд Засгийн газар шийдвэрээ эргэн харж 1931 оны IX сарын 4-ны өдөр хуралдсан XVI хурлын тогтоолын I зүйлд герман нисэгчдийн хэргийг хэрэгсэхгүй болгон суллах шийдвэр гаргасан байна.¹¹³

¹¹⁰ УТА. Фонд № 23, Судар Бичгийн хүрээлэнгийн данс (1921-1930), хадгаламжийн нэгж-116, нугалбар 22.

¹¹¹ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6, Монгол-Германы харилцааны данс-1, нугалбар 6.

¹¹² МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6, хадгаламжийн нэгж 6, хуудасны дугаар-24.

¹¹³ Мөн тэнд.

ЗХУ дахь БНМАУ-ын элчин сайдын яамнаас 1931 оны XI сарын 28-ны өдөр № 434 тоотоор ГЯЯ-нд ирүүлсэн албан бичигт дурьдсанаар Герман Улсын “Люфтганза” (Lufthansa)-аас Вольтер гэдэг хүн тус наманд ирж хүсэлт тавьсан тухай өгүүлжээ.

Түүний тавьсан хүсэлтийг дор сийрүүлбээс:

“... манай Герман ба Хятад хоёр улсын хооронд байгуулсан агаарын онгоцны хоршоо эдүгээ Манжуур ба Шанхай хот хоёрын дунд ажиллаж буй бөгөөд “Люфтганза”-ийн Ерөнхий Хорооноос туйлын гуйж хүсэх нь манай агаарыг онгоцнуудыг Манжуур хотоос Шанхай хот хүртэл үргэлж явахад танай улсын зүүн урьд хязгаарын дэвсгэр дээгүүр дайран гарч байх зөвшөөрлийг эрхэм Монгол Улсын Ардын Засгийн Газраас олгохыг гуйсугай. Хэрэв зөвшөөрлийг олох ахул тэрхүү агаарын тэргүүдэд бүхий л албан хаах этгээдүүд нарыг цөмөөр Герман Улсын харъяат нараар гүйцэтгүүлмөй хэмээхээс гадна Монгол Улсын нутгийн дэвсгэр дээгүүр нисэх бүхий л цаг үест цөм ямар ямар газраар нисэх ба түр буух зогсох өртөө буудал зэргийн зүйлүүдийг уг тогтоосон тушаал зааврын ёсоор нэг ч зөрчихгүйгээр эгнэгт гүйцэтгэж байх”¹¹⁴ гэх зэргээр зөвшөөрөлгүй нисэж байж баригдсан хоёр нисгэгч лугаа адил хүнд байдалд орохгүй байх үүднээс албан ёсоор зөвшөөрөл авахыг хүсэж байгаагаа мэдэгдсэн байна. Энэ асуудлаар Москва дахь БНМАУ-ын элчин сайдаас ГЯЯ-нд хандаж хэрхэх талаар хариу ирүүлэхийг хүссэн байна.

Элчин сайд албан бичигтээ өгүүлэхдээ *“... Үүнд хянаваас туйлын чухал бөгөөд ноцтой сонирхолтой асуудал лав мөн болох тул, үүгээр холбогдох улсын Гадаад Явдлын яамны нөхөд лүгээ нөхрийн хувиар харилцан ярилцсан бөгөөд зүй нь уул гуйсны ёсоор болгоход ихээхэн бэрхшээлтэй ба эцэст тун аюултай зүйл гарахуйяа болзошгүй ба нөгөөтэйгүүр манай улсаас хэрхэвч үүнийг зөвшөөрөхгүй баймөй хэмээн шууд харилцах хэмээвээс дэлхий дахины олон улсуудын хоорондын агаарын тэрэгний харилцаа байгуулах явдалд хараахан даруй нийлэмжтэй болсон хэмээхэд бас бэрхтэй тул арга буюу энэ асуудлыг хоёр улсын дунд урьдаар сайтар нарийн хянан хэлэлцэж тогтсоны дараагаар нарийн бодлоготой хариу ирүүлбээс болох болов уу хэмээн хэлэлцээд үүнийг тун яаравчлан эрхэм Гадаад Явдлын яамнаа бүрэн хүндэтгэн явуулаад түүгээр нягтлан хэлэлцэж зохих хариу зааврыг нэн даруйхан ирүүлэх ажаамуй хэмээн үүний тул явуулав.*

Элчин сайд”¹¹⁵

¹¹⁴ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6, хадгаламжийн нэгж 6, хуудасны дугаар - 32.

¹¹⁵ Мөн тэнд

гэснээс үзэхэд энэ асуудалд манай тал ихээхэн болгоомжилсон байр сууринаас хандаж байсныг харуулж байна. Гэвч байдал тийм ч ноцтой байсангүй. Монголын талын энэхүү байр сууринаас шалтгаалан Герман Улсын Алс Дорно зүгт агаарын зам нээх үйл ажиллагаа 1935 он хүртэл саатсан байна.

Монгол-Германы харилцааны түүхийг судалж байх явцад манай хоёр улсын харилцаанд ололт дэвшлүүдээс гадна үл ойлголцол, алдаа гажуудал ч байсныг тэмдэглэх нь зүйтэй болов уу?

Иймээс энэхүү түүхэн үйл явдлыг орхигдуулалгүйгээр зайлшгүй авч үзэх хэрэгтэй гэж үзсэн тул цухас дурьдсан болно.

7. Худалдаа ба ахуйн хэрэглээ, үйлчилгээний салбарт

Герман Улстай өргөн харилцаатай байсан салбар бол ахуйн хэрэглээний худалдаа, үйлчилгээ байжээ. Дурьдан буй үед иргэдийг өдөр тутмын хэрэгцээтэй бараа бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангах явдал туйлаас чухал зорилт байв. Энэ чиглэлд Герман Улстай харилцах талаар 1925 онд худалдааны төлөөлөгч нар шамдан ажилласан юм. Монголд бараа бүтээгдэхүүн, импортлогч Германы том кампани бол “Востваг” (*Wostwag*) байсан юм. Гэвч “Востваг” (*Wostwag*) -ын тухай хойно дэлгэрэнгүй өгүүлэх тул энд эс өгүүлэв. 1926 онд Герман Улсын шууд туслалцаатайгаар цэмбэний заводыг байгуулсан ба сургагч мэргэжилтнээр инженер Берхер ажиллаж байв. Инженер Берхер гэр бүлийн хамт Монголд ирж ажиллан тус заводын үйлдвэрлэлийг сайжруулах талаар их зүйл хийж байжээ. Аж ахуйн явдлын яамнаас ЗХУ-ын Элчин сайдын консулын хэлтэст № 16 тоот албан бичигт өгүүлснээр 1927 оны I сард цэмбэний заводын дутагдалтай байгаа тоног төхөөрөмжийг авчиргах зорилгоор инженер сургагч Бехер ЗХУ-д хоёр сарын хугацаатай явж ажиллаж байсан баримт байна.¹¹⁶

1928 оны VIII сард Засгийн газар Герман Улсаас цэмбэний болон бусад үйлдвэрт зориулагдах нэхмэлийн төрөл бүрийн машин, багаж, челонок, уурын зуухны тоноглол зэрэг техник төхөөрөмжүүдийг 96896 марктай тэнцэхүйц төгрөгийг зарцуулан худалдан авсан байна.¹¹⁷

¹¹⁶ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6, Монгол-Германы харилцааны данс-4, нугалбар 7.

¹¹⁷ УТА. Фонд № 359, данс-1, хадгаламжийн нэгж - 32.

ГЯЯ-ны № 939 тоотор СССР улсад суугаа БНМАУ-ын Бүрэн эрх барих элчин сайд Буянчуулганд илгээсэн албан бичигт “...Герман Улсын харъяат цэмбэний үйлдвэрийн сургагч Берхерийг эхнэрийн хамт нутаг буцахад нь хил хязгаарыг саадгүй өнгөрүүлэх виз олгохыг хүссэн”¹¹⁷ зэргээс үзэхүл Бехер нь 1929 оны IX сар хүртэл БНМАУ-д урилгаар ирж үр бүтээлтэй ажиллаж байсан байна. Герман Улсад ч сүлжмэл, нэхмэл эдлэлийн технологиор нилээд оюутан суралцаж байсан юм. Үүнээс гадна Алтанбулаг хотын архины заводод Кериг гэдэг герман хүн 1930 оны X сараас 1933 оны V сар хүртэлх хугацаанд техник ангийн эрхлэгчийн албан тушаалыг хашиж байжээ¹¹⁸.

Мөн Герман Улстай энэ үед анагаах ухааны чиглэлээр хамтран ажиллахаар шийдвэрлэж эмнэлэгийн мэргэжилтэн урин ирүүлэх ба хэрэгцээт эмийг худалдан авчируулахаар тогтоож байжээ. 1926 оны XII сарын 23-нд БНМАУ-ын ДЯЯ-ны сайд А. Амараас ГЯЯ-нд № 1469 тоотор илгээсэн бичигт энэ тухай өгүүлсэн байдаг. Бичигт өгүүлэхдээ “... Дотоод яамны харъяат Ардыг эрүүлийг хамгаалах ба Аптекийн зэрэг хоёр газар дор хүний эмнэлэгийн хувиар Зөвлөлийн Засагт Холбоот Орос улсаас эмч нар урин ирүүлж хэрэглэж буй бөгөөд дараа мөнхүү Холбоот Улс ба Герман улсаас чадвартай эмч нарыг урин ирүүлэх ба эмнэлэгийн явдал эрдэм боловсролын тухай харилцаж, мэдэв эм, бодис зүйлийг нааш цааш авч өгүүлэх зэргээр харилцахыг бодолхийлэн буй тул үүнийг, Монгол Ард Улсын Гадаад Хэргийн намнаа явуулаад байцаан үзүүлнэ хэмээмэй хэмээн эржүхүй.

Үүний тул илгээв.

Монгол Улсын арван зургадугаар он, XII сарын 23.

Дугаар № 1469.

Сайд Амар. Эрхэлсэн түшмэл Цэенпил.”¹²⁰

гэсэн байдаг.

Ер нь анагаах ухааны салбарт техник, тоног төхөөрөмжүүдийг Германаас гэрээгээр худалдан авч байх болон түүнийг чадварлаг эзэмшин ажиллуулах мэргэжилтэн бэлтгэх чиглэлд ч хамтран ажиллах төлөвлөгөөтэй байсан юм. Энэ үед Герман Улсаас манайд

¹¹⁸ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6, Монгол-Германы харилцааны данс-4, нугалбар 11.

¹¹⁹ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6, хадгаламжийн нэгж 6, хуудасны дугаар – 39-40.

¹²⁰ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6, Монгол-Германы харилцааны данс-3 II, нугалбар 6.

Хятадаар дамжуулан бараа, бүтээгдэхүүн импортлох явдал их байсан нь 1) БНМАУ-ын асуудлаархи ЗХУ дахь хандлага, 2) ЗХУ-ын нутгаар дамжуулахад тээвэрлэлтийн зардал нь хэд хэдэн өндөр гардаг байсантай холбоотой болов уу?

1922 оны XI сарын 3-нд Харилцан Туслалцах Хоршооны дарга Дашдэндэвээс Засгийн газарт явуулсан товч мэдэгдэх хуудаст бичсэнээр *“Тяньжин дэхь Германы пүүсээс бараагаа авч хоршооны дэлгүүрийг нээхээр завдан буй”*¹²¹ гэж өгүүлснээс үзвэл хувьсгалын эхний жилүүдээс эхлэн худалдааны харилцаатай байжээ. Герман Улсаас манай улсад нийлүүлж байсан бараа, бүтээгдэхүүнүүдийг гол төлөв автомашин, түүний сэлбэг хэрэгсэл, үйлдвэрийн зориулалттай төрөл бүрийн техник, тоног төхөөрөмжүүд, унадаг дугуй, бичгийн машин, цахилгаан хэрэгсэл, химийн бараа, бензин шатахуун, гутал, хувцас, малгай, бугуйн цаг, зургийн аппарат, костюм, үзэг, даавуу, хөнжил гэх мэт иргэдийн бүхий л хэрэгцээт барааг Герман улсаас шууд нийлүүлж байснаас гадна Германы зарим томоохон кампаниуд (*жишээ нь “Востваг”*) Хятадаас торгон, нэхмэл эдлэл, үхрийн булигаар, илэг, сарьс, гөлөм, ташуур, цай, тамхи, аяга шаазан, хөөрөг зэрэг олон барааг аваачин монгол иргэдийн хэрэгцээг хангадаг байжээ.

Германаас авчирсан бараа эдэлгээ сайн, бөх бат, өнгө үзэмж сайтай тул Монголчуудын таашаалд бүрнээ нийцэж байв. Жишээлбэл 1930 оны VIII сард ЗХУ-аас Улаанбаатар хотод оруулж ирсэн 1500 ширхэг унадаг дугуйг худалдан борлуулах ажил 1931 оны III сар хүртэл саатаж, хэдхэн ширхэг борлосон бол энэ хугацаанд Герман Улсаас оруулж ирсэн унадаг дугуй нэг сарын дотор бүрэн зарагдаж дууссан тухай БНМАУ-ын Төвийн Хяналтын болон МАХН-ын Төв Хянан Шалгах комиссын ерөнхий сургагч П. И. Гапееваас *“Монголын бараа таваарын хангамжийн байдал, Монголын Төв Хоршооны санхүүгийн байдал болон Зөвлөлтийн сургагч, мэргэжилтэн нарын ажлын дутагдлын тухай”* БХК(б)Н-ын Хянан Шалгах Төв Комисст бичсэн илтгэх хуудаст дурьдсан байна.¹²²

¹²¹ БНМАУ-ын социалист худалдааны түүхэнд холбогдох баримт бичиг, Улаанбаатар, 1974, 55-р тал.

¹²² Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичиг (1921-1932), Баримтын эмхэтгэл, боть I, Улаанбаатар, 2002, 328-р тал.

Харин манай улсаас ангийн үс, ноос, ноолуур, байгалын түүхий эдийг худалдан авч хилийн чанадаад экспортлодог байжээ. Энэ тухай сүүлд дэлгэрэнгүй өгүүлэх болно. Мөн 1926 оноос хоршооны харъяанд фото ба гар зургийн тасаг байгуулагдан Германы мэргэжилтэн зураач Л. Синуэр сурталчилгааны асуудал хариуцан ажиллаж байсан ажээ.

Эцэст нь нэгэн чухал зүйлийг тэмдэглэхэд Тэньжин-Хаалган-Өргөө¹²³-д төвлөрсөн албан конторууд бүхий Герман-Монголын худалдааны нийгэмлэг (*Deutsch-Mongolische Handelsgesellschaft*) Улаанбаатар хотноо ажиллаж байв. Тус нийгэмлэгийн даргаар Руд, нягтлан бодогчоор Е. А. Давидсон зэрэг хүмүүс ажиллаж байсны зэрэгцээ ноён Рудаас ДХГ-т 1929 оны VIII сарын 14-нд бичиг илгээн харилцаж байжээ.¹²³

Монгол дахь Герман Улсын зарим пүүс, кампаниудын үйл ажиллагаа

Хувьсгалын эхний жилүүдээс л Монгол-Германы хооронд улсын болон хувийн чанартай олон пүүс, кампаниуд үйл ажиллагаагаа идэвхжүүлэн ажиллаж байв. 1922 онд Монгол оронд худалдаа хийж байсан Англи, Америкийн пүүс 5, Герман Улсын пүүс байгаагүй бол 1923 онд Англи, Америк, Германы пүүс 26, 1924 онд 62 болж өргөжсөөр байжээ.¹²⁴ 1924 оны Анхдугаар Үндсэн хуулинд “Улсын аж ахуй ба эдийн засгийн бодлогыг чухал болгон тус улсаас эрхлэн удирдах ба басхүү гадаадтай харилцах худалдааг улсын онц эрх болгон авах явдлыг зүй зохисыг үзэж гүйцэтгэвэл зохино”¹²⁵ гэж заасан явдал нь худалдаа, эдийн засгийн салбар дахь нарийн төвөгтэй олон асуудлыг улсаас нэгтгэн шийдвэрлэх түүхэн нөхцлийг батлагаажуулсан хэрэг байв.

Өмнөх бүлэгт өгүүлсэнчлэн дурьдан буй энэ үед монголчуудад “*ашигтай бол хэнтэй ч худалдаа хийхэд бэлэн*” гэсэн уриалга бүхий нийгмийн байгуулал, үзэл суртлын ялгарлаас ангид эдийн засгийн

* Нийслэлээ өмнө нь Өргөө хот гэж нэрлэдэг байв.. Манай улсын нийслэл түүхийнхээ туршид олон удаа нэрээ сольсоор байжээ.

¹²³ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6, Монгол-Германы харилцааны данс-4, нугалбар 6.

¹²⁴ Н.Дангаасүрэн, БНМАУ-ын капиталист бус хөгжил ба хөдөө дэхь нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, Улаанбаатар, 1971, 32-р тал.

¹²⁵ БНМАУ-ын социалист худалдааны түүхэнд холбогдох баримт бичиг (1920-1940), Улаанбаатар, 1974, 97-р тал.

олон түшигт харилцааг өрнүүлэх туйлын эрмэлзлэлтэй байжээ. Германд худалдааны төлөөлөгчдийг одуулснаар хоёр улсын худалдаа, эдийн засгийн харилцаа албан ёсны шинж төрхөө олсон юм. Энэ үед хоёр улсын хэлэлцээрийн үр дүнд үйл ажиллагаагаа явуулж байсан томоохон пүүс, кампаниудаас гадна Германы жирийн худалдаачин иргэд ч Монголд цөөнгүй байжээ. Жишээ нь Герман Улсын худалдааны фирмийн ажлаар Латви Улсын иргэн Гарри Мэрс 1920 оны V сарын 17-нд Үдээр Улаанбаатар хотноо ирж байсан мэдээ байна.¹²⁶

Мөн Цэцэрлэг Мандалын аймгийн Заяын Бааюу хэмээх газар худалдаа хийж байсан Германы Симсани пүүсийн худалдаачин Александрт Цэцэрлэг Мандалын аймгийн төлөх өрийн тухай тус аймгийн яамнаас ГЯЯ-нд 1924 оны XII сарын 27-ны өдөр бичиг өргөсөн тухай мэдээ бий.¹²⁷ Мөн 1929-1930 онд Герман Улсын харъяат Берм Голст гэдэг худалдаачин хувиараа Монголд ирж адуу худалдан авч байв.¹²⁸ Иймээс Герман худалдаачид нь Нийслэл Хүрээнээс гадна хөдөө орон нутагт худалдаа, арилжаа хийх явдал их байснаар үл барам худалдаа нь тийм ч бага хэмжээтэй байсангүй бололтой. Энэ тухай доктор Армис Өргөө хотоос бичсэн захидалдаа *"... Монголын нийгмийн бүх давхрааны нэгэн нийтлэг нэгэн шинж бол Германтай найртай төдийгүй манай улсад элэгсэг дотно хандаж байгаа явдал юм. Бас иймэрхүү байдалтай хүлээн авч уулзах байх гэж горьдсон гадаадын зарим худалдаачид өөрийгөө герман хүн хэмээн танилцуулсан тохиолдол ч бий"* гэж бичжээ.

1920-иад оны эхэн үеийн Германы пүүс, кампаниуд Монголоос адуу худалдан авч урагш Шанхай руу аваачин цааш Европод гаргах явдал түгээмэл байжээ. Энэ чиглэлээр ажиллаж байсан *"Юэн фунг Трединг лүүс & Ко"* нь манай улстай 1922-1925 онд худалдааны харилцаатай байсан Монгол дахь Герман Улсын анхны томоохон пүүс байв.

Герман Улсын *"Юэн фунг Трединг & Ко"* хэмээх пүүсийн удирдлага Монгол газраас морь хиу худалдан авч тус улс дор (Германд) нэвтрүүлэн явуулбаас танай Засгийн газраас татгалзах эсэхийг хариу ирүүлмэй хэмээн 1922 оны IV сарын 19-ний өдөр № 236 тоотоор бичиг

¹²⁶ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6, Монгол-Германы харилцааны данс-4, нугалбар 1.

¹²⁷ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6, Монгол-Германы харилцааны данс-1, хуудасны дугаар 2-6.

¹²⁸ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6, хадгаламжийн нэгж 6, хуудасны дугаар- 35-37.

ингээж байсан байна. Энэ бичигт "...Германы Консулын Яамнаас манай пүүсэн дор найрамдлыг илэрхийлэн Монгол Улс лугаа харилцан худалдаа нэвтрүүлсүгэй хэмээн тушаасныг дагаж Нийслэл Хүрээний газар манай пүүсээс салбар хороо байгуулж худалдаалж буй, уг нутгаас манай консулын яаман дор уналга морь дутагдан гаднаас худалдан авах болсны дээр Монгол газраас морь хуу худалдан авах манай улс дор нэвтрүүлэн явуулах дор танай засгийн газраас татгалзах эсэх явдлыг хариу мэдэгдэх ажаамуу"¹²⁹ гэсэн байдаг.

Нугалбар № 4-т өгүүлснээс үзвэл "Юэн фунг Трединг & Ко" пүүс нь манай улсаас өөрийн оронд усан замаар агт морьд гаргадаг байсан бөгөөд Герман Улсын Засгийн газартай холбоотой ажилладаг, Монгол Улс дахь Герман улсын эрх ашгийг төлөөлөгч томоохон пүүс байсан бололтой. 1923 оны V сарын 6-ны өдрийн № 536 тоот бичгээр Шанхайд үрэлдуулах морьд хоёр зууг худалдан авах зөвшөөрөл¹³⁰, мөн тус пүүсийн тэргүүлэгч Баронхорст болон эмч Руд нараас 1923 оны VI сарын 25-ны өдөр № 692 тоот бичгээр мөн дээрхитэй адил зөвшөөрөл¹³¹ авах хүсэлтээ дахин уламжилж байжээ.

Монгол Улсын ГЯЯ-ны 1923 оны VII сарын 2-ны өдрийн № 567 тоотoor сайд Б. Цэрэндорж "Юэн фунг Трединг & Ко" пүүст агт морь худалдан авах зөвшөөрлийг өгсөн¹³² ба мөн 1923 оны VIII сарын 17-нд дахин агт морь худалдан авах зөвшөөрлийг олгосон байна.¹³³ Үүнээс гадна тус пүүс 1922 оны IV сарын 19-ний өдөр. № 237 тоотoor Хятадаас Хүрээнд авч ирэх хятад пиоз, янчаанаас гаалийн хураамж авах эсэх тухай асуудлаар¹³⁴, 1923 оны XII сарын 29-ний өдөр № 78 тоот бичгээр

¹²⁹ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6, Монгол-Германы харилцааны данс-2, нугалбар № 4.

¹³⁰ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6, Монгол-Германы харилцааны данс-2, нугалбар № 7.

¹³¹ Манжуурын чиглэлээр хил нэвтрэн ирсэн Герман Улсын харъяат эмэгтэй Руд, Бороншид нар Монгол Улсад худалдаа хийх зорилгоор 1925 оны VII сарын 25-нд Манжуураас машинаар хил нэвтрэн ирснийг Зүүн хязгаарын цэргийн тавдугаар тусгай морин дивизийн дарга нараас Гадаад явдлын яаманд 1926 оны VII сарын 19-нд хэрхэхийг шийдүүлэхээр уламжилж байжээ.

¹³² МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6, Монгол-Германы харилцааны данс-2, нугалбар № 8.

¹³³ Мөн тэнд, нугалбар № 9.

¹³⁴ Мөн тэнд, нугалбар № 13.

¹³⁵ Мөн тэнд, нугалбар № 3.

пүүсийн ажилтан Редер бие хамгаалах бичгээ гээгдүүлсэн тул Тяньжин хот явах, буцах үнэмлэх бичиг олгож өгөхийг хүсэх¹³⁵ зэргээр ГЯЯ-тай олон удаа харилцаж байсан байх юм.

Мөн “Юэн фунг Трединг & Ко” пүүстэй холбоотой нэгэн сонирхолтой түүхийн баримт байгаа нь 1922 оны II сард Цэргийн яамны тэргүүн сайд Д.Сүхбаатараас цэргийн дүрэмт хувцасны даавуу материал нийлүүлэх талаар тус пүүсийн төлөөлөгч Гуго Мандль, Луппе Герасимович Козумин нарт хандаж бичиг илгээж байсан ба түүнийг Сангийн яамны зөвлөх Л. Я. Бутин хориглосон цохолт хийж байжээ.¹³⁶

Харин 1925-1928 онуудад Герман Улсын Баронхорст (Юэн фунг Трединг & Ко пүүс болов уу? Р. Т.) хэмээх пүүс манай улсаас агт морь худалдан авч хил гаргаж байсан тухай баримт мэдээ цөөнгүй байна. ГЯЯ-нд БНМАУ-ын Харилцан Туслалцах Хоршооны Ерөнхий Хорооноос 1928 оны VIII сарын 18-нд № 1534 тоот өргөсөн бичигт дурьдсанаар “...Баронхорст нь уг гэрээ бичгийн ёсоор худалдан авч Шанхайд уралдуулах нэгэн мянган морины дотроос энэ хэр Хэнтий уулын аймгийн Өндөрхаан ба Мөнгөн хан уулын хоёр хошуунаас худалдан авсан морь 350, Баянтүмэний хошуунаас худалдан авсан морь 500-г Замын Үүд хэмээх газар явуулж хязгаар нэвтрүүлэхээр завдан буй”¹³⁷ гэснээс үзвэл Германы дээрхи пүүсүүд 1922-1928 он хүртэлх хугацаанд манай улсын Засгийн газрын зөвшөөрлөөр агт морьд худалдсаар байсан ажээ.

Архивын баримтуудад дурьдсанаар эдгээрээс гадна “Юэн ван ян хин” болон “В. Кауфман & Компани”, “Джозеф-Ульман & Компани” зэрэг монополь компаниуд худалдаа хийж байжээ.¹³⁸ Харин Хятад, Оросын компаниуд нь Монголын зах зээл дээр Герман, Англи, Америкийн компаниудтай өрсөлдөх талаар харьцангуй хүч сул байв.

¹³⁵ Мөн тэнд, нугалбар № 5 - 6.

¹³⁶ Бат-Очир. Л Бодоо сайд: Үзэл ба үйлс, түүхэн бие хүн: (Улс төрийн хөрөг), Улаанбаатар, 1991, 40-41-р тал.

Уг пүүс нь агт морьдыг Шанхайд аваачаад далайгаар тээвэрлэн дамжуулж АНУ болон Европын орнууд руу гаргадаг байсан байж болох тал ажиглагдсан бөгөөд мөн хонины ноос, өлөн гэдсийг АНУ-ын Нью-Йорк хотод экспортлон худалдаалдаг байсан баримт байна. (Р. Т)

¹³⁷ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6, Монгол-Германы харилцааны данс-2, нугалбар № 12.

¹³⁸ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6, Монгол-Германы харилцааны данс, хадгаламжийн нэг 74, хуудасны дугаар 7.

Хэдийгээр Германы олон пүүс, фирм, кампаниуд БНМАУ-д албан ёсоор салбараа нээн ажиллуулж байсан боловч тэдний гол томоохон төвүүд нь Хятадад байсан ба ялангуяа Шанхай, Тяньжин хотууд дахь Герман улсын пүүс, фирмүүдийн салбаруудтай манай тал өргөн харилцаатай байсан ажээ. Иймээс ерөнхийдөө Герман Улстай тогтож байсан худалдааны харилцаа нь дараах чиглэлүүдээр явагдаж байсан гэх үндэстэй. Үүнд:

- Хоёр улсын хоорондох албан ёсны хэлэлцээрийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байсан пүүс, кампани, фирмүүд.
- Засгийн газрын зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулж байсан пүүсүүд.
- Хувиар худалдаа хийж байсан иргэд

гэж ангилан үзэж болох юм.

1926 оноос Аж ахуйн явдлын яамнаас Герман Улсын *Apparatenbau, Junkers Motorenbau, Хенпинго, Кручна, Siemens & Schuckert, Antona Game & Co, A.E.G. (Всеобщая Компания Электричества), Швед улсын A/C Karlebo, Christianson* зэрэг пүүсүүдээс гадна монгол сурагчдын суралцаж дадлага хийж байсан олон пүүс, фирмүүдтэй өргөн харилцаатай байсан байна. Гэвч эдгээр пүүс, фирмүүд нь манай улсаас захиалсан зарим шаардлагатай бараа, бүтээгдэхүүнийг импортоор оруулахаас хэтрэхгүй байжээ. Энэ пүүс, фирмүүд нь ихэвчлэн ЗХУ-д концесс авч байсан учир БНМАУ-ын талаас Москва дахь Бүрэн эрхт төлөөлөгчийн газар, "Востваг" компани, Герман Улс дахь ЗХУ-ын худалдааны төлөөлөгчдөөр дамжуулан харилцаж байв.

Ийнхүү гадаад худалдаанд онц эрх тогтоож ЗХУ-ыг худалдаа, эдийн засгийн цор ганц харилцагч орон болгож сонгохоос өмнө манай оронд ЗХУ-аас гадна барууны олон улсын бараа, бүтээгдэхүүн худалдаалагдаж, капитал бэхжин хөрөнгө оруулалтын чөлөөт урсгал бий болох хандлага бүрэлдэж байжээ. Дурьдан буй үед ЗХУ-аас манай улсын эдийн засагт эзлэх хувь хэмжээ ямар хэмжээнд байсныг үзвэл экспортод 20%, импортод 15%-ийг эзэлж байснаас тодорхой харагдана.

Ийнхүү БНМАУ 1925-1930-иад он хүртэлх хугацаанд Герман Улстай худалдаа, эдийн засгийн өргөн харилцаа тогтоож чамламгүй амжилтуудыг олсон юм. Монголд албан ёсоор үйл ажиллагаа явуулж байсан Герман Улсын пүүс, кампаниуд цөөн байсан боловч манай улс 1) Герман Улсын Хятад дахь салбарын олон фирм, кампаниудтай, 2) Герман Улс дахь худалдаа, эдийн засгийн түнш пүүс, фирмүүдтэй шууд байдлаар, 3) Засгийн газраас Берлин хот дахь өөрийн

“Худалдааны төлөөлөгчийн газар”-аар дамжуулан Герман Улсын зохих албадуудтай худалдаа, эдийн засгийн харилцаа холбоо тогтоож харилцаагаа цаашид илүү өндөр хэмжээнд хүргэж албан ёсны болгох асуудаар идэвхтэй яриа хэлэлцээ болж байсан юм.

Эцэст нь тэмдэглэхэд 1925-1930-иад оны үеийн БНМАУ дахь Герман Улсын пүүс, кампаниудын үйл ажиллагааны ерөнхий хандлага нь Засгийн газрынхаа эрх ашгийг төлөөлсөн агуулагатай байсныг дурьдалтай.

Монгол Улсын эдийн засгийн бүх салбарт ЗХУ байр сууриа дангаар бэхжүүлж эхлэсэн нь

Монгол-Герман хоёр улсын хамтын хүчин чармайлтын үр дүнд худалдаа, эдийн засгийн салбарт дахь харилцаа өргөжин хөгжиж 1926 оноос зохистой үр дүнд хүрч Герман Улсад “*Монголын Худалдааны Төлөөлөгчийн газар*”, “*Герман, Франц Улс дахь Монгол сурагчдын захиргаа*” байгуулагдан ажиллах болсноор манай улсын гадаад бодлого дахь бие даасан үйл ажиллагаа тогтворжих хандлага бүрэлдсэн юм.

Гэвч Зөвлөлт Холбоот Улс, Коминтерны зүгээс БНМАУ-д өөрийн эдийн засгийн ашиг сонирхлыг дангаар эзэгнэн тогтоох, цаашилбал тус улсыг гадаад ертөнцөөс бүрмөсөн салган тусгаарлах улс төрийн зорилгоо тулган хүлээлгэхийг эрмэлзэх болсон байна. БНМАУ-аас өрнө дахины орнууд, ялангуяа Герман Улстай цаашид Бүрэн эрхэт улсуудын хувиар харилцаагаа төрийн хэмжээнд хүргэж хөгжүүлэх, худалдаа, эдийн засгийн салбар дахь харилцаагаа бататгах гэсэн үзэл баримтлалтай байсан нь Москвагаар илэрхий зөрчилдсөн том асуудал болон хувирчээ.

Иймээс 1926 оны I сард Засгийн газрын Ерөнхий сайдын жинхэнэ орлогч сайд бөгөөд Аж Ахуйн явдлын яамны сайд А. Амар, Бүх цэргийн зөвлөлийн тэргүүлэгч бөгөөд Засгийн газрын эрхлэх товчооны гишүүн Н. Жадамбаа нарын бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид Москва хотноо айлчилж хоёр улсын худалдаа, эдийн засгийн харилцаанд холбогдох тулгамдсан зарим асуудлаар санал солилцож, зохих үр дүнд хүрч чадсан байна.

ЗХУ-ын Гадаад хэргийн ардын комиссар Г. В. Чичеринд албан захидал хэлбэртэй гардуулсан БНМАУ-ын Засгийн газрын энэхүү

илбан ёсны саналыг ЗХУ-аас зөвшөөрөн хүлээж заасан болзлуудыг илбан ёсоор харгалзан үзэхээ илэрхийлсэн байна. Энэ асуудлыг Засгийн газар 1926 оны III сарын 31-ний өдрийн Хэрэг эрхлэх товчооны гишүүдийн хуралдсан 64-р хурлын 6-р зүйлд багтаан баталж холбогдох нам, НТХ-нд ажлын чиглэл болгон мөрдөхийг даалгасан байна.

Энэ түүхэн үйл явдлын тухай архивийн түүхэн баримтад бичсэнээр *"... Засгийн газрын Ерөнхий сайдын жинхэнэ орлогч сайд бөгөөд Ажлын явдлын яамны сайд А. Амар, Бүх цэргийн зөвлөлийн тэргүүлэгч бөгөөд Засгийн газрын эрхлэх товчооны гишүүн Жадамбаа нараас бидний бие Засгийн газраас олгосон үнэмлэх бичгийг хүлээн аваад Зөвлөлийн Засагт Холбоот улсын нийслэл Москва хотонд одоо хоёр улсын хооронд эдийн засгийн тухай харилцах явдал дор тохиолдон бүхий үл нийцэлдэх зүйлүүдийг устгаж энэхүү харилцах явдлыг сайжруулж нэгэн зам дор оруулах тухай хүсэх зүйлүүдийг тодорхойлон жагсаан бичиж, Холбоот Улсын Гадаад явдлын яамны сайд Чичерин танаа илгээсэн дор мөнхүү сайдаас зөвшөөрөн хариу бичиг өгсөн"*¹³⁹ гэж Москвад айлчласан төлөөлөгчдөөс мэдүүлж байжээ.

Энэ баримт бол энэ үед БНМАУ худалдаа, эдийн засгийн асуудлаар гадаад улсууд лугаа харилцах явдалд ЗХУ-аас хараат бус бие даасан бодлого явуулахыг чухалчилж байсны тод илрэл бөгөөд зохих амжилтад хүрч байлаа.

1927 оны VIII сарын 31-нд М.И.Амагаеваас КИГХ-ны Дорнодын хэлтэст илгээсэн онцгой нууц илтгэх хуудаст баруунтаны удирдагчдын үндсэн төлөвлөгөөний чиглэлийг дурьдахдаа БНМАУ-ын гадаад бодлого дахь үзэл баримтлалыг тодорхойлон *"...гадаад бодлогод ЗСБНХУ-аас гадна шинэ чиг баримжаа олох, боломжийг хичээнгүйлэн эрэлхийлж, үүний зэрэгцээгээр Германд хандах, хөрс суурь бэлтгэж, олон нийтийн санаа бодлыг боловсруулах"*¹⁴⁰ явдал гэжээ.

Ийнхүү 1927 оны сүүлээс Монгол-Герман хоёр улсын харилцаа, ялангуяа худалдаа, эдийн засгийн салбар дахь хамтын ажиллагаа нь Коминтерны анхаарлын төвд байх болж уг асуудлаархи ЗХУ-ын байр суурь эрс идэвхжиж ирсэн байна. БХК(б)Н-ын Төв Хорооны Улс төрийн товчооны 1927 оны VI сарын 16-ны өдрийн 111-р хаалттай

¹³⁹ УТА. Фонд №1, данс- 2, хадгаламжийн нэгж -166, 8-9-р тал.

¹⁴⁰ Коминтерн ба Монгол / Баримтын эмхтгэл /, -Улаанбаатар, 1996, 199-200-р тал.

хуралдаанаас “Востваг” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн эрхийг өргөтгөх талаар № 94-р тогтоолыг гаргасан байна.¹⁴¹

Ингэснээр Германы “Востваг” кампани нь Монгол, Хятад, Афганистан, Перс, Түрэг зэрэг дорно дахины олон орнуудад худалдаа хийх өргөн эрх авчээ. Дурьдан буй үеэс “Востваг” нь ЗХУ-ын Худалдааны Ардын Комиссариатын удирдамжийн дагуу үйл ажиллагаагаа явуулах болсон ба уг тогтоолоор “Востваг”-ын тусгай ажиллагаанд шаардагдах 10 сая орчим рублийг Сангийн Ардын Комиссариатаас санхүүжүүлэх шийдвэр гаргасан байна.¹⁴² Тогтоолоор “Востваг”-ын захиргааг урьдын адил Берлин хотод байлгахгаар заасан байна. ЗХУ-аас БНМАУ-ын гуравдагч орнуудтай харилцах асуудлыг ийнхүү аажмаар өөрийн хатуу хяналтад оруулах бодлого хэрэгжиж эхлэсэн юм. Ганц БНМАУ ч биш дорно дахины олон улсууд ЗХУ-ын дээрхи бодлогын талбар болсон билээ.

1928 оны IX сарын 14-нд КИГХ-ны Улс төрийн нарийн бичгийн дарга нарын газраас Монголын асуудлаар гаргасан маш нууц тогтоолд *“Монгол Ардын Хувьсгалт намын өнөөгийн удирдагчид нь хөдөлмөрчдийн эрх ашгийг хамгаалахаас улам бүр ухарч худалдааны капиталист талд орж, хөдөлмөрчин олон түмэн ба ядуучуудын аж байдлыг сайжруулах зорилтыг хангахгүй, Монголыг харийн капиталист гүрнүүдтэй ойртуулах хандлага гаргаж”*¹⁴³ байгааг онцлон тэмдэглэсэн байна.

МАХН-ын VII Их Хурлын өмнөхөн гаргасан КИГХ-ны Улс төрийн нарийн бичгийн дарга нарын газрын дээрхи тогтоол нь МАХН-д *“барууны”* аюул нэгэнт бүрэлдэн бий болгосныг тэмдэглэж тус нам дахь зүүн хөдөөгийн төлөөлөгчдийг дэмжих замаар МАХН дахь *“эрүүл бус”* гажуудлыг арилган засахад чиглэгдсэн байна. ЗХУ, Коминтерны дээрхи улс төрийн шахалтан доор МАХН дахь зүүний бүлгийн үйл ажиллагаа эрс сэргэж ирсэн бөгөөд 1928 оны X сарын 23-наас XII сарын 11-ний өдрийг хүртэл хуралдсан МАХН-ын VII их хурал нь тус хүчний улс төрийн байр суурийг бататгаж өгсөн байна.

¹⁴¹ Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичигт (1921-1932), Баримтын эмхтгэл, боть I, Улаанбаатар 2002, 230-231-р тал.

¹⁴² Мөн тэнд.

¹⁴³ Коминтерн ба Монгол /Баримтын эмхтгэл I, Улаанбаатар, 1996, 231-232-р тал.

Тухайн үед ЗХУ, Коминтерны зүгээс БНМАУ-ын бие даасан гадаад харилцааг хөгжүүлэх үзэл баримтлалыг өөрийн үндэсний аюулгүй байдал, улс төрийн ашиг сонирхлын үүднээс үнэлэн дүгнэж, ялангуяа Герман Улстай худалдаа, эдийн засаг, соёл боловсролын харилцааг өргөжүүлэн хөгжүүлж цаашид харилцаа холбоогоо төрийн шатанд гаргахыг эрмэлзэж байсан БНМАУ-ын нам, төрийн удирдлагыг "баруунтан" гэдэг нэрээр буруутган уул үйл ажиллагааг нь яаралтай таслан зогсоох замаар БНМАУ-ыг ямар нэг гадаад хоёрдагч түншлэлийн гарзгүй дан ганц ЗХУ, Коминтерны улс төрийн нөлөөг хадгалсан "дагуул" орон болгох төлөвлөгөөг тууштай хэрэгжүүлжээ.

ЗХУ, Коминтерны энэхүү улс төрийн бусармаг үйл ажилагаа БНМАУ-д хүчээ авч бодит байдал болон хэрэгжихэд МАХН-ын VII их хурал түүхэн чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

***МАХН-ын VII Их Хурал ба Монгол - Германы
худалдаа, эдийн засгийн харилцааны талаархи
"Зүүнтний" байр суурь***

1928 оны X сарын 23-наас XII сарын 11-ний өдрийг хүртэл хуралдсан VII их хурал бол БНМАУ-ыг ЗХУ, Коминтерны тогтоол шийдвэрт дуулгавартай захирагдсан "дагуул" орон болгох эхлэлийг тавьж улс орноо хүн төрөлхтний соёл иргэншлийн жам ёсны нийтлэг голдрил чиглэлээр хөгжүүлж дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хөгжингүй орнуудын эдийн засаг, соёл, шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэхийг эрмэлзэж байсан МАХН-ын тухайн үеийн дэвшилтэт сэтгэлгээтэй удирдагчдын улс төрийн байр суурийг сулруулах замаар их гүрнээс бага буурай орны дотоод хэрэгт хутгалдан оролцож өөрийн улс төрийн бусармаг үйл ажиллагааг тулган хэрэгжүүлж байсныг батлах түүхэн баримт мөн.

МАХН-ын VII их хурал Коминтерноос урьдаас төлөвлөгдсөн нарийн зохион байгуулалттай үйл ажиллагаа байв. "Зүүнтний" удирдагчдын нэг Ө.Бадрах Намын VII Их хурлыг дүгнэж бичихдээ: "...Хөрөнгөтний байдлыг тогтоох зорилгыг лоозонг үндсэн зорилгоо болгосон хувьсгалын эсэргүү ангийн итгэлтэй бөгөөд идэвхтэй төлөөлөгч баруун этгээдэд хатуу цохилтоор чанга хэмжээ өгч тус Монгол орны аж ахуй, соёл боловсролын зэрэг хамаг бүтээлтийг хөрөнгөтний бус нийгэм журмын замаар хөгжүүлэх зөв тулгуурыг олж хазайлтгүй

довтлого үйлдэх үндсэн зорилго бодлогыг дахин тодорхойлж заан гаргасан”¹⁴⁴ гэж тэмдэглэсэн байна.

Энэ үеэс 1921 оноос хөтөлбөргүй баримталж ирсэн БНМАУ-ын гадаад бодлого дахь олон талт худалдаа, эдийн засгийн үзэл баримтлал үндсэндээ өөрчлөгдсөн бөгөөд тус их хурлын “Улс төрийн тухай” ерөнхий тайлан илтгэлд “... одоогийн гадаад байдал түгшүүртэй болсон цаг үест гадаад лугаа харилцах бодлогоо улам тодорхой болгож ялангуяа манай улсын тусгаар тогтнох явдал Холбоот Улс лугаа гүнээ холбогдох учир холбоо найрамдлыг улам бататгаж завсардуулах харшлах этгээдийг шууд эсэргүүцэн устгаваас зохино”¹⁴⁵ гэж заасан байна.

Ийнхүү гадаад худалдаа, эдийн засгийн салбарт БНМАУ-ын Засгийн Газрын баримталж байсан бодлого зарчим нь намын их хурал дээр санал зөрөлдөх үндсэн асуудал болж байжээ. “Зүүнтэн” удирагчдаас тус их хурлын зорилтыг “... Хувьсгалын эсэргүү хүчийг бууруулах ба барууны аюулыг эсэргүүцэн устгаж чадахгүй болбоос хувьсгалаар олсон эл бүхий байдлаа бататган хөгжүүлэхэд үлэмжхэн хор саад болох төдийгүй эцэст Коминтерн ба Холбоот улс лугаа хэлхээ холбоо завсардан холдоход хүрэхээс зайлахгүй болох тул манай намаас энэхүү хувьсгалын явдалд саад боомт болох хүчин зүйлүүдийг бууруулан устгахыг шамдах чухал үе мөн”¹⁴⁶ гэж заажээ.

“Зүүнтэн” удирдагчид ЗХУ, Коминтерны дэмжлэгтэйгээр засгийн эрхэнд гарч ирснээр гадаад бодлогодоо ЗХУ-ыг түших бодлого баримтлах нь тодорхой байсан бөгөөд өмнөх удирдагчдын олон талт гадаад бодлогыг залгамжлан үргэлжлүүлэхээс эрс татгалзав.

1928 оны X сарын 23-нд МАХН-ын VII их хуралд зүүнтэн бүлгээс хэлэлцүүлэхээр оруулсан Бадрах, Гэндэн, Шижээ тэргүүнтэй 29 хүний гарын үсэг бүхий “МАХН-ын Хөдөөгийн бүлгийн эрмэлзэх санал” гэсэн бичиг баримтад “... гадаадын эзэрхэг түрэмгий нарын шунахай бодлого лугаа хатуугаар эсэргүүцэх ба дотоодоос хар, шар хуучны үлдэгдэл баруун этгээдийн үндсийг дахин тархи татахгүйгээр бүрмөсөн цэвэрлэх явдалд анхаарлаа хандуулах, цаашилбал ЗХУ-аас салж холдох гэсэн баруунтан удирдагчдын санаархалыг таслан зогсоох”¹⁴⁷ асуудлыг үндсэн асуудал болгон тавьж байжээ.

¹⁴⁴ Ө.Бадрах, Намаас баруун бөөрөнхийчүүд лугаа хийсэн тэмцлийн их туршлага, Улаанбаатар 2001, 9-р тал.

¹⁴⁵ МАХН-ын VII их хурал, Улаанбаатар, 1980, 11-р тал.

¹⁴⁶ МАХН-ын VII их хурал, Улаанбаатар, 1980, 40-р тал.

¹⁴⁷ Мөн тэнд, 47-р тал.

Намын VII их хуралд зүүнтэн удирдагчдаас Герман Улстай харилцах асуудлыг сэрэмжлэн хянаж явуулах саналыг удаа дараа гаргаж байжээ. Жишээ нь төлөөлөгч Лувсаншараваас “... Герман Улсын сурагч мэргэжилтэн нарыг хэрэглэж байгаа нь огт нийцэлдэхгүй бөгөөд Герман Улс болбоос хөрөнгөтний засаг бүхий улс болох тул эдгээр сурагч инженерийн дотор ямар ч зүйлийн шинжлэх эрдэмтэн бүхий хүн байх тул, тус улсын дотор онц чухал тустай хэрэглэгдэх зүйлүүдийг хоцрогдуулж ялимгүй зүйлүүдийг илрүүлэн гаргаж эцэст нь өөрсдөө колони болгон ашиглахыг хичээх”¹⁴⁸ гэсэн бол төлөөлөгч Жигжиджаваас “... Сургагч мэтийн этгээдэд үл тохирох хүнийг авсаар ирсэн нь Германы ажил мэдэхгүй сургагч нар ба Холбоот улсын хэмээвч цагааны үзэлт Сампилон, Английн тагнуулын этгээдийг авч хэрэглэснээс гэрчлэнэ... Сурагч нарыг Германаас авдаг ба машин зэргийг мөн улсаас авдаг болох нь ер тусыг олсон газаргүй байдаг”¹⁴⁹ гэжээ.

Мөн Ө. Бадрах Герман Улстай тогтоосон худалдаа, эдийн засгийн харилцааг хөндөн байдаг. Тэрбээр хэлэхдээ “... Герман Улсад Буриадын цагааны ихээхэн эрдэмтэн этгээд Сампилон нарыг явуулж машин техникийн зүйлийг авахуулах, захих ба мөнгө зээлэхийг эрмэлзэх зэргээр эдийн ба эрдэм боловсролын харилцаатай байж дараагаар тус улсаас багачууд хүүхдийг дагалдуулан сайд Батхаан нарын зэрэг этгээдүүдийг явуулсан хийгээд Герман ба цагааны сургагч нарыг урин ирүүлж хэрэглэх явдлыг олшруулан... Герман ба цагааны хөрөнгөтөнтэй худалдаа, аж ахуй эрдэм соёлын холбоо байгуулах зэрэг хэргүүдийг үүсгэн явуулж байсан”¹⁵⁰ гэжээ.

Дээрхи хурлын төлөөлөгчдийн саналд үндэслэн зүүнтний удирдагчдаас БНМАУ-ын эдийн засгийн гадаад харилцааны үндсэн чиглэлийг ЗХУ-тай голлон тогтоох, өрнөдийн улс гүрнүүдтэй харилцах явдлыг сайтар хянаж гүйцэтгэж байхыг тус их хурлаас гаргасан тогтоолоор баталсан байна. Мөн НТХ-ны дарга Ц.Дамбадорж нь уг хурал дээр өмнө Герман зэрэг барууны орнуудтай харилцаж байсан байр сууринаас ухарч няцсан баримт байна.

Жишээ нь тэрбээр тус хурал дээр тавьсан илтгэлдээ “...Холбоот улсын сургагч нарыг эсэргүүцүүлэн Оросын цагаан намын этгээдийг

¹⁴⁸ МАХН-ын VII их хурал, Улаанбаатар, 1980, 205-р тал.

¹⁴⁹ Мөн тэнд, 314 -р тал.

¹⁵⁰ Ө.Бадрах, Намаас баруун бөөрөнхийчүүд лугаа хийсэн тэмцлийн их туршлага, Улаанбаатар, 2001, 121-122-р тал.

хэрэглэж, мөн Герман сургагч нарыг хэрэглэсээр ч буй"¹⁵¹ гэх зэргээр олон жишээ баримт дурьдан германы мэргэжилтнүүд ба тэдний ажиллаж байсан үйлдвэрийн газруудын ажил байдлыг шүүмжилжээ. Ц.Дамбадоржийн энэхүү байр суурийг Өлзий-очир тэргүүтэй хурлын төлөөлөгчид зарим талаар шүүмжилж байв. Гэхдээ тус их хурлаас гаргасан гадаадтай харилцах явдлын тухай тогтоолд зааснаар Герман Улс нь БНМАУ-ын харилцаа тогтоохоос болгоомжлох улсын тоонд ороогүй байгаа нь сонирхол татаж байгаа юм.

Ийнхүү МАХН-ын VII их хурлын дараагаар БНМАУ-ын худалдаа, эдийн засаг, соёл, боловсролын салбар дахь үйл ажиллагааны хандлага төлөв эрс өөрчлөгдөж 1921 оны Үндэсний Ардчилсан хувьсгалын дараагаар олж авсан үндэсний уламжлал эрх ашгаа дээдэлсэн олон тулгуурт гадаад бодлого явуулах хэтийн зорилготой төрийн бодлогын залгамж чанар алдагдаж улс орон бүхэлдээ хэт хувьсгалжсан цаг үеийг туулах эхлэл тавигдсан байна. Коминтерны шахалт, МАХН-ын VII их хурлын хийрхсэн шийдвэрийн дагуу БНМАУ энэ үеэс хурдацтайгаар хувьсгалжих замд оржээ. 1929 оны VI сарын 27-ны өдөр Монгол-Зөвлөлтийн харилцааны үндсэн асуудлыг тогтоосон гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан нь БНМАУ-ын гадаад харилцааны асуудлыг үндсээр нь өөрчилсөн албан ёсны бичиг баримт болов.

Уг гэрээнд зааснаар *"... СССР нь Монголыг, Монгол нь СССР-ийг онцоор үзсэн лугаа адил бусад гадаад улсыг үзэх болсон нь хоёр этгээдийн уул бодлого зорилго лугаа үл нийцэх тул аливаа гадаад улсууд ба тэрхүү улсуудын харъяат нарт тийнхүү онцоор үзэх явдлыг үл дэлгэрүүлэхийг хоёр этгээдээс батлана."*¹⁵² гэж заасан байна.

Ингэснээр 1929 онд багтаан Герман, Их Британи, АНУ, Дани, Франц, Унгар, Польш, Итали зэрэг улсын 4000 иргэдийг албадан буцаасан байна.

БНМАУ-ын Засгийн газрын 1930 оны XII сарын 12-ны өдрийн 41-р хуралдаанаас гаргасан тогтоолын 4-р зүйлд *"Гадаад худалдаанд онц*

¹⁵¹ МАХН-ын VII их хурал, Улаанбаатар, 1980, 98 -р тал.

* Харилцаа тогтоохоос болгоомжлох улсуудад Хятад, Япон, Англи, Америк, Франц гэх мэт улсуудыг дурьдсан байна.

¹⁵² Монгол-Зөвлөлтийн ган бат найрамдал (1921-1940), Улаанбаатар, 1968.

эрх тогтоох тухай” заасан байна.¹⁵³ Гадаад худалдаанд онц эрх тогтоон ЗХУ-аас бусад гуравдагч орны худалдаа, эдийн засгийн капиталыг шахан гаргаснаар манай улсын эдийн засагт ЗХУ-ын эзлэх байр суурь тасралтгүй нэмэгджээ. Гадаад худалдаанд улсын онц эрх тогтоож өгснөөр ЗХУ-аас оруулж ирэх эд барааны хэмжээ асар түргэн өсч үнийн дүнгээрээ 1928-1932 онд 2,4 саяас 54. 0 сая төгрөг болж 22, 4 дахин өссөн байна.¹⁵⁴

Энэ нь манай улсын гадаад худалдааны зохистой тэнцвэрт харилцаа алдагдаж ЗХУ-аас эдийн засгийн хараат улс болох эхлэлийг тавьжээ. Энэ тухай Германы Гадаад Худалдааны Төв газраас Засгийн газар болон олон яамдаа өргөн илгээсэн бичигт *“Монголын бүх яаманд Москвагийн оросууд зөвлөх гэгчээр ажиллаж байна. Тэд Монголд Зөвлөлтийн тогтолцоог бараг бүрэн нэвтрүүлээд буй. Хуучин тэдгээр яамдад Монголчууд ажиллаж, ямар нэг хэмжээгээр асуудал шийдэж байсан, одоо тэдний зарим нь ажлаасаа гарч, нэг хэсэг нь баривчлагджээ. Сүүлчийн баривчлагсдын дотор германаар чөлөөтэй ярьдаг Сампилон орсон”*¹⁵⁵ гэж энэ үеийн Монголын улс төр, эдийн засгийн байдлыг дүгнэн бичсэн байдаг.

1932 оны V сард БХК(б)Н-аас манай талд өгсөн удирдамжинд гадаад худалдааны онц эрхийг хэлбэлтгүй хадгалах, өөрийн төгрөгийг хилийн чанадад биржийн наймааны объект болгохгүй байх зэргийг заасан ба харин зарим барааны хувьд Засгийн газрын шууд хяналтын дор хоёрдагч оронтой худалдаа хийж болох тухай өгүүлсэн байдаг.¹⁵⁶

1935 оны VIII сарын 1-ний өдөр Монгол банкнаас № 4732 тоот албан бичгээр Гадаад Явдлын яамаар дамжуулан Москва дахь БНМАУ-ын элчин сайдын яаманд мэдэгдсэнээр хоёрдагч оронд валют гуйвуулах үйл ажиллагааг зогсоох шийдвэр гаргасан тухай дурьдсан байна.¹⁵⁷

¹⁵³ БНМАУ-ын социалист худалдааны түүхэнд холбогдох баримт бичиг (1920-1940), Улаанбаатар, 1974, 202-р тал.

¹⁵⁴ МЭХХ-дын X Их хурлын илтгэлийн хэрэглэгдэхүүн, Улаанбаатар, 1938.

¹⁵⁵ Ж.Болдбаатар, Түүх зулсан он жилүүдийн ойллого, боть I, Улаанбаатар, 2003, ХБНГУ-ын Бундес архивт буй Монголын тухай баримт сэлт (1921-1930), 288-294-р тал.

¹⁵⁶ Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичигт (1921-1932), Баримтын эмхтгэл, боть I, Улаанбаатар, 2002, 380-р тал

¹⁵⁷ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6, хадгаламжийн нэгж -6, хуудасны дугаар - 42.

Ингэснээр Герман Улсын Монголд ажиллаж байсан иргэд банкинд хадгалуулж байсан мөнгөө авч чадахгүй хохирох явдал их гарч байсан тухай уг бичигт дурдсан байна.

Ийнхүү БНМАУ түүхийн ахархан хугацаанд огцом эргэлт хийв. 1925-1928 онд худалдаа, эдийн засгийн салбарт нээлттэй гадаад бодлого явуулснаар бүрэлдсэн өмнөх үеийн бие даасан шинж чанараа алдсан байна. Үүнд олон зүйл нөлөөлсөн.

- ЗХУ, Коминтерны дэмжлэгтэйгээр “зүүнтний” хийрхэл газар авч Засгийн газраас 1930 оны XII сарын 12-нд гадаад худалдаанд онц эрх тогтоосноор Монгол орны зах зээлд эзлэх гуравдагч орнуудын оролцоог шахан гаргасан.
- Хятад орны дотоодод иргэний дайн ихээхэн газар авснаар Монголын зах зээлд орж ирэх бараа, бүтээгдэхүүний тоо хэмжээ эрс цөөрч 1929 оноос хил хаасан явдал нь хэрэгцээ шаардлагатай зүйлсийг дан ганц Оросоос авахад хүргэсэн.
- Герман Улс дахь Хятадын талыг баримтлагсад, нөлөө бүхий бизнесменүүд Сибирийн төмөр замаар дамжин БНМАУ-тай худалдаа хийхийг эсэргүүцэж байсан.

гэх мэт үндэслэлүүдийг дурьдаж болох юм.

Дээр дурьдсан түүхэн шалтгаануудаас гадна Германы зарим засаг захиргаа, бизнесийн хүрээнийхэн БНМАУ-тай хийх худалдааг дэмжсэн

“Зүүнтний хийрхэл” газар авснаар Монголын ард түмний олон зуун жилээр хэмжигдэх аж ахуй, соёлын уламжлалт амьдралын хэвшлийг богино хугацаанд өөрчлөхийг муйхарлан оролдсон олон зохисгүй ажиллагааг явуулсан ба үүний үр дүнд 1932 онд манай улсын хэд хэдэн аймгийг хамарсан бослого тэмцэл гарсан боловч түүнийг зэвсгийн хүчээр нухчин дарсан юм. Манай өнгөрсөн түүх бичлэгт уг бослогыг “эсэргүү бослого” хэмээн нэрлэсээр ирсэн боловч 1990-иэд оноос хойш энэ бослогын түүхэн учир шалтгаан, нөхцлийг бодитойгоор олон талаас нь судалсны үр дүнд шинэлэг дүгнэлтүүдийг дэвшүүлэх болжээ. Харин 1932 оны 5 сарын 16-ны БХК(б)Н-ын хуралдаанаас гаргасан № 171 тоот тогтоолд 1932 оны бослогын учир шалтгааныг дүгнэн бичсэн нэгэн сонирхолтой баримт байгаа нь:


“... 1. Монгол нөхдийн (Зүүнтний удирдагчидыг хэлж байна. Р. Т) үндсэн алдаа бол Зөвлөлт Бүгд Найрамдах Улс бол хөгжсөн аж үйлдвэртэй, пролетари бүхий социалист улс, харин Бүгд Найрамдах Монгол Улс бол хөрөнгөтний ардын ардчилсан улс гэдгийг ойлгохгүй, ЗСБНХУ-ын Зөвлөлт Засгийн бодлогыг тэд сохроор хуулж байгаад оршиж байна.

2. Энэ алдаа бол одоо Монголд өрнөж байгаа бослогын гол шалтгаан мөн” гэж заажээ.

Энэ тухай баримт Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичигт (1921-1932), Баримтын эмхтгэл, боть I, Улаанбаатар 2002, 371-р талд буй).

бол ЗХУ-аас БНМАУ-ын гадаад худалдаанд эзлэх нийт бараа эргэлтийг 30 хувиас хэтрүүлэхгүй барьж байх түүхэн нөхцөл бүрэлдэж болох байжээ.

График № 1



Харин Монголд явагдаж байсан энэхүү үйл явцтай давхцан Берлин хотод хоёр улсын хооронд албан ёсны гадаад харилцаа тогтоох асуудал хөндөгдөж, улмаар тус хотод Монголын Консулын газрыг байгуулах хэлэлцээр явагдаж байсан байж тун болзошгүй байна. Гэвч энэ тухай албан ёсны нотлогоо болох баримт олдохгүй байна.

Энэ тухай Дж. Фритерс бичихдээ “... 1934 онд Германы нэгэн зохиолч бичихдээ, БНМАУ Германд Бүрэн Эрхэт төлөөлөгчийн газартай байсан гэжээ. Хэрэв ийм тохиолдол байсан гэж үзэхэд хувийн болон албаны эх сурвалжаас тодруулах бололцоо олдсонгүй бөгөөд энэ нь бараг л худал зүйл болов уу”¹⁵⁸ гэжээ.

Герман Улсад “БНМАУ-ын Бүрэн эрхэт төлөөлөгчийн газар” албан ёсоор байгуулагдаж чадаагүй бололтой. Гэвч тус төлөөлөгчийн газрыг нээх асуудлыг нааштайгаар шийдвэрлэж үндсэн тохиролцоонд хүрсэн нь тодорхой байгаа юм. Ийнхүү Монгол-Герман хоёр улсын харилцан ашиг сонирхол, хүчин чармайлтын үр дүнд 1926-1930 онд худалдаа, эдийн засгийн салбарт Герман Улстай өргөн харилцаатай байж Герман Улсын мэргэжилтэн боловсон хүчнүүд Монгол Улсад уригдан ирж

¹⁵⁸ Б.Батбаяр, ХХ зууны Монгол: Нүүдэл суудал, гарз олз, Улаанбаатар, 1996, 356-р тал.

ажиллан хоёр улсын харилцаа, хамтын ажиллагаа өргөн цар хүрээнд бэхжин хөгжиж байсан боловч олон улсын харилцааны тэгш бус байдал, ЗХУ-ын улс төрийн ашиг сонирхолтой уг асуудал нь нийцээгүйн улмаас худалдаа, эдийн засгийн салбарт Герман Улстай харилцах явдал удаан хугацаагаар тасалдахад хүрчээ.

Түүхийн гурвалжин:

- Олон улсын харилцааны хандлага

- Гадаад Монголын тусгаар тогтнол

- Монгол - Германы харилцаа

1929-1932 оны дэлхийн эдийн засгийн хямрал нь колони эзэмшигч Англи, Франц орнуудын хувьд харьцангуй хохирол багатай болж өнгөрөв. Учир нь эдгээр улсууд колони орнуудынхаа зах зээл рүү үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ шахаж замаар худалдааны эргэлтээ зохицуулж чадсан бол Герман зэрэг колони эзэмшлээ алдсан орны хувьд капиталын түгжигдмэл бөөгнөрөл үүсч эдийн засагт нь хямрал нүүрлэжээ. Эдийн засгийн хямрал Герман Улсын хүнд үйлдвэрлэлийн салбарыг илүүтэйгээр хамран явагдаж аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 1929-1932 онд 48%-иар, гадаад худалдаа 60% -иар буурсан үзүүлэлт гарсан байна.¹⁵⁹

Мөн 1932 оны зун гэхэд эдийн засгийн хямрал дээд цэгтээ тулж, үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний хэмжээ хямралын өмнөх 1929 оныхтой харьцуулахад дөнгөж 59% болсон байна.¹⁶⁰ Эдийн засгийн энэхүү хямралт байдлын улмаас Герман Улсын дотоод байдал нэн тогтворгүй болов. Энэ үеэс Герман Улсын Азийн орнууд руу чиглэсэн худалдаа, эдийн засгийн харилцаа эрс суларчээ. Эдийн засгийн хямралаас үүдэлтэй нийгмийн энэхүү савлагааны үр дүнд 1933 онд нацистууд засгийн эрх авсан юм. Энэ үе хүртэлх ЗХУ-ын гадаад бодлого нь Герман Улсын талыг баримталсан шинжтэй байсан ба өдгөө Зөвлөлт-Германы нууц харилцааны ээдрээтэй түүхэн асуудлууд нэгэнт ил тод болж эхлээд байна.

Үзэл суртлын үүднээс Европт хувьсгал гаргахад нөлөө бүхий орон хэмээн Оросуудын үзэж байсан Герман Улс ийнхүү ЗХУ-ын хяналтаас гарчээ. *Берлин-Ром-Токиогийн гурвалсан эвсэл* бий болж Коминтерны эсрэг Пактад нэгдлээ. Энэ бүхэн нь Версалын эрин үе нуран унахын

¹⁵⁹ Лосол, 1924-1939 оны Герман Улс, Улаанбаатар, 1948.

¹⁶⁰ ХХ зууны Дэлхийн түүх, Улаанбаатар, 2001, 145-р тал.

дохио болов. Яг энэ үетэй давхцан Алс Дорнодод Япончууд Манжуурыг эзлэн авч бэхжсэн байна. Олон улсын харилцааны энэхүү түгшүүртэй байдал нь БНМАУ-ын тусгаар тогтнол, аюулгүй байдалд сөрөгөөр нөлөөлж болзошгүй байв.

Харин ЗХУ, Коминтерноос БНМАУ-ын талаар баримталж байсан улс төрийн байр суурь нь анхнаасаа тодорхой байсан ба 1929 оны I сарын 7-ны өдөр “Монголын асуудал”-аар хуралдсан КИГХ-ны Дорнодын Нарийн бичгийн дарга нарын газрын хуралдаан дээр гишүүн Б. Шмералын хэлсэн үг үүнийг батлан харуулж байна. Тэрээр хэлэхдээ “... Бид Монголын өвөрмөц байдлыг харгалзах хэрэгтэй. Бид энд олон улсын маш чухал ач холбогдол бүхий асар өргөн уудам нутаг дэвсгэртэй тулгарч байна.

... Энэ нутаг дэвсгэрт нөлөөгөө хадгалж, ядахдаа Монголыг империалистууд хийгээд дэлхийн хувьсгалын дайсны нөлөөнд оруулахгүй байхыг сөрөг аргаар ч болов хичээх нь манай зорилт мөн гэж би хэлж байна.

... Нутаг дэвсгэр хүн амаас ч илүү чухал ач холбогдолтой бөгөөд хэргээ бид энэ цөөхөн хүн амыг капиталист биш хөгжлийн замаар оруулж, Монгол дахь хөдөлгөөнийг хөдөлмөрчин ард олны ангийн тэмцэл болгож чадвал зөвхөн ийм янзаар л бид энэ нутаг дэвсгэрийг нөлөөндөө байлгаж чадна”¹⁶¹ гэжээ.

Хэдийгээр Б. Шмералын хэлсэн дээрхи саналаар ЗХУ, Коминтерны БНМАУ-ын талаар баримтлаж байсан бодлого үйл ажиллагааг бүрэн тодорхойлоход хангалттай бус гэдэг нь ойлгомжтой боловч дээрхи санаа нь үндсэндээ 1921 оноос хойш ЗХУ-ын Монголын талаар баримталсаар ирсэн урт хугацааны бодлого байсан гэдэг нь ойлгомжтой.

Өөрөөр хэлбэл Б. Шмералын дээрхи санал нь хожим БНМАУ-д түүхэн бодит байдлаар хэрэгжсэн билээ. Дурьдан буй үед ЗХУ, Коминтерн нь БНМАУ-ыг цэрэг, стратегийн түшиц газар болгон ашиглахыг илүүтэй сонирхож байсан нь ажиглагддаг бөгөөд энэ нь Дэлхийн I дайнаас сургамж авсан ЗХУ-ын Алс дорнод дахь аюулгүй байдалтай холбоотой байсан болов уу?. Энэ тухайд холбогдох нэгэн түүхийн баримт байгаа нь 1934 оны X сарын 29-нд КИГХ-ны төлөөлөгч Б. Шмераль, В. Коларов нараас МАХН-ын IX их хурлын дүнгийн тухай бичсэн илтгэх хуудас болно.

¹⁶¹ Коминтерн ба Монгол (Баримтын эмхтгэл), Улаанбаатар, 1996, 284-р тал.

Энд дурьдахдаа "...Японы халдан орох аюул болон ЗСБНХУ-ыг батлан хамгаалахад БНМАУ их ач холбогдолтойгоор үүдэн гарч буй шууд тулгамдсан зорилтуудын үүднээс авч үзэх"¹⁶² тухай хариуцлагатайгаар дурьдсан байна. Энэ нь доорхи шалтгаанаас үүдэлтэй юм.

- Алс Дорно дахь өөрийн аюулгүй байдлыг сахин хамгаалахад тус улсын нутаг дэвсгэрийг аюулгүй байдлын жийргэвч бүс болгон ашиглах

- Ямарваа гуравдагч этгээдээс цэрэг, улс төрийн зорилгоор БНМАУ-ын нутаг дэвсгэрийг ЗХУ-ын эсрэг ашиглах санаархлыг таслан зогсоох

зэрэг шалтгааны улмаас БНМАУ-ыг өөрийн улс төрийн нөлөөнд баттай барьж байх ЗХУ-ын шаардлага нь тус улсаас Герман зэрэг гадаадын хөгжингүй улсуудтай худалдаа, эдийн засаг болон бусад салбарт өргөн харилцаа тогтоох, цаашид бүрэн эрхэт улсуудын хувиар харилцаагаа төрийн хэмжээнд хүргэж хөгжүүлэх зорилго, эрмэлзлэлийг Москвагийн зүгээс бүрмөсөн үгүйсгэх үндэслэл болжээ.

Харин БНМАУ-ын хувьд олон улсын байдал ийнхүү түгшүүртэй болсон цаг үед тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлаа хамгаалахын тулд тус улсыг албан ёсоор хүлээн зөвшөөрөөд байсан цор ганц улс болох ЗХУ-д хандсан бодлогоо тууштай үргэлжлүүлэхээс өөр түүхэн сонголт байгаагүй биз ээ. Энэ бол бага буурай улсын түүхийн өмнө хүлээсэн гашуун боловч үнэн зам байсан гэлтэй.

Энэ нөхцөлд БНМАУ гадаад бодлогоддоо ЗХУ-ыг түшиж, түүний нөлөөний орнуудтай харилцаа тогтоох асуудлыг гол зорилгоо болсон ба харин бие даасан гадаад бодлого явуулах нь бараг л бололцоогүй зүйл болсон юм. Мөн Гадаад Монголын тусгаар тогтнолыг олон улсын түвшинд нэг мөр хүлээн зөвшөөрөх нь ч тухайн үед ерөөс бололцоогүй зүйл байжээ. Ийнхүү БНМАУ ЗХУ-ын нөлөөний хүрээнд баттай орсон дагуул орон боллоо. МАХН-аас худалдаа, эдийн засгийн салбарт капиталист бус хөгжлийн чиглэлд тууштай замнах, улс ардын аж ахуйг таван жилээр төлөвлөх, гадаад худалдааны онц эрхийг ЗХУ-ын эрх ашигт нийцүүлэн тууштай баримтлах зэрэг бодлого нь ЗХУ-аас гадна хоёрдагч оронтой харилцах бүх боломжийг үгүйсгэв.

¹⁶² Коминтерн ба Монгол (Баримтын эмхтгэл), Улаанбаатар, 1996, 410-р тал.

Ингэснээр Герман Улстай тогтоож байсан албан бус харилцааны олон зүйл тохиролцоонууд аяндаа хүчингүй болсон юм. 1930 оны XII сарын 12-ны “Гадаад худалдаанд онц эрх тогтоох тухай”¹⁶³ тогтоолтой уялдан ЗХУ-д үйлдвэрлэдэггүй бараа бүтээгдэхүүнүүдийг гурав дахь орноос БНМАУ-д нийлүүлэх зорилгоор Коминтерны хяналтанд Герман Улсын монопольт компани “Востваг”-ын тус улс дахь эрхийг 1927 онд өргөтгөсний дагуу үйл ажиллагааг нь хэвээр үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн байна. Иймээс энэ үед Монгол-Германы худалдаа, эдийн засгийн харилцаа нь ихээхэн явцуу агуулагатай болж ирсэн ба БНМАУ-д хаагдалгүй үлдсэн Герман Улсын цорын ганц компани “Востваг”-ын үйл ажиллагааг ч ЗХУ-аас хянан зохицуулах болжээ.

Энэ тухай БХК(б)Н-ын Төв Хорооны Улс Төрийн товчооны 1932 оны XI сарын 1-ний өдрийн №190-р тогтоолын 8-р зүйлд “БХК(б)Н-ын Төв хорооны V сарын 29-ны удирдамжийг хэрэгжүүлэхийн тулд Зөвлөлт Улсад бэлтгэдэггүй буюу манайхаас зөвөөрлөж болохооргүй мөн газарзүй-тээврийн нөхцөл нь хойноос тээвэрлэхэд бололцоогүй тийм барааг (ялангуяа Хаалганаар дамжуулан Хятадаас хуурай замаар бүх Монгол ба Туваг хангах цайг тээвэрлэх) Монголд гуравдахь орноос хангах эрхийг Англиас Төв холбоогоор дамжуулан Бөөний худалдааны Нийгэмлэгт олгосон зээлийг ашиглан хангах. Энэ худалдааг Востваг-аар дамжуулан Монголын Худалдаа ба аж үйлдвэрийн яамны шууд удирдлагаар гүйцэтгэх бөгөөд энэ зорилгоор тэнцэх хэмжээний барааг гуравдагч оронд гаргаж, зохих хэмжээний хэрэгцээт барааг авах эрхийг Монголд олгох”¹⁶⁴ гэж заасан байна.

Дээрхи тогтоолын дагуу Германы монопольт кампани “Востваг” нь манай улсын экспорт, импортын чиглэлд нөлөө бүхий үйл ажиллагаа явуулах болсон юм. Гэвч Монгол дахь 1930 он хүртэл Воствагын үйл ажиллагаа нь харьцангуй өргөн хүрээг хамарч чадаагүй ба тус компани үйл ажиллагааны өргөжилт нь 1930 оны XII сард гадаад худалдаанд онц эрх тогтоосонтой холбоотой.

Учир тэр үеэс ЗХУ-д үйлдвэрлэдэггүй машин, тоног төхөөрөмж болон аж үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг гуравдагч зах зээлээс

¹⁶³ БНМАУ-ын социалист худалдааны түүхэнд холбогдох баримт бичиг (1921-1940), Тэргүүн дэвтэр, Улаанбаатар 1974, 202-р тал.

¹⁶⁴ Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичигт (1921-1932), Баримтын эмхтгэл, боть I, Улаанбаатар, 2002, 416-417-р тал.

нийлүүлж байх зорилгоор Воствагын БНМАУ дахь бизнесийн үйл ажиллагааг өргөтгөхийг ЗХУ дэмжиж байв.

Герман Улстай эдийн засгийн харилцааг үргэлжлүүлэх талаар Монголын зарим удирдагчдын гаргасан хүчин чармайлт, түүний үр дүн

1926 оны дундуур МАХН-ын Намын Төв хорооны дарга Ц.Дамбадорж Европт айлчлаад буцах замдаа Москвад түр саатсан ба энэ үеэр *“Известия Уланбатор хото”* сонины сурвалжлагчид сонирхолтой ярилцлага өгсөн байна. Тэрбээр хэлэхдээ *“... Нийт хүн төрөлхтөний үнэт зүйлсийн хувьд тэдгээр (барууны) орны соёл иргэншлээс тунгаан тусгах, зүйл их байна. Монгол Улсын тусгаар тогтнон хүмүүжих явдал нь гадаад ертөнцөөс зожигрох бус нээлттэй байх явдал юм”*¹⁶⁵ гэж цохон тэмдэглэсэн байна.

Энэ мэтчилэн гадаад харилцааг дан ганц ЗХУ-тай дагнан хийх бус худалдаа, эдийн засаг, соёл, боловсролын салбарт өрнөдийн улсуудтай нээлттэй харилцахыг чухалчилж байсан нь БНМАУ-ын тусгаар тогтнолыг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрүүлснээр л жинхэнэ утгаар нь батлагаажуулж чадна гэсэн үзэл баримтлалтай шууд холбоотой байсан болов уу? Энэ тухай А. Амар тэргүүтэй манай улсын дэвшилтэт үзэлтэй удирдагчид МАХН-ын VII их хурал дээр гаргасан зүүнтнүүдийн шүүмжлэлийн хариуд байр сууриа тодорхой батлан өгүүлсэн зүйл цөөнгүй байна.

Тус хурал дээр А. Амар хэлэхдээ *“...гадаад харилцааны тухай болбоос, Холбоот улстай найрамдалтай учир халуун үнэн саналаар харилцан буй. Бусад улс хэдийгээр бидний улсыг зөвшөөрөн хүлээж, найрамдал байгуулаагүй боловч манай улсаас Москвад суулгасан элчин сайд болбоос мөн улсад суугаа бусад олон элчингүүдийн холбоонд орсон тул тэдний элчингүүд лүгээ хэдийгээр Холбоо улсын мэт халуун үнэнчээр бус боловч нийтийн ёсыг дагаж энгийн зэрэг харилцсаар буй”*¹⁶⁶ гэжээ.

А. Амарын хэлсэн дээрхи үг нь дурьдан буй үеийн БНМАУ-ын гадаад харилцааны ерөнхий хандлага, төлөвийг оновчтой товч тодорхойлсон байна. Тэрээр цааш хэлэхдээ *“... Бас энэ завсар Франц ба Герман улсуудад цөөн тооны сургуулийн хүүхдүүдийг явуулсан ба Герман*

¹⁶⁵ Известия Уланбатор хото, 1926.10.1, № 13.

¹⁶⁶ МАХН-ын VII их хурал, Улаанбаатар, 1980, 205 -р тал.

улсаас машин зэрэг бага сага эдлэл хэрэглэл авчрах зэргээр харилцсаар буй. Энэ мэтээр харилцсаар байхдаа тэдний улсаас ашиг тус үзүүлэх болов уу хэмээн горилох бус зөвхөн тусгаар улс болсон байдлыг нийтэд илрүүлэх ба хөвгүүдийг хэл бичигт боловсруулах зэргийн явдал болно. Америк, Герман нарын гадаад улсуудын зарим нэг эрдэмтэн нараас нийтийн шинжлэх эрдмийн ёсоор Монголд орж ирэх зөвшөөрлийг гуйн ирэх бөгөөд бид нэгэнт тусгаар улс тул зүй байдлыг хянан нийтийн ёсоор зөвшөөрлийг олгосоор буй амуу”¹⁶⁷ гэсэн байдаг.

Ялангуяа энд онцлон тэмдэглэхэд А. Амар нь Монголын төрийн тулхтай том зүтгэлтэн байсны хувьд улс орныхоо үндэсний уламжлалыг дэлхийн нийтийн хөгжлийн ололттой талаар баяжуулах замаар хөгжүүлэх үзлийг баримталж байсан юм.

Сүүлд 1937 оны III сарын 7-нд МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн 37-р хурлаас “А. Амарын нам бус явдлын тухай” хэлэлцсэн хурлын протоколд тэмдэглэснээр Намын Төв Хорооны дарга Лувсаншараваас илтгэхдээ “...Германд Монгол сурагчидыг явуулсан, Манжуурт байсан Германы төлөөлөгчтэй харилцан Германы төмөр замыг Монголд байгуулах тухай ярилцсан, Германы Гадаад Явдлын яаманд дипломатын харилцаа тогтоохоор харилцсан”¹⁶⁸ гэх мэт үндэслэлээр буруутгасан эндээс үзэхэд А. Амар нь нийгмийн байгуулал, үзэл суртлын ялгааг үл харгалзан Герман Улстай харилцаагаа өргөжүүлэхийг эрмэлзэж байсныг давхар баталж байна.

Мөн Амар Ж. Цэвээний нэгэн адил Монгол орныг далайд гарзтай болгох боломжийн талаар эрэлхийлэн аж ахуйг эдийн засгийн бодит сонирхолд тулгуурлан хөтлөн явуулах, үндэсний хөрөнгөлөг хэсэг болон гадаад капиталын хүчийг улсын хөгжилд ашиглах, энэ үүднээс Европын Герман зэрэг хоёрдагч орнуудтай харилцаж хүн төрөлхтөний үнэт зүйлсээс суралцах нь нэн чухал ач холбогдолтой гэж үзэж байв. А. Амар ЗХУ-тай худалдаа, эдийн засгийн үзэл баримтлалын хувьд санал зөрөлдөж байсан олон асуудал байсан ба дээр өгүүлсэнчлэн 1926 онд Москвад айлчлахдаа ч энэ асуудлаа тавьж байсан юм.

¹⁶⁷ Мөн тэнд, 230-р тал.

¹⁶⁸ С.Энхжин, Ерөнхий сайд А.Амар: Нийгэм, улс төрийн үйл ажиллагаа, Түүхийн ШУ-ны дэд доктор/Ph.D/-ын зэрэг горилсон бүтээл, Улаанбаатар, 2001, 30-р тал.

БНМАУ дахь ЗХУ-ын элчин сайд П. М. Никифоровын тэмдэглэлээс зарим түүхэн баримтыг доктор С. Энхжин судалгаандаа оруулсан байна. Элчин сайд П. М. Никифоровын тэмдэглэлд *“Ерөнхий сайдын жинхэнэ орлогч, Аж Ахуйн Явдлын яамны сайд А.Амар нь гадаад харилцааг зөвхөн ЗХУ-тай дагнан хийх бус харин Монгол улс өөрийн хөлөг онгоцтой болж Хар далайд өөрийн гарц боомт нээж Герман зэрэг европын бусад улсуудтай худалдаа хийхийг эрмэлздэг”*¹⁶⁹ тухай бичсэн байна.

1940 оны VII сарын 10-нд Москвад ЗСБНХУ-ын Дээд Шүүхийн Цэргийн Коллегийн хаалттай хуралдаанаар А. Амарт ЗСБНХУ-ын Эрүүгийн хуулийн 58-ын 1а, 2-р зүйл ангиар ялын дээд хэмжээ оноосон бөгөөд уг шүүх хурал дээр А. Амарын өгсөн сүүлчийн мэдүүлэгт *“... манай Монгол Улстай алс хол оршдог учир Герман улстай холбоо тогтоохыг эрмэлзэж байлаа. 1928 он хүртэл Германы Гадаад Явдлын яамны сайдтай дотно холбоотой байж, түүнтэй бичиг захидлаар харилцдаг байв. ... Би Герман улстай холбоо тогтоон БНМАУ-д эрдмийн ажилтантай болохыг хүсч байлаа. Мөн тэдний элчин сайд нь Улаанбаатарт очоосой гэж хүсч байлаа”*¹⁷⁰ гэж өгүүлсэн байдаг.

Энэ баримт нь А. Амар Монголын төрийг барилцаж байхдаа Герман Улстай төрийн харилцаа тогтоохыг туйлаас хүсч байсныг нотлон харуулж байна.

Ер нь А.Амар төдийгүй Б.Цэрэндорж, Ц.Дамбадорж, Н.Жадамбаа, Ж.Гэлэгсэнгэ, Ж.Цэвээн тэргүүтэй Монголын тухайн үеийн сэхээтнүүд цөм дээрхи байр суурийг баримталж байсан юм. Жишээ нь 1928 оны Намын Төв хорооны хурал дээр Н.Жадамба, Ц.Дамбадорж нар *“...Хятад, Япон, Герман, Англи, Америктай ойртох нэгдэх гэсэн юм байхгүй, гагцхүү Монгол Улс бүрэн тусгаар тогтнолоо албан ёсоор хүлээлгэн зөвшөөрүүлэхийн тулд гадаад улстай хууль ёсны хүрээнд харилцаж ирсэн нь буруу болж байна уу?”*¹⁷¹ гэж мэдэгдэж байжээ.

Ингэж 1928 оны X сарын 23-наас XII сарын 11-ний өдрийг хүртэл хуралдсан МАХН-ын VII их хурлаас гарсан шийдвэр, гадаад

¹⁶⁹ С.Энхжин, Ерөнхий сайд А.Амар: Нийгэм, улс төрийн үйл ажиллагаа, Түүхийн ШУ-ны дэд доктор /Ph.D/-ын зэрэг горилсон бүтээл, Улаанбаатар, 2001, 30-р тал.

¹⁷⁰ Мөн тэнд.

¹⁷¹ Б.Батбаяр, ХХ зууны Монгол: Нүүдэл суудал, гарз олз, Улаанбаатар, 1996, 357-р тал.

худалдаанд онц эрх тогтоосон зэрэг асуудлуудаас үндэслэн Монгол-Германы аж үйлдвэр, худалдааны салбарууд дахь ергөн харилцаа 1930 он гэхэд үндсэндээ тасарсан гэж үзэж болно.

Гэвч энэ үед Москва дахь БНМАУ-ын элчин сайдын яамаар дамжуулан Герман Улсын тал манай улсын холбогдох удирдлагуудтай харилцсаар байжээ. Архивийн баримтад тэмдэглэснээр 1931 оны VI сарын 10-ны өдрийн 2 цагт Москва дахь манай улсын Элчин сайдын яаманд Герман Улсын Элчин яамны атташе фон Гервад, орчуулагч Дамров нар хүрэлцэн ирснийг элчин сайдын яамны ажилтан Чимиддаваа хүлээн авч орчуулагчаар дамжуулан БНМАУ дахь герман иргэдийн орхисон хөрөнгө, Германд суралцаж байсан сурагчдын төлбөрийн дутууг гүйцээх зэрэг олон асуудлаар ярилцсан байжээ.¹⁷²

Мөн энэ үед БНМАУ-ын хүсэлтийн дагуу Германы монопольт кампани “Востваг” (*West-Osteuropäische Warenaustausch Aktien Gesellschaft*) -ын гуравдагч орноос бараа, бүтээгдэхүүн импортлох, мөн тэдгээр орнуудад түүхий эд экспортлон гаргах эрхийг өргөтгөсөн байна. “Востваг” кампаны манай улсад нийлүүлж байсан бараа, бүтээгдэхүүний тоо хэмжээ Хятад дахь иргэний дайны үйл явцад хил хаагдсан зэргээс шалтгаалан эрс өсөх хандлагатай болжээ.

“Востваг”-аар дамжуулан гуравдагч орнуудаас экспортлосон бараа бүтээгдэхүүний тоо хэмжээ 1929 онд 1, 9 сая төгрөг, 1931 онд 3, 4 сая төгрөг, 1933 онд 7, 6 сая төгрөг, 1937 онд 9, 6 сая төгрөг болсон бол 1937 онд Монголоос мөөг, хунчир, бугын ясан эвэр зэрэг 2, 6 сая төгрөгийн түүхий эдийг гадаадад экспортлон гаргасан байна.¹⁷³

Өөрөөр хэлбэл “Востваг”-ын манай улсын экспортод эзлэх хувийн жин 1929 онд 20%, 1931 онд 6, 7%-ийг эзлэж байсан нь тоо хэмжээ буурсан мэт боловч ерөнхий үнийн дүнгээрээ өссөн байна.¹⁷⁴

¹⁷² МУ-ын ГХЯ-ны Төв Архив, Фонд № 6, хадгаламжийн нэгж № 6, хуудас 35. “Востваг” (*West-Osteuropäische Warenaustausch Aktien Gesellschaft*) нь Монголд 1923 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулж байсан Германы монополь кампани. Монголоос гадна Азийн Хятад, Афганистан гэх мэт олон улсад өөрийн салбартай байжээ. 1939 он хүртэл манай улсад ЗХУ-д үйлдвэрлэдэггүй бараа бүтээгдэхүүнийг гуравдагч орноос гэрээгээр нийлүүлж байсан.

¹⁷³ Ч.Банзрагч, Монголын эд хэрэглэгчдийн хоршооны үүсэл, хөгжил (1921-1958), Түүхийн ШУ-ны дэд доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл, Улаанбаатар, 2001, 47-р тал.

¹⁷⁴ Мөн тэнд.

1935 оны I сарын 28-нд БНМАУ-ын Худалдаа ба Аж Үйлдвэрийн Харилцан Нэвтрэлцэх Холбооны яамны өмнөөс сайд Мэнд, нөгөө этгээдээс хувь нийлүүлсэн хоршигсдын “Востваг” хэмээх Герман Улсын баруун ба зүүн Европын улсын дотор бараа таварын худалдаа хийх пүүсийн өмнөөс, тус пүүсээс 27 оны XI сарын 3-ны өдөр олгосон итгэмжийн бичгийн ёсоор Ян Дайн нар, тус улсын худалдааны ашиг тусыг харгалзан 21 зүйл бүхий худалдааны гэрээг байгуулсан байна. Гэрээг монгол, орос хэлээр хоёр хувь үйлдэж харилцан зөвшөөрсний үндсэн дээр гарын үсэг зурж баталгаажуулсан байна.¹⁷⁵

Хоёр тал дараах нөхцлүүдийг гэрээнд тусгасан байна. Үүнд:

- *“Востваг” нь ЗХУ-ын үйлдвэрийн барааг үл оролцуулан бусад гадаадаас ирэх барааг цөм худалдан авах*
 - *БНМАУ-аас экспортлох түүхий эдийг худалдан борлуулах зардлыг тооцохын тулд “Востваг” нь Худалдаа, үйлдвэрийн яаманд 1 сая ам. долларыг урьдчилан төлөх.*
 - *Урьдчилан олгосон хөрөнгө ашигласан ба экспортын түүхий эдийг борлуулсны ашгаас Худалдаа, үйлдвэр яам болон “Востваг” нь хоорондоо харилцан хүү төлж байх.*
 - *Худалдааны тооцоог цаашид гэрээг байгуулсан мөн өдрийн ЗХУ-ын банканд дахь алтан рублийн ханшаар бодох.*
 - *Монголын тал түүхий эд нийлүүлэх явдлыг зогсоовол “Востваг” нь бараа бүтээгдэхүүн импортлохыг зогсоох санал тавих эрхтэй байх.*
 - *Импортын барааг баталгаатай тээвэрлэн ирүүлэх явдлыг “Востваг”-аас чанартай гүйцэтгэх, аливаа хариуцлагыг дангаар хүлээх.*
 - *Экспортын зүйлийг гүйцэтгэн өгөх боомтыг Алтанбулаг ба Замын-Үүдэд төвлөрүүлэх*
 - *Хоёр этгээдийн гэрээ нэг жилийн хугацаатай байх ба өөрчлөх санал гарахгүй бол цаашид сунгагдан хүчинтэй үргэлжилж байх.*
- гэх мэт олон асуудлыг тусгасан байна.¹⁷⁶

1935 оны I сарын 28, 29, 30-ны өдөр тус онд “Востваг”-аар дамжуулан гадаадаас захиалан ирүүлэх барааны тухай асуудлаар Худалдаа ба Аж үйлдвэрийн яамнаа тус пүүсийн төлөөлөгчдийг урин хуралдсан байна. Хуралд Худалдаа ба Аж үйлдвэр харилцан нэвтрэлцэх

¹⁷⁵ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6, Монгол-Германы харилцааны данс, хадгаламжийн нэгж 74, хуудасны дугаар 1.

¹⁷⁶ МУ-ын ГХЯ-ны Төв Архив. Фонд 6, Монгол-Германы харилцааны данс, хадгаламжийн нэгж 74, хуудасны дугаар 1-6

холбооны яамны Ерөөлсэнгэ, Төв Коопертивийн дарга Нанзад, мөн Цэрэндорж, Эрвис, Улсын худалдааны газрын дарга Равдан, мөн газрын Шагдар, Зарубин нар, "Востваг"-ын төлөөлөгч Брувис, К... (нэр нь уншигдамгүй болжээ Р. Т) нар оролцсон байна.¹⁷⁷

Дээрхи гэрээгээр Улсын эм бэлдмэлийн газрын захиалгын зүйлийг 1936 оны нэгдүгээр улирлын дотор багтаан, мөн Герман Улсын өргөн хэрэглээний бараа таварыг 1935 оны X сарын 1-ний дотор багтаан ирүүлэхээр заажээ.¹⁷⁸ 1935 оны VIII сарын 10-ны өдрийн Худалдаа ба Аж үйлдвэрийн яамны сайд Мэндийн гарын үсэгтэй № 711 тоот албан бичигт дурьдсанаар 1935 оны эхний хагас жилд "Востваг"-аар дамжуулан авсан хятад барааны үнэ 868 мянган алтан төгрөг болсон тухай дурьдсан байна.¹⁷⁹

Гэвч Хятадын иргэний дайн өргөжиж эдийн засгийн байдал нь тогтворгүйжсэнээр "Востваг"-аас манай улсад нийлүүлж байсан бараа, бүтээгдэхүүний үнэд зохих нөлөө үзүүлж байв. Үүний улмаас Худалдаа ба Үйлдвэрийн яам зарим барааг нийлүүлэхийг түр түтгэлзэх саналыг гаргаж байжээ.

1935 оны VI сарын 18-нд Худалдаа ба Үйлдвэрийн яамны орлогч сайд Гомбожаваас "Востваг"-ын салбарын эрхлэгч Я. Дайнад № 491 тоот албан бичиг явуулсан байна. Уг бичигт "... Хятад газартаа мөнгөний үнэ ханш тогтворгүй байдалд орсон учир хятад бараа нь үнэд оров хэмээн танай газраас мэдэгдэн ирснийг хянаад, манай захиалсан барааны дотроос хэдэн зүйлийн бараанаас бусдыг худалдан авахыг түр түтгэлзэж, хятадын зах зээлийн ханшын байдал бидэнд тохиромжтой сайн болохыг хүлээх нь зүйтэй хэмээн шийдвэрлэсэн"¹⁸⁰ тухай дурьдсан байна.

Мөн манай талд давын өмнө чисчүү, ташуур, гаансны мод, дүнсэн тамхи, тууз ба малгайн залаа, үндсэн аяга, сам шүүр зүйлийг хэвээр нийлүүлэх, харин угалзтай гөлөм, торго, ногоон сарьс, чулуугаар хийсэн эдлэл зэргийг зах зээлийн тогтворжих үед үнийг мэдэгдэн нийлүүлэх хүссэн байна. Үндэсний Түүхийн архивийн Фонд № 359 - Худалдаа, бэлтгэлийн яамны холбогдолтой баримтуудад 1935 оны V

¹⁷⁷ УТА. Фонд 359, данс-1, хадгаламжийн нэгж-78, хуудасны дугаар 6-8.

¹⁷⁸ Мөн тэнд, хуудасны дугаар 46.

¹⁷⁹ Мөн тэнд, хуудасны дугаар 50.

¹⁸⁰ Мөн тэнд, хуудасны дугаар 48.

сарын 15-ны № 70 тоот бичигт 2.833.28 мексик долларын, V сарын 27-ны № 87-д 35.791.70 мек. долларын гэх мэтээр “Востваг”-аар дамжуулж авчирсан бараа, бүтээгдэхүүний үнийн албан бланк хуудас олон байна.¹⁸¹

“Востваг” нь тухайн үед манай улсын хуурай цайны хэрэгцээг бүрэн хангаж зузаан, нимгэн хар цай, байхуу цай нийлүүлж байснаас гадна автомашин, түүний сэлбэг хэрэгсэл(100 000 төгрөгний), гутал, дурдан, бөс даавуу, хонь хяргах хайч, цагаан эсгий болон цагаан ширээсэн малгай, чулуун хөөрөг, цагаан чулуун соруул, будаг, төвд эм тан, хөгжмийг хүртэл нийлүүлж байжээ.¹⁸²

Иймээс “Востваг” нь БНМАУ-ын хэмжээнд шаардлагатай бараа, бүтээгдэхүүнийг ханган нийлүүлэх чухал үүргийг гүйцэтгэж байжээ. Үндэсний Төв Архивт байгаа зарим баримтаар бол 1935 онд 10.178.539 төгрөг 15 мөнгөний барааг авчруулсан гэж байгаа нь нарийн судалууштай тоо гэж үзэж байна. Харин экспортын хувьд “Востваг” нь 1935 онд дурьдсан хэмжээний түүхий эдийг гадаадад гаргахаар төлөвлөж байв.

Хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт № 2

№	Түүхий эдийн нэрс.	I улирал	II улирал	III улирал	IV улирал
1.	Намрын тарвага	150000	50000		900000
2.	Хаврын тарвага		50000	150000	
3.	Хэрэм	40000	30000	20000	10000
4.	Үнэг	5000	10000	5000	
5.	Хирс	8000	10000	7000	
6.	Чоно	3000	4000	3000	3000
7.	Элдэв ангийн үс		8000 рубль	7000	
8.	Мөөг	30 тонн			70 тонн
9.	Хунчир	70 тонн	20 тонн		110 тонн
10.	Эвэр	70 хос	50 хос		180 хос
11.	Утаат болор			5 тонн	10 тонн
12.	Өлөн гэдэс	80000 баглаа	100000 баглаа	100000 баглаа	220000 баглаа

¹⁸¹ УТА. Фонд 359, данс-1, хадгаламжийн нэгж-78, хуудасны дугаар 16-22.

¹⁸² УТА. Фонд 359, данс-1, хадгаламжийн нэгж-74, хуудасны дугаар 1-2.

1935 оны III сарын 6-ны өдөр Худалдаа ба Аж ахуйн яамнаас тус онд “Востваг”-тай байгуулсан гэрээний 8-р зүйлд заасны дагуу оны эхэн хагаст багтаан бод мал, ангийн үс, байгалын түүхий эдийг шилжүүлэн өгөх үнийн доод хэмжээг “Востваг”-т санал болгосон байна.

Үүнд:

Хүснэгт №3
(рублиэр)

№	Худалдах зүйлүүд	Үнийн доод хэмжээ
1.	Нямрын тарваганы арьс	97к
2.	Чюно	6р
3.	Үнэг	5р
4.	Хярс	1р 50к
5.	Хэрэм	32к
6.	Өлөн гэдэс	50к
7.	Мөөг (тонн)	520р
8.	Хунир	700р
9.	Бульн эвэр (хос)	56р
10.	Утааг болор (цэн)	4р
11.	Мөрь (толгой)	25р
12.	Тэмсэ	40р
13.	Мануул	1р80к
14.	Хүрнэ	1р80к
15.	Дорго	2р40к
16.	Туулай	20к
17.	Солонго	2р20к
18.	Шилүүс	20р
19.	Нхой	2р
20.	Зурам	3к
21.	Жиргээн	10к
22.	Агадрахай	2к
23.	Барс	24р
24.	Бөгвөөхай	4р80к
25.	Суусар	1р

Худалдаа ба Аж ахуйн яамнаас явуулсан энэхүү үнийн саналтай “Востваг”-ыг төлөөлж Крафт гэдэг хүн танилцаж гэрээ хийн гарын үсэг зурсан байна.¹⁸³ Эндээс үзвэл Германы “Востваг” кампани манай улсын гадаад худалдаанд томоохон байр суурыг эзэлж байжээ. Мөн

¹⁸³ УТА. Фонд 359, данс-1, хадгаламжийн нэгж-78, хуудасны дугаар 70.

тухайн үед Засгийн газар Аж үйлдвэрийн комбинатын боловсруулсан илэгээс 200 ширхэгийг туршилтын журмаар “Востваг”-аар дамжуулан гадаадад гаргаж байсан баримт байна.¹⁸⁴

“Востваг” кампани нь БНМАУ-д үйл ажиллагаагаа явуулах хугацаандаа Хятадын *Нанжоу-Юшань-Наньчан-Писян-Чужоу* чиглэлээр төмөр зам тавьж байсан Германы нэртэй томоохон кампани *Отто Вольф & Ко, Фенштейн, Оппель, Ферресталь, Фридрих Групп, Сталь Юнион экспорт Ко* зэрэг кампаниутай нягт харилцаатай ажиллаж байв.¹⁸⁵

1930-иад оны эхэн хагасаас Монгол-Германы хооронд худалдаа, эдийн засгийн салбарт тогтож байсан өргөн харилцаа үнэн хэрэгтээ тасалдсан боловч БНМАУ-ын холбогдох удирдлагуудын зүгээс Герман Улсын “Востваг” кампанитай өргөн хүрээнд нягт хамтран ажиллаж тус кампаны албан ёсны салбар Улаанбаатар хотод ажилласаар байжээ.

***Монгол-Германы харилцаа хурцадаж,
худалдаа эдийн засгийн харилцаа бүрмөсөн
тасарсан нь***

1930-иад оны сүүл үе болж ирэхэд олон улсын байдал нэн тогтворгүй боллоо. Үзэл суртлаар зааглагдсан шинэ хүчний төвүүд бий болж дайн эхлэх нь хэн бүхэнд ойлгомжтой болсон бөгөөд харин аль хүрээнд багтан орж сөрөн ирэх аюулыг хохирол багатай даван гарах вэ? гэдэг л асуудлын гол болов. Судлаач Д. Баярхүү “Евразийн геополитик: одоо, Олон улсын харилцаа: ирээдүй” хэмээх бүтээлдээ энэ үеийн шинээр бүрэлдсэн хүчний төвүүдийг дараах байдалтай тодорхойлон гаргажээ. Үүнд:

- а. Берлин-Ром-Токиогийн гурвалжин буюу Коминтерны эсрэг Пакт*
- б. Японы эсрэг СССР-Дундад Иргэн улсын холбоотны цэргийн харилцаа*
- с. Молотов-Риббэнтропын нууц хуйвалдаанаар бий болсон Дорнод Европ, Прибалтика, Бессарабийг дахин хуваах цэргийн хэлцэл*

¹⁸⁴ УТА. Фонд 359, данс-1, хадгаламжийн нэгж-78, хуудасны дугаар 14.

¹⁸⁵ Д. Уламбаяр, Монгол-Германы түрүү үеийн харилцаа, Олон улс судлал сэтгүүл, Улаанбаатар, 1 (2001), 89-р тал.

d. СССР-Японы Төвийг сахих тухай гэрээгээр бий болсон нөлөөний хүрээний хувиарлалт¹⁸⁶ зэргийг дурьдсан байна.

Ийнхүү Версалын эрин үеийн төгсгөл ойртсон байлаа. ЗХУ 1920-иад оны үеийн түүхэн ганцаардлаасаа гарч олон улсын тавцан товойн гарч ирсэн бөгөөд энэ тухайд судлаач Д. Баярхүү бичихдээ "... ЗСБНХУ-ын хувьд 30-аад он шийдвэрлэх ач холбогдолтой. Энэ орон 20-иод онд ганцаардлаас гарсан бол энэ үед дэлхийн хүчирхэг гүрэн болж, Европ бүү хэл дэлхийн үйл хэргийг түүний оролцоогүйгээр шийдвэрлэх боломжгүй нь харагдаж байв"¹⁸⁷ гэж дүгнэн бичсэн байдаг.

1938 оноос Герман Улсын гадаад бодлого түрэмгийлэлийн шинж чанартай болж Австри, Судетийг өөртөө нэгтгэж, 1938 оны IX сарын 29-ний Мюнхений хэлэлцээр-ээр Чехословакийг хэсэглэн хуваав. Мөн Алс Дорнодод Япон Улс дайн эхлүүлсэн зэргээс шалтгаалан БНМАУ-ын аюулгүй байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдал ЗСБНХУ-аас нягт хамааралтай болов. Энэ үүднээс 1936 оны III сарын 12-нд Монгол-Зөвлөлтийн удирдлагууд 10 жилийн хугацаатай харилцан туслалцах протоколд гарын үсэг зурсан байна.¹⁸⁸ Олон улсын харилцааны хурцдмал байдлыг дүгнэн шинжилж 1937 оны X сарын 22-26 хүртэл хуралдсан МАХН-ын Төв Хорооны 3-р Бүгд хурал дээр н. Чойбалсангийн илтгэлийг сонсоод гаргасан тогтоолын 1-р зүйлд "...Одоо бүх дэлхийн олон улсын байдал улмаар хурцдаж байгаа бөгөөд фашистын засагт Япон, Герман, Итали улсуудын холбоо нь бага буурай улсуудыг дайран довтлох ажлуудыг эмхлэж, тэдний тусгаар тогтносон байдлыг эвдэн устгаж өөрсдийн колони болгохыг эрмэлзэн бүхий"¹⁸⁹ гэж онцлон тэмдэглэжээ.

Олон улсын дээрхи түгшүүртэй цаг үед ч БНМАУ-д Германы "Востваг" кампани үйл ажиллагаа хэвийн хэмжээнд явуулсаар байжээ. 1938 оны VI сарын 7-ны өдөр Худалдаа ба Тээврийн яамны сайд Доржоос "Востваг"-ын удирдлагад № 914 тоот албан бичиг илгээн тус

¹⁸⁶ Д.Баярхүү, Евразийн геополитик: одоо, олон улсын харилцаа: ирээдүй, Улаанбаатар, 2002, 53-54-р тал.

¹⁸⁷ Д.Баярхүү, Монгол Улсын гадаад бодлого, олон улсын харилцааны түүхэн зарим асуудал, Улаанбаатар, 1996, 62-р тал.

¹⁸⁸ БНМАУ-ын гадаад харилцааны баримт, бичгүүдийн эмхтгэл (1921-1961), боть 1, Улаанбаатар, 1964, 288-р тал.

¹⁸⁹ МАХН, Их, бага хурал, Төв хорооны Бүгд хурлуудын тогтоол шийдвэр (1921-1939), боть 1, Улаанбаатар, 1956, 595-р тал.

камpany БНМАУ дахь экспорт, импорттой холбогдох бүх асуудлуудыг Хоршоодын Төв холбоонд хариуцуулан гүйцэтгэж байхаар шийдвэрлэсэн тул цаашид дурьдсан ёсоор үйл ажиллагаагаа зохицуулах тухай мэдэгдсэн байна.¹⁹⁰

Гэвч олон улсын байдал хурцдаж Герман Улсад фашист дэглэм тогтож хүчээ авсны улмаас БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1938 оны X сарын 24-ны өдрийн тогтоолыг үндэслэл болгон Сангийн яамны сайд Ю. Цэдэнбалын тушаалаар “Востваг” камpany БНМАУ-д явуулж байсан үйл ажиллагааг зогсоосон байна.¹⁹¹

Үүнтэй холбогдуулан Худалдаа ба Тээврийн яамны сайд Дорж, дэд сайд Баттөмөр нараас мөн өдөр № 1743 тоотой “Востваг”-ын БНМАУ дахь салбарын эрхлэгч ноён Дайнд албан ёсоор мэдэгдсэн байна. Уг албан бичигт дурьдахдаа:

“Сайд нарын Зөвлөлийн тушаалыг үндэс болгож тус Худалдаа тээврийн яам нь танай газар ангийн үс ба өлөн гэдэс тушаах явдлыг зогсоох тухай Хоршоодын холбоонд тушаалыг өгсөн болохыг танд мэдэгдэхийн гадна тус яамнаас танай газар лугаа байгуулсан гэрээ ба мөн танай газар ангийн үс ба өлөн гэдэс тушаах явдлуудыг хүчингүй болгосугай. Монголын байгууллагуудаас гуравдугаар орноос захиалсан импортын барааны гэрээ нь танай газраас гуравдугаар орны захиалтыг гүйцэтгэх хүртэл оны эцэс үзтэл хэвээр баймой. Манай харъяа байгууллагуудын ба танай газрын хооронд харилцаа, тооцооны тайланг энэ оны X сарын 15-ны байдлаар гаргаж тус Худалдаа тээврийн яамнаа ирүүлэхийг хүсмой.

Сайд Дорж
Дэд сайд Баттөмөр¹⁹²”

гэжээ.

Ийнхүү дээрхи шийдвэр гарснаар БНМАУ дахь Герман Улсын “Востваг” камpany үйл ажиллагаа зогсож Монгол-Германы албан бус харилцааны хүрээнд тогтож байсан өмнөх үеийн өргөн хэмжээний худалдаа, эдийн засгийн түншлэлээс үлдэж хоцорсон сүүлчийн төлөөлөл үгүй болов.

¹⁹⁰ УТА. Фонд № 359, данс-1, хадгаламжийн нэгж-128, хуудасны дугаар 1.

¹⁹¹ Мөн тэнд, хуудасны дугаар 3.

¹⁹² УТА. Фонд № 359, данс-1, хадгаламжийн нэгж-128, хуудасны дугаар 3.

Германы “Востваг” кампани БНМАУ-аас шахагдан гарснаар тус улсад хоёрдагч орноос нийлүүлж байсан бараа бүтээгдэхүүн зогсож түүхий эдийг дан ганц ЗХУ-д нийлүүлэх болов. Хэдийгээр дурьдан буй үед Монгол-Германы харилцаа гэж томъёолоход нэн ээдрээтэй түүхэн нөхцөл байдал хоёр орны хооронд үүсээд байсан боловч “Востваг” кампани нь БНМАУ-ыг Баруун Европтой холбон ажилласаар байсан юм.

Мөн дурьдан буй үед Монгол-Герман хоёр улсын хооронд албан ёсны төрийн харилцаа тогтож хөгжөөгүй боловч 1921 оны Үндэсний Ардчилсан хувьсгалын дараагаас эхлэн Монгол Улсыг төрийн хэмжээнд сонирхон үзэж худалдаа, эдийн засаг, соёл, боловсролын салбарт өргөн дэлгэр харилцаа тогтоож 1930-иад оны сүүлд олон улсын байдал тогтворгүйжсэн үед ч БНМАУ-тай зохих харилцаатай байсан Баруун Европын цорын ганц орон бол Герман Улс байжээ.

Эцэст нь тэмдэглэхэд Монгол-Германы албан бус харилцаа тасалдсан түүхэн учир шалтгааныг олон улсын харилцааны тэгш бус байдал, их гүрнүүдийн үзэл суртлын хуваагдлаас эрж хайх хэрэгтэй биз ээ. Эл асуудлыг сурвалжлан хайх нь манай улсын ХХ зууны түүхэн дэхь олон зангилаа асуудлыг тайлахад дөхөм болох буй за.

ХАВСРАЛТ

Монгол-Германы худалдаа, эдийн засгийн түүхэнд холбогдох он цагийн хэлхээс

1861. IX. 2. Германы Эзэнт Улсын Засгийн газар Манж Чин Улстай байгуулсан гэрээгээр Монголд өөрийн худалдааны эрх ашгийг нэн тааламжтай нөхцлөөр тогтоов.

1890. Хүрээнд Ази хувцас өмссөн герман иргэд худалдаа хийж эхлэжээ.

1900. Германы “Мендельсон & Ко” компани болон Европын бусад орнуудын хувь нийлүүлсэн “Монголор” алтны уурхай нээгдэв.

1904. Германы “Стукен” пүүс Монголд үйл ажиллагаагаа эхлэв.

1907. VIII Богд Жибзундамба хутагт Герман Улсаас 1 цилиндртэй, дотоод шаталтын хөдөлгүүртэй “Деймлер” хэмээх автомашиныг худалдан авчруулсанаар нь Монгол дахь анхны автомашин эзэмшигч болов.

1909. Бидерманы пүүс нээгдэв.

1912. "Монголор"-оос олборлосон 1 354 222 рублийн үнэ бүхий алтыг Хаант Оросоор дамжуулан Берлин, Амстердам хотуудад гаргаж худалдаж байжээ.

1912. Богд Хаант Монгол Улсын Засгийн газраас өөрийн улсын тусгаар тогтнолыг зарлан тунхагласнаа мэдэгдэж дэлхийн олон улсад гэрээ байгуулан худалдааны харилцаа тогтоох, найрамдлыг зузаатгах зорилгоор нот бичиг явуулсан ба энд Дэ^{*} Улс чухал байр суурийг эзэлж байсан нь эргэлзээгүй юм.

1913. Хаант Орос-Хятадын хооронд Монголын асуудлаар гаргасан тунхаг бичиг нь 1861 онд Манж Чин Улстай байгуулсан гэрээнд заасанчилан Германы Эзэнт Улсын Монгол дахь худалдааны эрх ашигт нөлөөлж байгаа эсэх талаар Германы Үндэсний Либерал намын удирдагч фон Бассерман Рейхстагт хандсан байна.

1913-1914. Ерөнхий сайд Намнансүрэн Хаант Оросод очих үедээ тус улс дахь Герман Улсын элчин сайдад харилцаа тогтоох асуудлаар дахин нот бичиг явуулсан боловч бодитой ямар нэгэн хариу авч чадсангүй.

1914. IV сар. Хятад дахь Германы бизнесийн салбарынхан дунд хятадын нэрээр өөрийн банкыг Хүрээнд нээх тухай асуудал яригдаж байгаа тухай Хаант Орос Улсын Сайд нарын танхимийн дарга Горемыкинээс Гадаад Хэргийн яамны сайд С. Д. Сазановт захидал илгээсэн мэдэгдэв.

1917. Сангийн яам анхны жижиг цахилгаан станцыг Герман Улсын Кода фирмээс Шанхай, Манжуураар дамжуулан худалдан авжээ.

1920. V.17. Герман Улсын худалдааны фирмийн ажлаар Латви улсын иргэн Гарри Мэрс Үдээр Улаанбаатар хотноо иржээ.

1921. IX. 14. Ардын Засгийн газраас *"Монгол Улсыг тусгаар тогтносон тухай гадаад олон улсуудад тунхагласан бичиг"*-ийг дэлхийн олон улс, гүрэнд зарлан илгээсэн байна.

1922. II сар. Цэргийн яамны тэргүүн сайд Д. Сүхбаатараас цэргийн дүрэмт хувцасны даавуу материал нийлүүлэх талаар Герман Улсын *"Юэн фунг Трединг & Ко"* пүүсийн төлөөлөгч Гуго Мандль, Луппе Герасимович Козумин нарт хандаж бичиг илгээв.

* Дэ –Энэ нь герман гэсэн хятад ханзны дуудлага юм.

1922. IV. 19. Герман Улсын “Юэн фунг Трединг & Ко” хэмээх пүүсийн удирдлага монгол газраас морь хиу худалдан авч тус улс дор (Германд) нэвтрүүлэн явуулбаас танай Засгийн газраас татгалзах эсэхийг хариу ирүүлмөй хэмээн № 236 тоотоор бичиг илгээв.

1922. IV. 09. “Юэн фунг Трединг & Ко” пүүс Хятадаас Хүрээнд авч ирэх хятад пиоз, янчаанаас гаалийн хураамж авах эсэх тухай асуудлаар Засгийн газарт ханджээ.

1922. V.12. Ардын Засгийн газрын “Хууль цаазыг зохиох тухай” 21-р тогтоолоор Европын улсуудын хууль, дүрмийг харгалзах шийдвэр гаргасан байна.

1922. Монгол Улсын тухайн үеийн эрдэмтэд, улс төрчид хамтран Австри, Германы Ваймарын Бүгд Найрамдах Улсын Үндсэн хуулийг монгол хэлнээ орчуулан барууны орнуудын эрх зүйн тогтолцоог баримжаалах болов.

1922. VIII сар. Москва дахь Германы элчин сайдын яамны төлөөлөгч, Бээжин дэх Германы элчин сайдын яамны худалдааны атташе, Дорнод Европыг судлах Германы нийгэмлэгийн нарийн бичгийн дарга нарын бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид Нийслэл Хүрээнд хүрэлцэн ирж худалдаа, эдийн засгийн хэлэлцээ хийв.

1922. VIII.16. Хаалганд сууж байсан АНУ-ын консул Самуэл Сокобин Төрийн нарийн бичгийн даргадаа бичсэн тайландаа Читад суугаа Германы консулын газрынхан Хүрээнд үргэлж ирж очиж, Монголчуудтай хэл амаа ололцон ойртож байгаа болон Германчууд Монголыг Хятадад хамаагүй тусгаар тогтносон улс хэмээн үзэж байгаа тухай дурьджээ.

1922. XI сар. Тяньжин дэхь Германы пүүсээс бараагаа авч Харилцан туслалцах хоршооны дэлгүүрийг нээхээр тогтжээ.

1923. Герман Улсын “Востваг” кампани Хаалган - Нийслэл Хүрээ хооронд 100 гаруй автомашинаар байнгын ачаа, тээврийн үйл ажиллагаа явуулж эхлэв.

1923. V. 6. Шанхайд уралдуулах морьд хоёр зууг худалдан авах зөвшөөрлийг “Юэн фунг Трединг & Ко” пүүсийн тэргүүлэгч Баронхорст болон эмч Рот нараас № 536 тоот бичгээр хүсэж мэдэгдэв.

1923. VII. 2. Монгол Улсын Гадаад Явдлын яамнаас № 567 тоотой сайд Б. Цэрэндорж “Юэн фунг Трединг & Ко” пүүст агт морь худалдан авах зөвшөөрөл олгов.

1923. VII. 24. Тусгай комиссын боловсруулан нийтэлсэн “Эдийн засгийн үндсэн бодлого” хэмээх бодлогын шинж чанартай бичгийг батлан гаргав.

1923. IX сар. Дундад Улсад суугаа Герман Улсын элчин сайдын зөвлөх Кибор Нийслэл хүрээнд албаны хэргээр хүрэлцэн ирэв.

1923. XII. 29. “Юэн фунг Трединг & Ко” пүүсийн ажилтан Редер бие хамгаалах бичгээ гээгдүүлсэн тул Тяньжин хот явах, буцах үнэмлэх бичиг олгож өгөхийг хүсэж Гадаад Явдлын яаманд № 78 тоот бичиг илгээв.

1924. VIII. 5. МАН-ын III Их Хурлын 2-р хуралдаан дээр Намын Төв хорооны гишүүн Элбэгдорж Ринчино Герман Улстай худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоох асуудлын тухай хөндсөн байдаг.

1924. XI. 3. Монгол Улсаас ЗХУ-д суух бүрэн эрхэт элчин сайд А. Данзанд Монгол Улсын Ерөнхий сайд Б.Цэрэндоржоос өгсөн удирдамжинд Герман Улстай харилцаа тогтоох явдлыг чухалчлах үүрэг өгчээ.

1924. XII. 27. Цэцэрлэг Мандалын аймгийн Заяын Бааюу хэмээх газар худалдаа хийж байсан Германы Симсани пүүсийн худалдаачин Александрт Цэцэрлэг Мандалын аймгийн төлөх өрийн тухай тус аймгийн яамнаас Гадаад Явдлын яаманд бичиг өргөв.

1925. IV сар. БНМАУ-ын Засгийн газрын ажилтан Даш Сампилон, инженер Хурлат нарыг Монголын худалдааны төлөөлөгчдөөр сонгон Герман Улсад явуулав.

1925. V сар. Берлин хотод “Монгол Улсын Худалдааны Төлөөлөгчийн газар” байгуулагдав.

1925. V сар. Унгарын харъяат Иосиф Глета Тяньжин хот дахь Герман Улсын “Кода” фирмээс станцад шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг станцын дарга Жанцансамбуугийн хамт явж 3500 янчаанаар худалдан авсан байна.

1925. VII сар. Даш Сампилон, Хурлат нар Герман улсын Гадаад Явдлын яамны холбогдох албан тушаалтнуудтай уулзаж ярилцав.

1925. VII. 19. Даш Сампилон Берлинээс Москва хот дахь элчин сайдын яамаараа дамжуулан Аж Ахуйн яаманд Монгол-Германы харилцаанд холбогдолтой зарим асуудлаар мэдэгдэх захидал илгээв. Герман Улстай худалдаа, эдийн засгийн олон салбарт харилцаа тогтоох тухай идэвхтэй яриа хэлэлцээ хийв.

1925. VIII. 30. Герман Улсын Засгийн газрын даалгавраар Берлины Их сургуулийн багш профессор Кюзенсис хэлмэрч Баурикийн хамт Монголд томилогдон ирэв.

1925. “Америк, Герман, Франц зэрэг орнуудад үйлдвэрлэсэн 1-1,5 тоннын, бага даацын 40 орчим марк, сэрийн 120 авто машинтайгаар Монгол тээх нэвтрүүлэх газар” анх байгуулагдав.

1925. XI. 27. Ардын Засгийн газрын 42-р хуралдаанаас гаргасан шийдвэр ёсоор 35 сурагчийг сонгон Герман, Франц Улсад явуулж дунд, лицейд, мөн тусгай мэргэжлийн ажилтан бэлтгэх зорилгоор төрөл бүрийн үйлдвэр, заводад дадлага хийлгэн суралцуулах” шийдвэр гаргав.

1926. I сар. Засгийн газрын Ерөнхий сайдын жинхэнэ орлогч сайд бөгөөд Аж ахуйн явдлын яамны сайд А. Амар, Бүх Цэргийн зөвлөлийн тэргүүлэгч бөгөөд Засгийн газрын эрхлэх товчооны гишүүн Жадамбаа нарын бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид Москва хотноо айлчлаж хоёр улсын худалдаа, эдийн засгийн харилцаанд холбогдох тулгамдсан зарим асуудлаар санал солилцож, зохих үр дүнд хүрч чадсан байна. ЗХУ-ын Гадаад хэргийн ардын комиссар Г. В. Чичеринд албан захидал хэлбэртэй гардуулсан БНМАУ-ын Засгийн газрын энэхүү албан ёсны саналыг ЗХУ-аас зөвшөөрөн хүлээж заасан болзлуудыг албан ёсоор харгалзан үзэхээ илэрхийлсэн байна.

1926. II.14 -17. Герман Улсын Вюртемберг дэхь “Карл Хендлэ & Санс” фирмээс тоосгон заводыг нээхэд шаардлагатай бүх техник, тоног төхөөрөмжийг худалдан авахаар тохиролцов.

1926. VII сар. Герман Улсын “Люфтганза” (Lufthansa) хэмээх нисэхийн хорооны инженер нисгэгч Ервин Шульц, Габриел Надеждин нар *Берлин-Москва-Улаанбаатар-Бээжин* гэсэн маршрут бүхий агаар зам шинжин үзэх ажлаар БНМАУ-д хүрэлцэн ирэв.

1926. Шатахуун хадгалах зориулалттай 14-15 тоннын багтаамж бүхий 230 ширхэг савыг Герман Улсаас худалдан авчирч тавьснаар Улаанбаатар хотод анхны шатахуун түгээгүүрийн станц байгуулагдав.

1926. Харилцан туслалцах хоршооны харъяанд фото ба гар зургийн тасаг байгуулагдан Германы мэргэжилтэн зураач Л. Синуэр сурталчилгааны асуудал хариуцан ажиллаж эхлэв.

1926. Герман Улсын шууд туслалцаатайгаар Цэмбэний заводыг байгуулсан ба сургагч мэргэжилтнээр инженер Берхер ажиллахаар болов.

1926. XI сар. МАХН-ын Намын Төв Хорооны дарга Ц. Дамбадорж, Намын Төв Хорооны Н. Жадамбаа нар 3 сарын хугацаатайгаар Герман, Франц, Итали орнуудаар явжээ.

1926. XII. 23. БНМАУ-ын Дотоод Явдлын яамны сайд А. Амараас Гадаад Явдлын яаманд № 1469 тоотой илгээсэн бичигт Герман Улстай эрүүлийг хамгаалах салбарт хамтран ажиллахаар төлөвлөн буй тухай өгүүлжээ.

* Герман Улсын “Люфтганза” (Lufthansa) хэмээх нисэхийн хороо нь Хятадтай байгуулсан гэрээ ёсоор Манжуур-Шанхайгийн чиглэлээр нислэг үйлдэж байсан ажээ.

1927. I сар. Цэмбэний заводын дутагдалтай байгаа тоног төхөөрөмжийг авчиргах ажлаар инженер сургагч Бехер ЗХУ-д хоёр сарын хугацаатай явжээ.

1927. Шанхай хот дахь Герман Улсын "Siemens" пүүсээс авахаар тохиролцож захиалсан машин техник, зургийн тор зэрэг хэрэгслүүдийг Монголд үйл ажиллагаагаа явуулж байсан Германы "Востваг" нэгдлээр дамжуулан хүлээн авав.

1927. Ардыг Гэгээрүүлэх яаманд номын санч хийж байсан байсан Зөвлөлтийн харъяат Курт Альферевич Кавельмахер нь Монгол хэвлэлийн хороонд шилжин ажиллаж эхлэв.

1927. VI. 28. Герман Улсын хөрөнгө оруулалттай Төмөр, модны үйлдвэрийн газар албан ёсоор ашиглалтанд орж үйл ажиллагаагаа явуулж эхлэв.

1927. VI. 1. Аж Ахуйн яам Герман Улсын иргэн Р. Мюллертэй жил тутам 5000 пүнтээс доошгүй эрдэнийн чулуу олборлох гэрээ байгуулав.

1928. БНМАУ-д урилгаар ажиллаж байсан уурхайн хэлтсийн ахлах мэргэжилтэн, инженер Ф. Вейске *"Гадаад Монголын эдийн засгийн нөхцлийн тухай"* илтгэл өгүүлэл бичиж хэвлүүлсэн нь Герман Улсын Гадаад явдлын яамны сонирхлыг ихэд татаж, өндөр үнэлэгдэв.

1928. V. 25. Ерөнхий сайд Б. Цэрэндоржийн дэмжлэгтэйгээр өдөр Герман Улсын Берлин хот дахь А.Е.Г фирмтэй гэрээ байгуулан 500 киловатт чадалтай дулааны цахилгаан станц, түүний сэлбэг хэрэгслийг 75000 ам. доллараар худалдан авахаар тохиролцов.

1928. V. 28. Цахилгаан Гэрлийн Ерөнхий хорооны инженер Хамир Эрист бүрмөсөн нутаг буцав.

1928. VIII сар. Засгийн газар Герман Улсаас цэмбэний үйлдвэрт зориулагдах нэхмэлийн төрөл бүрийн машины багаж, техник төхөөрөмжүүдийг 96896 марктай тэнцэхүйц төгрөгийг зарцуулан худалдан авав.

1928. VIII. 18. Герман Улсын Баронхорст пүүс Хан Хэнтий уулын аймгийн хошуудаас Шангайд уралдуулах 850 гаруй агт морьд худалдан авч хил гаргахаар төлөвлөж байгаа тухай өгүүлжээ.

1928. IX. 14. КИГХ-ны Улс төрийн нарийн бичгийн дарга нарын газраас Монголын асуудлаар гаргасан маш нууц тогтоолд: *"Монгол Ардын Хувьсгалт намын өнөөгийн удирдагчид нь хөдөлмөрчдийн эрх ашгийг хамгаалахаас улам бүр ухарч худалдааны капиталист талд орж, хөдөлмөрчин олон түмэн ба ядуучуудын аж байдлыг сайжруулах зорилтыг хангахгүй, Монголыг харийн капиталист гүрнүүдтэй ойртуулах хандлага гаргаж"* байгааг онцлон тэмдэглэв.

1928.Х. 23 - XII. 11. МАХН-ын VII их хурал хурлаар 1921 оноос гадаад харилцаандаа тууштай баримжаалсан олон талт худалдаа, эдийн засгийн бодлогыг эрс эсэргүүцэн няцааж БНМАУ ЗХУ-ын эдийн засгийн нөлөө ноёрхсон бүс болох үндэс бүрэлдэв.

1928. XI. 11. ГЯЯ дугаар № 1162 тоот албан бичгээр ЗХУ дахь БНМАУ-ын элчин сайдын яам, мөн Монгол Улс дахь ЗХУ-ын элчин сайдын яаманд тус тус хандаж Германаас авах станцыг Монголд саатуулахгүй ирүүлэх зөвшөөрөл олгохыг хүсэв.

1929. Тоосгон заводод ажиллах инженер К. Геринг Монголд хүрэлцэн иржээ.

1929. Герман Улсын харъяат барилгын инженер Дебель, Зөвлөлтийн инженер Барановски нарын зураг төслөөр Монгол хэвлэлийн хорооны байшинг өргөтгөн тоосгон байшин нэмэн барьж ашиглалтанд оруулсан байна.

1929. VI. 27. Монгол-Зөвлөлтийн харилцааны үндсэн асуудлыг тогтоосон гэрээнд хоёр тал гарын үсэг зурав.

1929. IX сар. Инженер К. Геринг зохих тохируулга, засварыг хийсний дараа Худалдаа ба Аж ахуйг яаманд Тоосгон заводыг албан ёсоор хүлээлгэн өгчээ.

1929. IX сар. Цэмбэний үйлдвэрт ажиллаж байсан инженер Бехер нутаг буцав.

1929. Герман, Их Британи, АНУ, Дани, Франц, Унгар, Польш, Итали зэрэг улсын 4000 иргэдийг албадан буцаажээ.

1929. Берлин хотод Монголын Консулын газрыг байгуулах хэлэлцээр явагдаж байсан байж тун болзошгүй юм.

1929-1930. Герман Улсын харъяат Берм Голст гэдэг худалдаачин хувиараа Монголд ирж адуу худалдан авч байв.

1930. Германаас авах станцыг холбогдох хэрэгслийн хамтаар Москва, Улан-Үд хотуудаар дамжуулан хүлээн авчээ.

1930. Инженер К. Геринг энэ онд 9 000 000 түүхий тоосго үйлдвэрлэн гаргахаар ажлын төлөвлөгөөндөө оруулсан байна.

1930. Германд суралцаж ирсэн Ц.Баатарсэнгэ, Лувсаннамжил нар нь Монголын анхны хэвлэлийн үндэсний мэргэжилтэн болж латин ба монгол үсэг өрөгч нарыг курсээр сургаж “Үндэсний эрх” сонинг латинаар өрөн

хэвлэж байв. Мен Б. Ишдорж багш Германаас буцаж ирснийхээ дараа Германд суралцаж байсан шавь С.Наваан-Юндэн, Б. Содном нарын хамт хэвлэлд бэлтгэх материалын хэл найруулагыг засах, монгол хэлнээ орчуулага хийх зэрэг ажлыг анхлан гүйцэтгэж байжээ.

1930. “Монгол Улсын хувь нийлүүлсэн Зам тээврийн ерөнхий хороо Монгол транс”-аас Герман улсын автомашин үйлдвэрлэлийн “Мерседес-Бенз” (Mercedes-Benz) компанитай хэлэлцэн тохиролцож, тус үйлдвэрийн автомашин Монгол орны нөхцөлд нийцэх эсэхийг шалган үзэж судлах комисс байгуулан ажиллахаар тогтсон байна. Энэ хүрээнд авто инженер Карл Швагерыг Германаас Монголд урин ирүүлж ажиллуулахаар тохиролцов.

1930. V.19. Дотоод Явдлын яамны сайд Х. Чойбалсангаас № 261 тоотойр ЗХУ дахь Элчин сайдын яамнаа албан бичиг явуулан Антон Вехерийг яаралтай ирүүлэх асуудлаар харилцав.

1929. V. 21. Герман Улсын харъяат Вилгельм Дорн Төмрийн заводтой гэрээ байгуулан сэлбэг, хэрэгсэл нийлүүлж байсан тухайгаа Засгийн газарт илгээсэн захидалдаа дурьджээ.

1930. VI сар. Монтёр Антон Вехер БНМАУ-д урилгаар ирж ажиллах болов.

1930. X сар. Алтанбулаг хотын архины заводод техник ангийн эрхлэгчийн албан тушаалыг Германы харъяат Кериг хаших болов.

1930.XII.12. БНМАУ-ын Засгийн газрын 41-р хуралдаанаас гаргасан тогтоолын 4-р зүйлд “гадаад худалдаанд онц эрх тогтоох тухай” заасан байна. Ингэснээр Герман Улсын монопольт кампани “Востваг”-аас бусад кампаниудын эрхийг хүчингүй болгож зогсоов.

1931. VII сар. Зөвшөөрөлгүй туршин нисэлт хийж байсан Герман Улсын “Европ ба Ази” нүүсийн хоёр онгоцыг Буйр нуурын орчим буудан унагаж нисгэгч Фридрих Кольбер, Иохан Ратье нарыг баривчлан хорьжээ.

1931. VIII сар. Герман Улсаас авчирсан станцын тохируулга, туршилтыг хийж дуусган ашиглалтад өгснөөр нийслэлчүүдийн нэрлэж заншсан “Дунд голын чийдэн хороо” ажиллаж эхлэв.

1931.XI сар. ЗХУ дахь БНМАУ-ын элчин сайдын яаманд Герман Улсын “Люфтганза” (Lufthansa)-аас Вольтер хэмээх хүн ирж БНМАУ-ын Засгийн газраас нутаг дэвсгэр дээгүүр нь дамжин өнгөрөх албан ёсны зөвшөөрөл олгохыг хүссэн байна.

1933. “Востваг”-аар дамжуулан гадаадаас авсан бараа, бүтээгдэхүүний үнийн дүн 7, 6 сая тегрөг болсон байна.

1935. I. 28. БНМАУ-ын талаас Худалдаа ба Аж Үйлдвэрийн Харилцан Нэвтрэлцэх Холбооны яамны сайд Мэнд, нөгөө этгээдээс хувь нийлүүлсэн хоршигсдын “Востваг” хэмээх Герман Улсын баруун ба зүүн Европын улсын дотор бараа таварын худалдаа хийх пүүсийн өмнөөс, тус пүүсээс 27 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр олгосон итгэмжийн бичгийн ёсоор Ян Дайн нар, тус улсын худалдааны ашиг тусыг харгалзан 21 зүйл бүхий худалдааны гэрээг байгуулсан байна.

1935. I. 28 - 30. “Востваг”-аар дамжуулан гадаадаас захиалан ирүүлэх барааны тухай асуудлаар Худалдаа ба Аж үйлдвэрийн яамнаа тус пүүсийн төлөөлөгчдийг урин хуралдсан байна.

1935. Үндэсний Төв Архивт байгаа зарим баримтаар бол “Востваг” нь тус онд 10.178. 539 төгрөг 15 мөнгөний барааг авчирсан гэж байгаа нь нарийн судалууштай тоо юм.

1935. III. 6. Худалдаа ба Аж ахуйн яамнаас тус онд “Востваг”-тай байгуулсан гэрээний 8-р зүйлд заасны дагуу оны эхэн хагаст багтаан бод мал, ангийн үс, байгалын түүхий эдийг шилжүүлэн өгөх үнийн доод хэмжээг “Востваг”-т санал болгосон байна.

1935. VI. 18. Хятад дахь иргэний дайн өргөжиж эдийн засгийн байдал нь тогтворгүйжсэнээр “Востваг”-аас манай улсад нийлүүлж байсан бараа, бүтээгдэхүүний үнэд зохих нөлөө үзүүлж байв. Иймд Худалдаа ба Үйлдвэрийн яамны орлогч сайд Гомбожаваас “Востваг”-ын салбарын эрхлэгч Дайнад № 491 тоот албан бичиг явуулж зарим барааг нийлүүлэхийг түр түгэлзэх саналтай байгаагаа мэдэгдэв.

1936. III.12. Монгол-Зөвлөлтийн удирдлагууд арван жилийн хугацаатай харилцан туслалцах протоколд гарын үсэг зурчээ.

1937. “Востваг”-аар дамжуулан гадаадаас авсан бараа, бүтээгдэхүүний үнийн дүн 9, 6 сая төгрөг хүрчээ.

1938. VI. 7. Худалдаа ба Тээврийн яамны сайд Доржоос “Востваг”-ын удирдлагад № 914 тоот албан бичиг илгээн тус кампаны БНМАУ дахь экспорт, импорттой холбогдох бүх асуудлуудыг Хоршоодын Төв холбоонд хариуцуулан гүйцэтгэж байхаар шийдвэрлэсэн тул цаашид дурьдсан ёсоор үйл ажиллагаагаа зохицуулах тухай мэдэгдсэн байна.

1938. X. 24. Олон улсын байдал хурцдаж Герман Улсад фашист дэглэм тогтож хүчээ авсны улмаас БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоолыг үндэслэл болгон Сангийн яамны сайд Ю.Цэдэнбалын тушаалаар “Востваг” кампаны БНМАУ-д явуулж байсан үйл ажиллагааг зогсоов.

№	Монгол Улсад урилгаар ирж ажилласан герман сургагч, мэргэжилтнүүдийн нэрс*	Ажиллаж байсан салбарууд	Тайлбар
1.	инженер Хамир Эрист	Цахилгаан Гэрлийн Ерөнхий хороонд	1928 оны V сарын эцэс хүртэл Монгол Улсад ажиллажээ.
2.	монтёр Антон Вехер	Цахилгаан Гэрлийн Ерөнхий хороонд	1930 оны VI сард Монгол улсад ирж ажилласан. ЦГЕХороонд Герман улсаас худалдан нийлүүлсэн станцыг угсран тавих ажлыг гүйцэтгэжээ.
3.	инженер Карл Шварце	Төмөр, модны үйлдвэрийн газарт	
4.	мастер Альфонс Бейдлик	Төмөр, модны үйлдвэрийн газарт	
5.	инженер К. Херинг	Тоосгон заводод	Швейцарын коммунист намын санал болгосны дагуу Монголд ирж ажиллаж байв.
6.	инженер Дебель	Барилгын салбарт	Монгол хэвлэлийн хорооны байшинг барих ажлыг хариуцаж байв.
7.	Монгол хэвлэлийн хорооны ажилтан Курт Альфредович Кавельмахер	Монгол хэвлэлийн хороонд	К. А. Кавельмахер нь Монголын хэвлэлийн салбарын тулгын чулууг тавилцаж их зүйл хийсэн гавьяатай хүн байжээ.
8.	инженер Бартор	Монгол хэвлэлийн хороонд	1928 оны V сарын эцэсээр Монголд ирж ажилласан.
9.	инженер Ф. Вейске	Уул, уурхайн хэлтсийн ахлах мэргэжилтэн	1928 онд "Гадаад Монголын эдийн засгийн нөхцөл"-ийн талаар ГЯЯ-ндаа тайлан илтгэл бичиж өндөр үнэлэлт авч байв.
10.	геологич Р. Мюллер	Уул, уурхайн салбарт	Аж Ахуйн яамтай гэрээ хийж эрдэнийн чулуу олборлож байв.
11.	Вильгельм Дорн	Авто техникийн салбарт	Манай Улсын албан газруудад гэрээгээр техник, тоног төхөөрөмж нийлүүлж байв.
12.	авто инженер Карл Швагер	"Монгол транс"-ын Ерөнхий хороонд	"Мерседес-Бенз" кампанитай хийсэн хэлэлцээрийн дагуу 1930 оны X сарын эцсээр Монголд ирсэн.
13.	авто инженер Кречман	"Монгол транс"-ын Ерөнхий хороонд	
14.	инженер фон Дегион Монтеток	"Монгол транс"-ын Ерөнхий хороонд	
15.	инженер Берхер	Цэмбэний заводад	1929 оны IX сар хүртэл тус заводод үр бүтээлтэй ажиллаж байв.
16.	техник ангийн эрхлэгч Кериг	Алтанбулагын архины заводад	1930 оны X сараас 1933 оны V сар хүртэл ажиллаж байв.
17.	мэргэжилтэн зураач Л. Синүэр	Фото ба гар зургийн тасагт	1926 оноос эхлэн Харилцан туслалцах хоршооны харьяанд ажиллаж байжээ.

* Дээр дурьдсан мэргэжилтнүүдээс гадна инженер Линбюломбод, сургагч Мондойдон, Торнтен, Н.Г.Россилио, Хандоберг, Альберта, Хицер нарын хүмүүс Монголд ирж ажиллаж байв.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЛАВЛАГАА

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНАГУ	Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улс
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
БХК(б)Н	Бүх Холбоотны Коммунист /большевикуудын/ Нам
БНХУ	Бүгд Найрамдах Хятад Улс
ГХЯ	Гадаад Хэргийн яам
ГЯЯ	Гадаад Явдлын яам
ДХГ	Дотоодыг Хамгаалах Газар
ДЯЯ	Дотоод Явдлын яам
ЗСБНХУ	Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс
ЗХУ	Зөвлөлт Холбоот Улс
КИГХ	Коммунист Интернационалын Гүйцэтгэх Хороо
МАН	Монгол Ардын Нам
МАХН	Монгол Ардын Хувьсгалт Нам
МУИС	Монгол Улсын Их Сургууль
МЭХХ	Монголын Эд Хэрэглэгчдийн Хоршоо
НТХ	Намын Төв Хороо
ОК(б)Н	Оросын Коммунист /большевикуудын/ Нам
ОХУ	Оросын Холбооны Улс
СнХК	Сонин Хэвлэлийн Комбинат
ТХХБТК	Төв Хорооны Хянан Байцаах Төв Комисс
УБХ	Улсын Бага Хурал
УХГ	Улсын Хэвлэлийн газар
УХХЭХ	Улсын Хэвлэлийн Хэрэг Эрхлэх Хороо
ХААЯЯ	Худалдаа, Аж Ахуйн Явдлын яам
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ШУА	Шинжлэх Ухааны Академи